



УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ,  
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН  
СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ  
2012-2015 он**

Улаанбаатар хот  
2016 он

# ГАРЧИГ

<b>I. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ .....</b>	<b>5</b>
1.1 ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ .....	5
1.2 ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ӨРХИЙН ТОО .....	7
1.3 ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН .....	10
1.4. НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛЭГ .....	12
<b>II. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЦАЛИН ХӨЛС.....</b>	<b>15</b>
2.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ .....	15
2.2 АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН.....	16
<b>III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ</b>	<b>23</b>
3.1 ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА .....	23
3.2 ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ЯДУУРАЛ.....	28
3.3. НИЙГМИЙН ДААТГАЛ.....	30
3.4. НИЙГМИЙН ХАЛАМЖ.....	32
3.5. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ .....	32
<b>IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД .....</b>	<b>35</b>
4.1. БОЛОВСРОЛ .....	35
4.2. СОЁЛ, УРЛАГ.....	40
4.3. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ.....	42
4.4. ЭРҮҮЛ МЭНД.....	43
4.5 ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ.....	48
<b>V. БАЙГАЛЬ ОРЧИН .....</b>	<b>51</b>
5.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САН.....	51
5.2. ЦАГ УУР.....	52
5.3. АГААРЫН БОХИРДОЛ .....	53
5.4. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ .....	54
<b>VI. ГЭМТ ХЭРЭГ .....</b>	<b>55</b>
<b>VII. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО .....</b>	<b>59</b>
7.1 ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ ӨСӨЛТ .....	59
7.2 ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ .....	59

<b>VIII. ҮНЭ, ХАНШНЫ БАЙДАЛ .....</b>	<b>67</b>
8.1 ИНФЛЯЦИ .....	67
8.2 МӨНГӨ, ЗЭЭЛ, ВАЛЮТЫН ХАНШ .....	70
<b>IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД .....</b>	<b>75</b>
9.1 МАЛ АЖ АХУЙН САЛБАР .....	75
9.2 АЖ ҮЙЛДВЭР .....	81
9.3 БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ .....	84
9.4 ТЭЭВЭР .....	86
9.6 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ .....	89
9.7 ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ .....	90
9.8 ХУДАЛДААНЫ САЛБАР .....	91
9.9 ХАРИЛЦАА ХОЛБОО .....	92
<b>X. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ .....</b>	<b>95</b>
10. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ .....	95
<b>XI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ХУДАЛДАА .....</b>	<b>97</b>
11.1 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ .....	97
11.2 ГАДААД ХУДАЛДАА .....	98
<b>XII. ТӨРИЙН САНХҮҮ .....</b>	<b>105</b>
12. ТӨРИЙН САНХҮҮ .....	105
<b>XIII. СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТРИЙН САН .....</b>	<b>109</b>
<b>ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ .....</b>	<b>111</b>
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>113</b>
1. ХҮН АМ, НИЙГМИЙН БАЙДАЛ .....	113
2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ .....	117



## I. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

### 1.1 ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ

Монгол Улсын хүн амын тоо 2015 оны эцсийн байдлаар 3057.8 мянга болж, өмнөх оныхоос 61.9 мянган хүнээр нэмэгдэж, жилийн дундаж өсөлт 2.06 хувь болжээ (Зураг 1.1). Хүн амын тоо өсч байгаа хэдий ч өсөлтийн хурд тогтвортой байсангүй. Хүн ам 2012 оныхоос 190.1 мянга буюу 6.6 хувь, 2013 оныхоос 127.5 мян.хүн буюу 4.3 хувиар өссөн байна.

Зураг 1.1. Монгол Улсын хүн амын тоо, өсөлтийн хувь, 2012-2015



Хүн амын өсөлтөд төрөлт, нас баралт, гадаад шилжих хөдөлгөөн гэсэн хүн ам зүйн үндсэн гурван үзүүлэлт шууд нөлөөлдөг. Аймаг, нийслэлийн хүн амын тооны өөрчлөлтөд хүн амын ердийн өсөлтөөс илүүтэй шилжих хөдөлгөөн нөлөөлж байна. Тухайлбал, Орхон аймгийн хүн амын өсөлт 6.68 хувь, Увс аймгийнх 6.56 хувь, Баян-Өлгий аймгийнх 5.29 хувь байна (Хүснэгт 1.1).

Хүснэгт 1.1. Монгол Улсын хүн ам, жилийн дундаж өсөлтийн хувь, хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр, 2015

Аймаг, нийслэлийн нэр	Хүн ам	Жилийн дундаж өсөлтийн хувь	Хүн амын нягтрал
<b>Бүгд</b>	<b>3 057 778</b>	<b>2.06</b>	<b>1.95</b>
<b>Баруун бүс</b>	<b>390 594</b>	<b>3.09</b>	<b>0.94</b>
Баян-Өлгий	100 189	5.29	2.19
Говь-Алтай	56 209	-0.93	0.40
Завхан	69 916	0.26	0.85
Увс	80 763	6.56	1.16
Ховд	83 517	2.50	1.10
<b>Хангайн бүс</b>	<b>577 252</b>	<b>1.26</b>	<b>1.50</b>
Архангай	92 059	-1.10	1.66
Баянхонгор	83 936	1.07	0.72
Булган	60 014	-0.79	1.23
Орхон	100 731	6.68	125.91
Өвөрхангай	112 353	-0.57	1.79
Хөвсгөл	128 159	1.68	1.27

## I. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

Хүснэгт 1.1-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэлийн нэр	Хүн ам	Жилийн дундаж өсөлтийн хувь	Хүн амын нягтрал
<b>Төвийн бүс</b>	<b>485 525</b>	<b>1.11</b>	<b>1.03</b>
Говьсүмбэр	16 522	2.89	3.00
Дархан-Уул	100 939	0.99	30.59
Дорноговь	65 267	2.29	0.60
Дундговь	44 429	0.18	0.59
Өмнөговь	61 655	3.29	0.37
Сэлэнгэ	106 292	0.08	2.58
Төв	90 421	0.35	1.22
Зүүн бүс	208 119	2.10	0.73
Дорнод	76 476	1.70	0.62
Сүхбаатар	59 034	2.81	0.72
Хэнтий	72 609	1.96	0.90
<b>Улаанбаатар</b>	<b>1 396 288</b>	<b>2.44</b>	<b>297.08</b>

Манай улс хүн амын нягтралаар дэлхийн бусад улс оронтой харьцуулахад хамгийн сийрэг суурьшилтай орнуудын тоонд ордог бөгөөд 2015 онд нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 2.0 хүн ногдож байхад дэлхийн дундаж 54 хүн байна.

Сүүлийн жилүүдэд нийслэл хот болон бусад томоохон хот, суурин газарт хүн ам олноор шилжин суурьших болсноор манай улсын хотжих үйл явц улам өргөжсөөр байна. Тухайлбал, нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүн буюу хүн амын нягтрал Улаанбаатар хотод 297.1 болж, 2012 оныхоос 35 хүн буюу (13.4 хувь), 2013 оныхоос 5 хүн (1.8 хувь), өмнөх оныхоос 7 хүн (2.4 хувь)-ээр нэмэгджээ.

Хүснэгт 1.2. Монгол Улсын хотын хүн ам, эзлэх хувь, аймаг, нийслэлээр, 2012, 2015

Аймаг, нийслэл	2012		2015	
	Хүн ам	Дүнд эзлэх хувь	Хүн ам	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>1 926 625</b>	<b>67.2</b>	<b>2 096 180</b>	<b>68.6</b>
<b>Баруун бүс</b>	<b>116 903</b>	<b>32.4</b>	<b>127 261</b>	<b>32.6</b>
Баян-Өлгий	33 332	36.8	35 828	35.8
Говь-Алтай	17 910	33.4	19 448	34.6
Завхан	14 772	22.9	16 051	23.0
Увс	25 225	34.2	27 908	34.6
Ховд	25 664	32.8	28 026	33.6
<b>Хангайн бүс</b>	<b>211 906</b>	<b>40.0</b>	<b>239 762</b>	<b>41.5</b>
Архангай	19 486	22.9	21 361	23.2
Баянхонгор	27 419	35.2	29 825	35.5
Булган	14 999	27.5	15 147	25.2
Орхон	25 298	27.3	35 230	35.0
Өвөрхангай	37 275	36.5	41 280	35.7
Хөвсгөл	87 429	74.3	96 919	75.6
<b>Төвийн бүс</b>	<b>204 797</b>	<b>43.9</b>	<b>244 800</b>	<b>50.4</b>
Говьсүмбэр	9 005	62.9	12 059	73.0
Дархан-Уул	78 054	79.7	83 421	82.6



## I. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

Хүснэгт 1.2-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	2012		2015	
	Хүн ам	Дүнд эзлэх хувь	Хүн ам	Дүнд эзлэх хувь
Дорноговь	36 599	59.7	40 665	62.3
Дундговь	9 191	24.3	14 434	32.5
Өмнөговь	23 834	36.5	21 119	34.3
Сэлэнгэ	31 847	30.8	56 839	53.5
Төв	16 267	18.7	16 263	18.0
<b>Зүүн бүс</b>	<b>74 889</b>	<b>39.1</b>	<b>88 069</b>	<b>42.3</b>
Дорнод	39 820	55.9	43 506	56.9
Сүхбаатар	14 290	27.1	19 827	33.6
Хэнтий	20 779	30.8	24 736	34.1
<b>Улаанбаатар</b>	<b>1 318 130</b>	<b>100.0</b>	<b>1 396 288</b>	<b>100.0</b>

Аймгуудын хүн амын нягтрал газар нутгийн хэмжээ, хүн амын тооноос шалтгаалан харилцан адилгүй байна. Орхон аймагт нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 126 хүн, Дархан-Уул аймагт 31 хүн, Говьсүмбэр, Сэлэнгэ, Баян-Өлгий, Увс, Ховд, Архангай, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Төв аймагт 1-3 хүн, бусад аймагт нэг хүрэхгүй хүн ногдож байна.

Монгол Улсын хүн амын 68.6 хувь буюу 2096.2 мянган хүн 2015 оны байдлаар хот, тосгонд амьдарч байгаа нь 2012 оныхоос 169.6 мянган хүн буюу 8.8 хувиар өсчээ. Аймгийн хувьд хотын хүн амын эзлэх хувь 2015 оны байдлаар Хөвсгөл, Орхон, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Дорнод аймгийн хүн амын талаас илүү хувь нь хот, тосгонд оршин сууж байна. Харин Завхан, Архангай, Булган, Төв аймагт хүн амын 70-аас дээш хувь нь хөдөөд амьдарч байна (Хүснэгт 1.2).

### 1.2 ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ӨРХИЙН ТОО

Хүн амын нас, хүйсийн бүтэц нь тухайн нас, хүйсийн бүлэг дэх хүн амын тархалтыг харуулах бөгөөд хүн амын өсөлт, өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүд болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөс хамаарахаас гадна эргээд эдгээр бүрэлдэхүүн хэсгүүддээ нөлөө үзүүлж байдаг чухал үзүүлэлт юм.


Сүүлийн жилүүдэд нийт хүн амын дунд 15-64 насны хүн амын эзлэх хувийн жин нэмэгдэж, 2015 оны эцсийн байдлаар 66.6 хувийг 15-64 насны хүн ам, 29.6 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 3.8 хувийг 65 ба түүнээс дээш насныхан эзэлж байна. Үүнийг 2012 оныхтой харьцуулахад 15 хүртэлх насны хүүхэд 2.6 пунктээр өсч, 15-64 насны хүн амын эзлэх хувь 2.6 пунктээр буурч, 65 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь ижил түвшинд байна.

Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эерэгээр нөлөөлдөг. Хүн ам зүйн цонх нээгдсэн үед хүүхэд, залуучуудын боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт хугацааны бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлсэн нөхцөлд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц байх нөхцөл бүрэлдэнэ гэж ойлгож болох юм.

Хүн амын нас, хүйсийн суваргаас харахад, дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн ам идэрших хандлагатай байгааг харуулж байна. Харин 10-20 насны хүн амын хэсгээр нарийссан байгаа нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин мэдэгдэхүйц буурч байсныг харуулж байна. Төрөлт 2006 оноос эхлэн нэмэгдэж 2012 онд 1985 оны түвшинд хүрсэн нь суваргаас харагдаж байна. Түүнчлэн 20-34 насны хүн ам харьцангуй их, ерөнхийдөө хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж хүн ам зүйн цонхны үе үргэлжлэхийг суварга харуулж байна.


## I. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

### Зураг 1.2. Хүн амын нас, хүйсийн суварга, 2015



Монгол Улсын хүн амын 49.2 хувийг эрэгтэйчүүд, 50.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж, хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэй ногдох эрэгтэйчүүдийн тоо 96.7 байна.

### Зураг 1.3. Хүн амын хүйсийн харьцаа, 2012, 2015



Хүн ам зүйн ачаалал, өөрөөр хэлбэл эдийн засгийн идэвхтэй (олон улсын жишгээр 15-64 насны) 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн (0-14, 65, түүнээс дээш насны хүн ам) тоо нь хүн амын нийгэм, эдийн засгийн чухал үзүүлэлт юм. Хүн ам зүйн ачаалал 2015 онд 51.3 болж, өмнөх жилүүдээс өссөн нь сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдсэнтэй холбоотой (Хүснэгт 1.3).



**Хүснэгт 1.3. Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд, 2012-2015**

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015
Хүн ам зүйн ачаалал-Бүгд	46.3	47.0	47.2	51.3
Хүүхэд	40.5	41.2	41.3	45.5
Хөгшид	5.8	5.8	5.8	5.8
Хүн амын голч нас	25.3	25.4	25.4	25.4
Хүйсийн харьцаа	94.5	94.8	95.9	96.7

Хүн амыг насны бүтцийнх нь хувьд таллан хувааж байгаа насыг голч нас харуулах бөгөөд энэ үзүүлэлт 2012 онд 25.3 байсан бол 2015 онд 25.4 болж, 0.1 насаар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2015 онд 859.1 мянган өрх, түүний 67.4 хувь нь хотод, 32.6 хувь нь хөдөөд байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 3.5 хүн ногдож байна. Аймаг, нийслэлийн хувьд нэг өрхөд ногдох хүний тоогоор Баян-Өлгий, Ховд, Увс аймаг болон Улаанбаатар хот, бусад аймаг, улсын дунджаас өндөр буюу 3.6-4.3 хүн ногдож байна.

**Хүснэгт 1.4. Өрхийн тоо болон нэг өрхөд ногдох хүн, бүс, аймаг, нийслэлээр, 2015**


Аймаг, нийслэл	Бүгд	Үүнээс:		Нэг өрхөд ногдох хүний тоо
		Хот	Хөдөө	
<b>Бүгд</b>	<b>859 106</b>	<b>579 305</b>	<b>279 801</b>	<b>3.5</b>
Баруун бүс	102 767	34 315	68 452	3.8
Баян-Өлгий	23 082	8 214	14 868	4.3
Говь-Алтай	16 072	5 747	10 325	3.5
Завхан	20 695	4 849	15 846	3.4
Увс	21 212	7 665	13 547	3.8
Ховд	21 706	7 840	13 866	3.8
<b>Хангайн бүс</b>	<b>169 327</b>	<b>69 361</b>	<b>99 966</b>	<b>3.4</b>
Архангай	26 727	5 770	20 957	3.4
Баянхонгор	24 821	8 922	15 899	3.4
Булган	18 479	4 482	13 997	3.2
Орхон	28 089	26 929	1 160	3.6
Өвөрхангай	33 438	10 466	22 972	3.4
Хөвсгөл	37 773	12 792	24 981	3.4
<b>Төвийн бүс</b>	<b>146 942</b>	<b>72 258</b>	<b>74 684</b>	<b>3.3</b>
Говьсүмбэр	5 017	3 632	1 385	3.3
Дархан-Уул	29 971	25 216	4 755	3.4
Дорноговь	20 018	12 045	7 973	3.3
Дундговь	13 900	4 486	9 414	3.2
Өмнөговь	20 098	6 916	13 182	3.1
Сэлэнгэ	29 316	14 998	14 318	3.6
Төв	28 622	4 965	23 657	3.2
<b>Зүүн бүс</b>	<b>63 651</b>	<b>26 952</b>	<b>36 699</b>	<b>3.3</b>
Дорнод	22 916	12 765	10151	3.3
Сүхбаатар	17 251	6 030	11 221	3.4
Хэнтий	23 484	8 157	15 327	3.1
<b>Улаанбаатар</b>	<b>376 419</b>	<b>376 419</b>	<b>-</b>	<b>3.7</b>

## I. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

### 1.3 ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

Төрөлтийн түвшин 2006 оноос өсч, 1000 хүнд ногдох төрөлт 2012 онд 26.0, 2014 онд 28.0 хүрч байснаа 2015 онд 27.1 болсон нь өмнөх оныхоос 0.9 пунктээр буурчээ. Төрсөн хүүхэд 2015 онд 82.1 мянгад хүрч, 2012 оныхоос 11.2 хувиар, 2013 оныхоос 2.9 хувиар өсч, 2014 оныхоос 0.9 хувиар буурсан байна. Манай улсын хүн амын төрөлтийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 105 хөвгүүн ногдож байна. Төрөлтийн нийлбэр коэффициент 2012 онд 2.7 байсан бол 2015 онд 3.0 болж нэмэгдлээ.

**Зураг 1.4. Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт 1000 хүнд ногдохоор, 2012-2015**



Төрөлтийн дундаж түвшин 2012-2015 онд 2008-2011 оны дунджаас дээгүүр байна.

**Хүснэгт 1.5. Нас баралт (1000 хүнд ногдох), нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөд ногдох), аймаг, нийслэлээр, 2012, 2015**

Аймаг, нийслэл	Нас баралт		Нялхсын эндэгдэл	
	2012	2015	2012	2015
<b>Бүгд</b>	<b>6.3</b>	<b>5.8</b>	<b>15.5</b>	<b>15.0</b>
Баруун бүс	4.0	6.0	20.7	21.6
Баян-Өлгий	2.8	5.7	27.1	24.7
Говь-Алтай	4.1	5.5	20.6	13.1
Завхан	5.2	6.7	20.7	25.7
Увс	4.5	6.3	15.1	20.4
Ховд	3.9	5.8	19.8	20.7
<b>Хангайн бүс</b>	<b>5.2</b>	<b>6.5</b>	<b>19.4</b>	<b>15.8</b>
Архангай	5.6	7.1	17.8	14.1
Баянхонгор	4.9	6.3	13.9	14.0
Булган	4.7	6.1	14.3	17.1
Орхон	4.3	6.1	16.0	12.1
Өвөрхангай	5.7	6.5	22.8	14.1
Хөвсгөл	5.4	6.7	26.2	22.3
<b>Төвийн бүс</b>	<b>4.6</b>	<b>6.3</b>	<b>10.0</b>	<b>11.2</b>
Говьсүмбэр	4.6	5.7	11.7	13.4
Дархан-Уул	4.3	6.0	8.7	10.1
Дорноговь	4.3	5.6	14.4	12.2


Хүснэгт 1.5-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Нас баралт		Нялхсын эндэгдэл	
	2012	2015	2012	2015
Дундговь	5.4	7.2	9.5	7.0
Өмнөговь	3.7	6.2	14.8	16.6
Сэлэнгэ	4.5	6.4	5.6	8.1
<b>Төв</b>	<b>5.8</b>	<b>6.8</b>	<b>9.8</b>	<b>13.3</b>
Зүүн бүс	5.2	6.3	16.3	13.8
Дорнод	5.2	6.1	14.4	7.6
Сүхбаатар	5.4	6.3	20.4	18.6
Хэнтий	5.0	6.6	15.1	17.1
<b>Улаанбаатар</b>	<b>8.0</b>	<b>5.3</b>	<b>14.2</b>	<b>14.3</b>

Нас баралтын ерөнхий коэффициент 2006 оноос тогтмол буурч, 2012 онд 6.3-аас 2014 онд 5.6 болж буурч, 2015 онд 0.2 пунктээр өсч, 5.8 болсон байна. Нялхсын эндэгдэл 2012-2013 онд буурч, 2015 онд 15.0 болж, өмнөх оныхоос 0.1 пунктээр буурсан байна.

Нийт 17.6 мянган хос 2015 онд гэрлэлтээ бүртгүүлж, 3.9 мянган гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 2.2 мянган хүүхэд үрчлүүлсэн байна. Гэрлэлт өмнөх оныхоос 1.5 хувь, гэр бүл цуцлалт 3.3 хувиар, үрчлүүлсэн хүүхэд 25.9 хувиар өсөв. Түүнчлэн 18, түүнээс дээш насны 1000 хүнд ногдох гэрлэлт 2012 онд 6.8 байснаа 2015 онд өсч 9.0 болж өмнөх оныхоос 0.1 пунктээр илүү, гэр бүл цуцлалт 2012 онд 1.3-аас аажмаар өсч, 2015 онд 2.0 болж, өмнөх оныхоос 0.1 пунктээр их байна. Хүүхэд үрчлэлт 2012-2014 онд харьцангуй тогтвортой буюу 0.6, 2015 онд 0.7 болж, өмнөх оныхоос 0.1 пунктээр өссөн байна.

Зураг 1.5. Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт, 1000 хүнд ногдохоор, 2012-2015



\* 18, түүнээс дээш насны 1000 хүнд ногдохоор тооцсон.

## I. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

### 1.4. НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛЭГ

#### Өнчин хүүхэд

Улсын хэмжээгээр өнчин хүүхэд 2015 онд 37.9 мянга болж, 2012 оныхоос 6.2 хувь, 2013 оныхоос 4.1 хувь, 2014 оныхоос 2.9 хувиар буурчээ. Нийт өнчин хүүхдийн 3.9 мянга буюу 10.2 хувь нь бүтэн өнчин, 34.1 мянга буюу 89.8 хувь нь хагас өнчин хүүхэд байна (Зураг 1.6).


Зураг 1.6. Бүтэн болон хагас өнчин хүүхэд, 2012-2015



Нийт өнчин хүүхдийн 3.9 мянга буюу 10.3 хувь нь 0-4 насны, 8.3 мянга буюу 21.9 хувь нь 5-9 насны, 12.6 мянга буюу 33.3 хувь нь 10-14, 13.1 мянга буюу 34.6 хувь нь 15-17 насны хүүхдүүд байна.

Улсын хэмжээнд 2015 онд өрх толгойлсон гэр бүлгүй хүмүүсийн 79.1 хувийг өрх толгойлсон эмэгтэйчүүд, 20.9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүд 2015 онд 78.6 мянга болж 2012 оныхоос 3.6 хувь, 2013 оныхоос 3.8 хувь, 2014 оныхоос 2.8 хувиар буурч, 2012-2015 оны дунжийг 2008-2011 оныхтой харьцуулахад 0.7 хувиар өсчээ. Харин өрх толгойлсон эрэгтэйчүүд 2015 онд 20.7 мянга болж, 2012 оныхоос 31.2 хувь, 2013 оныхоос 18.6 хувь, 2014 оныхоос 7.3 хувиар буурсан байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 15.7 хувь нь Баруун, 27.8 хувь нь Хангай, 20.3 хувь нь Төв, 9.4 хувь нь Зүүн бүсэд, 26.8 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Зураг 1.7. Өрх толгойлсон эх, эцэг, 2012-2015



Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 45.1 мянга буюу 57.3 хувь нь 3 хүртэл, 26.9 мянга буюу 34.3 хувь нь 3-5, 6.6 мянга буюу 8.4 хувь нь 6, түүнээс дээш тооны ам бүлтэй байна. Мөн өрх толгойлсон эрэгтэйчүүд 20.7 мянга байгаагийн 13.5 мянга буюу 65.4 хувь нь 3 хүртэл, 5.6 мянга буюу 26.9 хувь нь 3-5, 1.6 мянга буюу 7.7 хувь нь 6, түүнээс дээш тооны ам бүлтэй байна.

**Хүснэгт 1.6. Арван найм хүртэлх насны хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг, эх, 2012-2015**

	2012*	2013	2014	2015
<b>Бүгд</b>	<b>46 134</b>	<b>48 158</b>	<b>48 404</b>	<b>47 716</b>
Эцэг	7 575	8 254	7 971	8 396
Эх	38 559	39 904	40 433	39 320

\* 16 хүртэлх насны хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг, эх

Арван найм хүртэлх насны хүүхэдтэй, гэр бүлгүй хүний тоо 2015 онд 47.7 мянга болж 2012 оныхоос 3.4 хувиар өсч, 2013 оныхоос 0.9 хувь, 2014 оныхоос 1.4 хувиар буурчээ. Арван найм хүртэлх насны хүүхэдтэй, гэр бүлгүй нийт хүний 82.4 хувийг эмэгтэйчүүд, 17.6 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

**Зураг 1.8. Олон ам бүлтэй өрх, 2012-2015**



\* 8, түүнээс дээш гишүүнтэй өрх

\* 16 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрх

Улсын хэмжээнд 6, түүнээс дээш гишүүнтэй өрх 2015 оны эцэст 81.0 мянга болж, 2013 оныхоос 21.4 хувь, 2014 оныхоос 17.0 хувиар өсчээ. 18 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрх 2015 онд 36.1 мянга болж, 2013 оныхоос 3.5 хувь, 2014 оныхоос 10.4 хувиар буурсан байна. (Зураг 1.8)

**Хүснэгт 1.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, бэрхшээлийн төрлөөр, 2012-2015**

Он	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрөл			
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Төрөлхийн		Олдмол	
			Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
2012	92 263	100.0	30 346	32.9	61 917	67.1
2013	96 325	100.0	34 239	35.5	62 086	64.5
2014	99 573	100.0	35 681	35.8	63 892	64.2
2015	101 730	100.0	41 550	40.8	60 180	59.2

## I. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2015 онд 101.7 мянга болж, нийт хүн амын 3.3 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2012 оныхоос 10.3 хувь, 2013 оныхоос 5.6 хувь, 2014 оныхоос 2.2 хувиар өсчээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрлөөр нь авч үзвэл 40.8 хувь нь төрөлхийн, 59.2 хувь нь олдмол, үүнээс 74.8 хувь нь ердийн өвчнөөс, 9.6 хувь нь ахуйн ослоос, 9.2 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөс, 3.8 хувь нь зам тээврийн ослоос, 2.6 хувь нь үйлдвэрийн ослоос шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

### Хүснэгт 1.8. Хөгжлийн бэрхшээлтэй 0-17 насны хүүхэд, бэрхшээлийн төрлөөр, 2012-2015

Он	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрөл			
			Төрөлхийн		Олдмол	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
2012	8 044	100.0	5 368	66.7	2 676	33.3
2013	10 869	100.0	7 122	65.5	3 747	34.5
2014	11 365	100.0	7 622	67.1	3 743	32.9
2015	10 407	100.0	7 528	72.3	2 879	27.7

\* 0-15 насны хүүхэд

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 2013 оныхоос 4.3 хувь, 2014 оныхоос 8.4 хувиар буурчээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эзлэх хувь өндөр байгаа бөгөөд өсөх хандлагатай байна.



## II. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЦАЛИН ХӨЛС

### 2.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Монгол Улсын нийт хүн амын 64.5 хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байгаагаас 55.0 хувь нь 15-34 насныхан, 31.4 хувь нь 35-49 насныхан, 13.6 хувийг 50-59 насныхан эзэлж байна.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2015 онд 56.9 хувь, улсын хэмжээнд 1152.2 мянган хүн ажил эрхэлж байгаагийн 28.5 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 15.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, тус бүр 7.7 хувь нь барилга, 7.7 хувь нь боловсрол, 7.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 6.3 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа болон 27.2 хувь нь эдийн засгийн бусад салбарт ажиллаж байна.

Ажилгүйдлийн түвшин нь ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулсан хувийг илэрхийлнэ.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд ажилгүйдлийн түвшин буурч байгаа боловч эдийн засгийн идэвх төдийлөн нэмэгдэхгүй байна. Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарт ажиллагчид 2008-2011 онд 4.2 хувиар нэмэгдэж байсан бол 2012-2015 оны дундаж ажиллагчид 2004-2007 оны дунджаас 7.3 хувиар өсчээ. Сүүлийн 4 жилд эдийн засгийн идэвхтэй хүн ам 7.1 хувиар нэмэгдсэн нь өмнөх 4 жилийн дундаж өсөлтөөс 2.6 пунктээр бага байна.

**Хүснэгт 2.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлт, 2012-2015**

	2008-2011 оны дундаж*	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							%
15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	1 801.0	1 812.1	1 937.1	1 941.6	2 022.9	1 928.4	107.1
Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо	1 120.3	1 151.1	1 198.3	1 206.6	1 243.9	1 200.0	107.1
Ажиллагчид	1 029.9	1 056.4	1 103.6	1 110.7	1 151.2	1 105.5	107.3
Ажилгүй иргэд	149.9	94.7	94.7	95.9	92.7	94.5	63.0
Ажиллах хүчний оролцооны түвшин (%)	63.6	63.5	61.9	62.1	61.5	62.3	-
Хөдөлмөр эрхлэлт (%)	57.3	58.3	57.0	57.2	56.9	57.3	-
Ажилгүйдлийн түвшин (%)	8.0	8.2	7.9	7.9	7.5	7.9	-

\* - 2009 он хүртэл аймаг, нийслэлийн засаг захиргааны нэгжээс мэдээлдэг "Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан"-гийн дүнгээр гаргаж байсан. Харин 2009 оноос хойш Үндэсний статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 01/68/94 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистик үзүүлэлтийг тооцох аргачлал"-ын дагуу "Ажиллах хүчний судалгаа"-ны дүнгээр тооцож гаргасан.

Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг харуулах гол үзүүлэлт болох ажиллах хүчний оролцооны түвшин 2012-2015 онд 62.3 хувь болж өмнөх 4 жилийн дунджаас 1.3 пунктээр буурч, харин хөдөлмөр эрхлэлтийн түвшин 57.3 хувь болж, 0.1 пунктээр өссөн байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) нь 15, түүнээс дээш насны хүн амын дотор эдийн засгийн идэвхтэй хүн ам (ЭЗИХА) хэдэн хувийг эзэлж буйг харуулдаг хэмжигдэхүүн бөгөөд энэ нь сүүлийн 4 жилд 15, түүнээс дээш насны хүн амын тоо ЭЗИХА-ын тооны өсөлттэй тэнцүү байсныг илэрхийлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин харьцангуй тогтвортой байгаа нь ажиллагчид нэмэгдэж байгаатай зэрэгцэн 15, түүнээс дээш насны хүн ам өсч байгаатай холбоотой байна.

## II. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЦАЛИН ХӨЛС

Ажиллах хүчний судалгааны 2015 оны дүнгээр улсын хэмжээнд 92.7 мянган ажилгүй иргэд байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажилгүй иргэд 2015 оны 12 дугаар сарын эцэст 32.8 мянга болсны 17.7 мянга нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1.1 хувийг магистр, доктор, 28.9 хувийг дипломын болон бакалаврын, 6.3 хувийг тусгай мэргэжлийн дунд, 6.5 хувийг техникийн болон мэргэжлийн, 47.3 хувийг бүрэн дунд, 9.9 хувийг суурь, бага боловсролтой болон боловсролгүй иргэд эзэлж, тэдгээрийн 61.3 хувь нь 15-34 насны залуучууд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэд 2008-2011 онд жилд дунджаар 40.9 мянга байсан бол 2012-2015 оны дунджаар 37.1 мянга болж буурсан байна.

**Хүснэгт 2.2. Хөдөлмөр эрхлэлтийн зарим үзүүлэлт, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж % 2008-2011 оны дундаж
Бүртгэлтэй ажилгүй иргэд /мян.хүн/	40.9	35.8	42.8	37.0	32.8	37.1	90.8
Шинээр бүртгүүлсэн иргэд /мян.хүн/	67.6	61.5	110.0	109.7	122.8	101.0	149.3
Ажилд зуучлагдан орсон иргэд /мян.хүн/	61.9	35.2	65.9	27.4	27.7	39.1	63.1
Ажил хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд /мян.хүн/	14.7	10.6	37.2	89.8	99.3	59.2	402.9

Эх үүсвэр: Хөдөлмөрийн яамны мэдээ

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2012-2015 онд жилд дунджаар ажилгүй 101.0 мян.иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 39.1 мян.иргэн ажилд зуучлагдан орж, 59.2 мян.иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан нь 2008-2011 оныхтой харьцуулахад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 49.3 хувиар нэмэгдэж, ажилд зуучлагдан орсон иргэд 22.3 хувиар буурсан байна. Харин ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 4.0 дахин нэмэгджээ.

### 2.2 АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН


Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар нь 2000-2013 онуудад ажиллагчдын сарын дундаж цалинг аж ахуйн нэгж, байгууллагад суурилсан түүвэр судалгааны үр дүнд үндэслэн тооцож байсан. Уг судалгааны түүврийн дизайныг 2013 онд шинэчлэн 100 ба түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ыг нэлэнхүй ажиглалтаар, 100 хүртэлх ажиллагчидтай ААНБ-ыг санамсаргүй түүврийн аргаар судалж байв.

Мэдээллийн эх үүсвэрийг 2014 оноос эхлэн өөрчилсөн бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл төлж буй аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэлд үндэслэн ажиллагчдын сарын дундаж цалинг тооцож байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн мэдээлэлд 2015 оны байдлаар 40.0 мянган ажил олгогч/ аж ахуйн нэгж, байгууллагын 697.9 мянган ажиллагчид хамрагдсан байна.

Ажиллагчдыг цалин хөлсний бүлгээр авч үзвэл 2015 онд 38.2 мян.хүн буюу 5.5 хувь нь 192.0 мян.төг хүртэлх цалинтай, 80.0 мян.хүн буюу 11.5 хувь нь 192.0-300.0, 142.0 мян.хүн буюу 20.3 хувь нь 300.0-500.0, 258.7 мян.хүн буюу 37.1 хувь нь 500.0-900.0, 69.8 мян.хүн буюу 10.0 хувь нь 900.0-1100.0, 109.2 мян.хүн буюу 15.6 хувь нь 1100.0 мян.төг ба түүнээс дээш төгрөгийн цалинтай байна.

## II. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЦАЛИН ХӨЛС

**Зураг 2.1. Ажиллагчид, цалин хөлсний бүлгээр, мян.хүн, дүнд эзлэх хувь, 2014, 2015**



Улсын хэмжээнд ажиллагчдын сарын дундаж цалин 2015 онд 808.0 мян.төг болж 2012 оныхоос 250.4 мян.төг буюу 44.9 хувиар, 2014 оныхоос 11.0 мян.төг буюу 1.4 хувиар нэмэгджээ. Эрэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин эмэгтэй ажиллагчдын сарын дундаж цалингаас илүү байх хандлага 2012-2015 онд хадгалагдсаар байна.

Ажиллагчдын дундаж цалин 2012-2015 онд 2008-2011 оныхоос 399.2 мян.төг буюу 2.2 дахин нэмэгдсэн байна.

**Хүснэгт 2.3. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мян.төг, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013		2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж* / 2008-2011 оны дундаж %
			100 хүртэлх ажиллагчидтай ААНБ-ын	100, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ын				
<b>Улсын дундаж</b>	<b>335.1</b>	<b>557.6</b>	<b>627.2</b>	<b>813.5</b>	<b>796.6</b>	<b>808.0</b>	<b>734.3</b>	<b>219.1</b>
Эрэгтэй	363.6	593.1	650.8	913.7	859.7	856.0	792.3	217.9
Эмэгтэй	308.5	524.3	604.6	711.1	733.3	760.7	676.7	219.4

Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 78 дугаар тогтоолоор 2012 онд 38.2 хувь, 23.0 хувиар 2 удаа, 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолоор 15.0 хувиар тус тус нэмэгдүүлсэн, мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2013 онд 36.8 (Зураг 2.6) хувиар нэмэгдүүлсэн нь дундаж цалин хөлсний өөрчлөлтөд нөлөөлсөн байна.


**Хүснэгт 2.4. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишиг, 2010-2014**

Баталсан огноо	Засгийн газрын тогтоол	Нэмэгдүүлсэн огноо	Нэмэгдүүлсэн хувь (%)
2010.09.15	239	2010.10.01	30.0
2012.03.16	78	2012.02.01	38.2
2012.03.16	78	2012.05.01	23.0
2014.10.11	332	2014.10.01	15.0

## II. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЦАЛИН ХӨЛС

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл 2008-2011 онд санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, уул уурхай, олборлолт, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал болон тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллагчдын сарын дундаж цалин хөлс улсын дундаж цалингаас илүү байсан бол 2012-2015 онд дээрх салбаруудаас гадна олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, цахилгаан хий, уур, агааржуулалт, мэдээлэл холбооны салбарт ажиллагчдынх улсын дундаж цалингаас илүү байна.


**Зураг 2.2. Ажиллагчдын сарын дундаж цалин, эдийн засгийн салбарын ангиллаар, мян.төг**



Ажиллагчдын сарын дундаж цалинг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд менежерийн сарын дундаж цалин 2008-2011 болон 2012-2015 онд хамгийн их байна. Сүүлийн 4 жилд үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, зэвсэгт хүчний ажил, мэргэжил, техникч болон туслах/ дэд мэргэжилтэн, суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, мэргэжилтэн болон менежерийн сарын дундаж цалин улсын дундажаас илүү байна.

## II. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЦАЛИН ХӨЛС

**Зураг 2.3. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажил мэргэжлийн ангиллаар, мян.төг**



Ажиллагчдын сарын дундаж цалинг байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл, хязгаарлагдмал хариуцлагатай компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, бусад (хувийн цэцэрлэг, сургууль зэрэг) болон хувьцаат компанид ажиллагчдын сарын дундаж цалин бусад салбарынхаас харьцангуй өндөр байна.

Төрийн бус байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин 2012-2015 онд дунджаар 564.7 мян.төг болж, 2008-2011 оныхоос хамгийн их 3.0 дахин, хоршоонд ажиллагчдын сарын дундаж цалин хамгийн бага буюу 1.6 хувиар нэмэгдсэн байна.

**Хүснэгт 2.5 Ажиллагчдын сарын дундаж цалин, байгууллагын хариуцлагын хэлбэрээр, мян.төг, 2012-2015**


	2008-2011 оны дундаж	2012	2013		2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
			100 хүртэлх ажиллагчидтай ААНБ-ын	100, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ын				
<b>Бүгд</b>	<b>335.1</b>	<b>557.6</b>	<b>627.2</b>	<b>813.5</b>	<b>796.6</b>	<b>808.0</b>	<b>734.3</b>	<b>219.1</b>
Хувьцаат компани	333.5	550.1	445.5	863.1	929.0	916.9	807.0	242.0
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	352.0	575.3	652.5	938.4	880.6	835.0	789.5	224.3
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	246.7	391.4	296.6	-	634.9	618.5	485.3	196.8
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	221.0	353.6	-	-	510.9	492.8	452.4	204.7
Хоршоо	177.6	264.6	159.4	-	347.9	351.5	280.8	158.1
Төрийн өмчит үйлдвэрийн газар	361.6	603.2	713.7	868.1	916.3	948.9	830.9	229.8
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	288.5	444.7	586.7	600.5	623.2	673.4	584.9	202.8
Төсөвт байгууллага	331.7	564.8	629.3	688.5	718.6	729.7	672.3	202.7
Төрийн бус байгууллага	187.5	326.7	555.1	-	701.8	675.2	564.7	301.2
Бусад (хувийн цэцэрлэг, сургууль зэрэг)	-	-	554.0	731.2	951.3	975.2	858.0	-

## II. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЦАЛИН ХӨЛС

Нийгмийн даатгалын шимтгэл төлж буй аж ахуйн нэгж, байгууллагыг ажиллагчдын тоогоор ялгаатай таван бүлэгт ангилж, бүлэг бүрийн хувьд ажиллагчдын сарын дундаж цалинг тооцоход ажиллагчдын тоо нэмэгдэх тутам сарын дундаж цалингийн хэмжээ их байна. Тухайлбал, 10-49 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2015 онд 689.3 мян.төг, 100-199 ажиллагчидтайнх 834.4 мян.төг байна.


1-9 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2015 онд 550.5 мян.төг болсон нь 2014 оныхоос 36.9 мян.төг буюу 7.2 хувиар, 10-49 ажиллагчидтайнх 23.0 мян.төг буюу 3.4 хувиар, 100-199 ажиллагчидтайнх 43.4 мян.төг буюу 5.5 хувиар, 200, түүнээс дээш ажиллагчидтайнх 6.5 мян.төг буюу 0.6 хувиар нэмэгдсэн байна. Харин 50-99 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2015 онд 752.2 мян.төг болж 2014 оныхоос 8.5 мян.төг буюу 1.1 хувиар буурчээ.

**Зураг 2.4. Ажиллагчдын сарын дундаж цалин, аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тооны бүлгээр, мян.төг, 2014, 2015**



2010 оныг суурь болгосон нэрлэсэн цалингийн индекс 2.4 дахин нэмэгдсэн хэдий ч худалдан авах чадварыг илэрхийлэх бодит цалингийн индекс 57.2 хувь байна.

**Зураг 2.5. Бодит цалингийн индекс (2010=100%)**






## II. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЦАЛИН ХӨЛС

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны хурлын 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 7 дугаар тогтоолоор боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажилтан болон ажиллагчийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 192.0 мян.төг байхаар шинэчлэн тогтоосноор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2012 оныхоос 51.6 мян.төг буюу 36.8 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг 2.6. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, мян.төг , 2000-2013**





### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

#### 3.1 ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

Судалгааны дүнгээр 2015 онд өрхийн сарын дундаж нийт орлого 1047.3 мянган төгрөг болж 2012 оныхоос 27.7 хувиар өссөн боловч өмнөх оныхоосоо 3.0 хувиар буурчээ. Өрхийн сарын дундаж нийт орлого 2015 онд өмнөх оныхоос 3.0 хувиар буурахад мөнгөн орлого 3.0 хувиар, үүнээс өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 17.5 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Сүүлийн 4 жилийн дунджийг 2008-2011 оны дундажтай харьцуулахад өрхийн сарын дундаж нийт орлого 2.2 дахин нэмэгдсэн байна.

**Хүснэгт 3.1. Нэг өрхийн сарын дундаж орлого, оны үнээр, төг, 2012-2015**

Орлогын төрөл	2008-2011 оны дундаж	Улсын дундаж				2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
		2012	2013	2014	2015		
<b>Нийт орлого - Бүгд</b>	<b>446 922</b>	<b>819 996</b>	<b>959 247</b>	<b>1 080 145</b>	<b>1 047 255</b>	<b>976 662</b>	<b>218.5</b>
<b>1. Мөнгөн орлого - Бүгд</b>	392 818	741 917	862 511	974 392	945 118	880 985	224.3
Цалин хөлс	197 134	372 114	439 289	500 649	503 714	453 942	230.3
Тэтгэвэр, тэтгэмж	77 448	155 686	151 841	143 520	163 776	153 706	198.5
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	84 020	145 740	179 938	221 665	182 810	182 538	217.3
Бусад орлого	34 216	68 377	91 443	108 558	94 818	90 799	265.4
<b>2. Бусдаас үнэгүй авсан</b>	16 794	31 967	37 285	46 083	50 508	41 461	246.9
<b>3. Хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	37 310	46 112	59 451	59 670	51 629	54 216	145.3

Инфляциар засварласан өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2015 онд 2012 оноос 0.1 хувь, үүнээс цалин хөлс 6.4 хувь, бусад орлого 9.0 хувиар нэмэгдэж, харин тэтгэвэр, тэтгэмж 17.3 хувь, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 1.4 хувиар буурчээ (Хүснэгт 3.2).

**Хүснэгт 3.2. Нэг өрхийн сарын дундаж орлого, инфляциар засварлан тооцсоноор, төг, 2012-2015**

Орлогын төрөл	2008-2011 оны дундаж	Улсын дундаж				2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
		2012	2013	2014	2015		
<b>Нийт орлого - Бүгд</b>	<b>654 282</b>	<b>819 996</b>	<b>852 664</b>	<b>864 981</b>	<b>823 006</b>	<b>840 162</b>	<b>128.4</b>
<b>1. Мөнгөн орлого - Бүгд</b>	575 194	741 917	766 677	780 294	742 739	757 907	131.8
Цалин хөлс	288 894	372 114	390 479	400 920	395 853	389 842	134.9
Тэтгэвэр, тэтгэмж	112 459	155 686	134 970	114 931	128 706	133 573	118.8
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	123 693	145 740	159 945	177 510	143 665	156 715	126.7
Бусад орлого	50 149	68 377	81 283	86 933	74 515	77 777	155.1
<b>2. Бусдаас үнэгүй авсан</b>	24 468	31 967	33 142	36 903	39 693	35 426	144.8
<b>3. Хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	54 620	46 112	52 845	47 784	40 574	46 829	85.7

### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Нэг өрхийн сарын дундаж бодит орлого 2014 онд 865.0 мян.төг болж 2012 оныхоос 5.5 хувиар нэмэгдсэн бол 2015 онд бодит орлого 823.0 мян.төг болж, 2012 оныхоос 0.4 хувиар нэмэгдэж, өмнөх оныхоос 4.9 хувиар буурсан байна (Хүснэгт 3.2).

Өрхийн орлогын бүтцээс харахад 2012-2015 онд дунджаар өрхийн нийт орлогын 46.5 хувийг цалин хөлс, 18.7 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 15.7 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байна. Нэг өрхийн сарын дундаж нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2012-2015 онд өмнөх 4 жилийн дунджаас 2.3 пунктээр нэмэгдсэн байна. Үүнээс цалин хөлсний орлогын эзлэх хувь 2.4 пунктээр, бусад орлого 1.6 пунктээр нэмэгдсэн байна (Хүснэгт 3.3).

**Хүснэгт 3.3. Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц, хувиар, 2012-2015**

Орлогын төрөл	2008-2011 оны дундаж	Улсын дундаж				2012-2015 оны дундаж
		2012	2013	2014	2015	
<b>Нийт орлого - Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>1. Мөнгөн орлого - Бүгд</b>	87.9	90.5	89.9	90.2	90.3	90.2
Цалин хөлс	44.1	45.4	45.8	46.3	48.1	46.5
Тэтгэвэр, тэтгэмж	17.3	19.0	15.8	13.3	15.6	15.7
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	18.8	17.8	18.8	20.5	17.5	18.7
Бусад орлого	7.7	8.3	9.5	10.1	9.1	9.3
<b>2. Бусдаас үнэгүй авсан</b>	3.8	3.9	3.9	4.3	4.8	4.2
<b>3. Хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	8.3	5.6	6.2	5.5	4.9	5.6

Өрхийг мөнгөн орлогоор нь бүлэглэж авч үзвэл, улсын дунджаар 2015 онд 500.0 мянган төгрөгөөс доош орлоготой өрх нийт өрхийн 29.0 хувийг, 500.0-900.0 мянган төгрөгийн орлоготой өрх 31.0 хувийг, 900.0-1600.0 мянган төгрөгийн орлоготой өрх 27.6 хувийг эзэлж байна.

**Хүснэгт 3.4. Өрхийн бүлэглэлт, мөнгөн орлогоор, дүнд эзлэх хувиар, 2012-2015**

Мөнгөн орлогын бүлэг	Улсын дундаж				Хот				Хөдөө			
	2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015
300 001 төгрөг хүртэл	24.8	14.9	11.2	12.4	15.9	7.0	6.2	7.7	41.8	28.3	20.0	21.2
300 001 - 500 000	20.8	17.6	16.8	16.6	19.8	14.0	12.1	13.2	22.9	23.7	25.0	22.9
500 001 - 700 000	16.2	18.1	17.0	17.0	17.7	18.8	15.9	15.7	13.2	16.9	18.8	19.3
700 001 - 900 000	12.2	14.3	14.3	14.0	14.1	15.9	15.2	15.0	8.5	11.6	12.8	12.2
900 001 - 1 100 000	8.5	10.6	11.0	11.1	10.2	12.6	13.0	13.1	5.3	7.2	7.7	7.4
1 100 001 - 1 600 000	10.2	14.0	16.2	16.5	12.6	17.9	19.9	19.9	5.5	7.3	9.7	10.3
1 600 001 - 2 100 000	3.5	5.4	6.8	6.7	4.6	7.1	8.8	8.3	1.5	2.6	3.3	3.7
2 100 001 төгрөгөөс дээш	3.8	5.1	6.7	5.7	5.1	6.7	8.9	7.1	1.3	2.4	2.7	3.0

Өрхийн мөнгөн орлогын бүлэглэлтийг байршлаар нь авч үзвэл, хотод 700.0 мянган төгрөгөөс доош орлоготой өрх нийт өрхийн 36.6 хувь, хөдөөд 63.4 хувийг эзэлж байхад, 700.0-1600.0 мянган төгрөгийн орлоготой өрх хотод 48.0 хувь, хөдөөд 29.9 хувийг эзэлж байна (Хүснэгт 3.4). Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага 2015 онд 1064.8 мян.төг болж 2012 оныхоос 29.8 хувиар өсч, өмнөх оныхоос 1.1 хувиар буурчээ (Хүснэгт 3.5). Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2012-2015 онд өмнөх 4 жилийн дунджаас 2.2 дахин өссөн нь хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 2.5 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

#### Хүснэгт 3.5. Нэг өрхийн сарын дундаж зарлага, оны үнээр, төг, 2012-2015

Зарлагын төрөл	2008-2011 оны дундаж	Улсын дундаж				2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж %
		2012	2013	2014	2015		2008-2011 оны дундаж
<b>Нийт зарлага - Бүгд</b>	<b>458 170</b>	<b>820 263</b>	<b>961 677</b>	<b>1 076 557</b>	<b>1 064 808</b>	<b>980 826</b>	<b>214.1</b>
<b>1. Мөнгөн зарлага - Бүгд</b>	<b>404 066</b>	<b>742 184</b>	<b>864 941</b>	<b>970 804</b>	<b>962 671</b>	<b>885 150</b>	<b>219.1</b>
Хүнсний зүйлийн зарлага	138 715	207 858	226 031	249 905	239 436	230 808	166.4
"Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага"	252 156	518 750	619 329	694 486	694 983	631 887	250.6
Бусдад өгсөн бэлэг, тусламж	13 195	15 576	19 581	26 413	28 252	22 455	170.2
<b>2. Бусдаас үнэгүй авсан - Бүгд</b>	<b>16 794</b>	<b>31 967</b>	<b>37 285</b>	<b>46 083</b>	<b>50 508</b>	<b>41 461</b>	<b>246.9</b>
Хүнсний зүйлийн зарлага	7 691	12 880	13 934	18 733	19 560	16 277	211.6
"Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага"	9 103	19 087	23 351	27 350	30 948	25 184	276.7
<b>3. Хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>37 310</b>	<b>46 112</b>	<b>59 451</b>	<b>59 670</b>	<b>51 629</b>	<b>54 215</b>	<b>145.3</b>

Өрхийн зарлагын бүтцээс харахад 2012-2015 оны дунджаар өрх нийт зарлагынхаа 64.4 хувийг хүнсний бус бараа үйлчилгээнд, 23.5 хувийг хүнсний зүйлд зарцуулсан байна.

#### Хүснэгт 3.6. Нэг өрхийн сарын дундаж зарлагын бүтэц, хувиар, 2012-2015

Зарлагын төрөл	2008-2011 оны дундаж	Улсын дундаж				2012-2015 оны дундаж
		2012	2013	2014	2015	
<b>Нийт зарлага - Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>1. Мөнгөн зарлага - Бүгд</b>	<b>88.2</b>	<b>90.5</b>	<b>89.9</b>	<b>90.2</b>	<b>90.4</b>	<b>90.2</b>
Хүнсний зүйлийн зарлага	30.3	25.3	23.5	23.2	22.4	23.5
"Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага"	55.0	63.3	64.4	64.5	65.3	64.4
Бусдад өгсөн бэлэг, тусламж	2.9	1.9	2.0	2.5	2.7	2.3
<b>2. Бусдаас үнэгүй авсан - Бүгд</b>	<b>3.7</b>	<b>3.9</b>	<b>3.9</b>	<b>4.3</b>	<b>4.7</b>	<b>4.3</b>
Хүнсний зүйлийн зарлага	1.7	1.6	1.5	1.7	1.8	1.7
"Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага"	2.0	2.3	2.4	2.6	2.9	2.6
<b>3. Хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>8.1</b>	<b>5.6</b>	<b>6.2</b>	<b>5.5</b>	<b>4.9</b>	<b>5.5</b>

Өрхийн сарын дундаж нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2012-2015 онд өмнөх 4 жилийн дунджаас 2.0 пунктээр нэмэгджээ. Хүнсний зүйлийн зарлага 6.8 пунктээр буурч, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 9.4 пунктээр нэмэгдсэн байна (Хүснэгт 3.6). Өрхийг мөнгөн зарлагаар нь бүлэглэж авч үзвэл, улсын дунджаар 2015 онд 500.0 мянган төгрөгөөс доош зарлагатай өрх нийт өрхийн 25.9 хувийг, 500.0-900.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 32.8 хувийг, 900.0-1600.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 28.1 хувийг эзэлж байна.

### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

#### Хүснэгт 3.7. Өрхийн бүлэглэлт, мөнгөн зарлагаар, дүнд эзлэх хувиар, 2012-2015


Мөнгөн зарлагын бүлэг	Улсын дундаж				Хот				Хөдөө			
	2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015
300 001 төгрөг хүртэл	20.7	13.4	9.6	9.2	10.5	5.9	4.8	5.6	40.2	26.1	18.1	15.9
300 001 - 500 000	23.5	19.1	17.1	16.7	22.2	15.5	13.2	13.7	26.0	25.1	24.0	22.5
500 001 - 700 000	18.0	19.2	17.9	17.7	20.7	20.4	17.5	17.4	12.7	17.2	18.6	18.1
700 001 - 900 000	12.0	14.3	15.0	15.1	14.4	16.2	16.3	16.3	7.5	11.1	12.7	12.9
900 001 - 1 100 000	7.9	9.9	11.0	11.7	9.5	12.0	12.6	13.2	4.9	6.3	8.1	8.8
1 100 001 - 1 600 000	10.0	13.6	15.4	16.4	12.2	16.6	18.1	18.5	5.6	8.7	10.8	12.4
1 600 001 - 2 100 000	3.9	5.5	7.1	7.1	5.0	6.9	8.7	8.1	1.8	3.1	4.3	5.2
2 100 001 төгрөгөөс дээш	4.0	5.0	6.9	6.1	5.5	6.5	8.8	7.2	1.3	2.4	3.4	4.2

Өрхийн мөнгөн зарлагын бүлэглэлтийг байршлаар нь авч үзвэл, хотод 700.0 мянган төгрөгөөс доош зарлагатай өрх нийт өрхийн 36.7 хувь, хөдөөд 56.5 хувийг эзэлж байхад, 700.0-1600.0 мянган төгрөгийн зарлагатай өрх хотод 48.0 хувь, хөдөөд 34.1 хувийг эзэлж байна.

#### Өрхийн орлого, зарлагын /хэрэглээ/ харьцаа

Эдийн засгийн тогтвортой өсөлт хадгалагдаж буй нөхцөлд хүн амын амьжиргааны түвшин ерөнхийдөө дээшилж байх зүй тогтолтой. Орлого нь зарлагаа давж байвал хүмүүс хуримтлуулдаг, харин өдөр тутмын хэрэгцээнд дөнгөж хүрэлцэх төдий орлоготой бол хуримтлал үүсгэх боломжгүй юм. Өрхийн нийт орлого, зарлагын харьцааг (Зураг 3.1) харахад 2012-2013 онд өрхийн нийт зарлагын хэмжээ орлогоосоо 0.03-0.3 хувиар илүү, харин 2014 онд 0.3 хувиар бага байсан бол 2015 онд өрхийн нийт зарлагын хэмжээ орлогоосоо 1.7 хувиар илүү байна. Энэ нь өрхүүд хуримтлал үүсгэж чадах хэмжээний орлого олж чадахгүй байгааг харуулж байна.

Зураг 3.1. Өрхийн нийт орлого, зарлагын харьцаа, 2012-2015



#### Хүн амын хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 257 дугаар тоот тушаалаар батлагдсан “Хүн амын хоол, тэжээлийн физиологийн норм”-ыг үндэслэн тооцож үзвэл, 2012-2015 онд дунджаар нэг хүнд ногдох будаа, өндөг, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон ургамлын ба өөхөн тосны хэрэглээ нь физиологийн нормоос доогуур байна.



### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

#### Хүснэгт 3.8. Хүнсний зарим бүтээгдэхүүний нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ, жишсэн нэг хүнээр, кг, 2012-2015

Хүнсний бүтээгдэхүүн	Физиологийн норм*	2008-2011 оны дундаж	Улсын дундаж				2012-2015 оны дундаж
			2012	2013	2014	2015	
"Мах, махан бүтээгдэхүүн, маханд шилжүүлснээр"	6.0	8.2	8.2	8.1	8.8	8.5	8.4
"Сүү, сүүн бүтээгдэхүүн, сүүнд шилжүүлснээр, литр"	10.5	12.1	13.4	13.4	13.6	13.8	13.5
Цэцгийн тос	-	-	0.3	0.3	0.3	0.3	0.3
"Гурил, гурилан бүтээгдэхүүн, гурилд шилжүүлснээр"	9.6	10.7	10.5	10.1	10.6	10.5	10.4
Будаа	2.3	1.7	1.8	1.8	1.9	1.8	1.8
"Чихэр, сахарын зүйл, сахарт шилжүүлснээр"	0.7	1.6	1.4	1.4	1.3	0.8	1.2
Өндөг, ширхэг	9.5	2.6	3.2	3.6	3.6	4.1	3.6
Төмс	4.2	3.3	3.2	3.2	3.0	2.8	3.0
Хүнсний ногоо	8.7	1.8	2.0	2.0	2.1	2.0	2.0
Жимс, жимсгэнэ	5.4	0.7	0.7	0.7	0.8	0.7	0.7
Ургамлын болон өөхөн тос	0.8	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5

\* Сэрүүний улирлын физиологийн норм

Мах, махан бүтээгдэхүүний хэрэглээ 2012 онд 8.2 кг байсан бол 2015 онд 8.5 кг болж 0.3 кг-аар нэмэгдэж, харин өмнөх оныхоос 0.3 кг-аар буурсан байна. Хүнсний ногооны нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ 2015 онд 2 кг буюу физиологийн норм хэмжээнээс 6.7 кг-аар, өндөгний хэрэглээ 4.1 ширхэг буюу физиологийн норм хэмжээнээс 5.4 ширхэгээр, жимс, жимсгэний хэрэглээ 0.7 кг буюу физиологийн норм хэмжээнээс 4.7 кг-аар бага байна.

Жишсэн нэг хүний хоногт хэрэглэсэн илчлэгийн хэмжээ 2014 онд 2013 оныхоос 104.2 ккал-оор өссөн бол 2015 онд 2791.4 ккал болж өмнөх оныхоос 107.9 ккал-оор буурсан байна. Энэ үзүүлэлт 2015 онд өмнөх оныхоос хотод 155.5 ккал-оор, хөдөөд 49.0 ккал-оор буурсан байна (Хүснэгт 3.9).

#### Хүснэгт 3.9. Жишсэн нэг хүний хоногт хэрэглэсэн хүнсний зүйлийн илчлэг, найрлага, хот, хөдөөгөөр, 2012-2015

	Зөвлөмж хэмжээ	Улсын дундаж				Хот				Хөдөө			
		2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015
Илчлэг, ккал	2500	2 848.8	2 795.1	2 899.3	2791.4	2 549.8	2 549.5	2 605.0	2449.5	3 214.6	3 101.9	3 266.7	3217.7
Уураг, гр	94	107.2	105.8	111.9	109.8	91.1	91.9	94.7	91.7	127.0	123.1	133.3	132.3
Өөх тос, гр	69	94.2	93.5	96.7	95.8	79.1	79.2	81.4	79.3	112.6	111.4	115.9	116.4
Нүүрс ус, гр	375	373.9	363.6	375.7	353.5	351.3	350.1	356.0	325.7	401.4	380.6	400.4	388.2

Хүн амын хүнсний хэрэглээний үндсэн шимт бодисуудын зохистой хэрэглээ хот, хөдөөгөөр авч үзвэл хотын нэг хүний хоногт хоол хүнснээсээ авч байгаа уураг 2015 онд 91.7 грамм байгаа нь физиологийн норм хэмжээнээс 2.3 граммаар бага, хөдөөгийн нэг хүний хоногт авч байгаа уургийн хэмжээ 132.3 грамм буюу 38.3 граммаар илүү байна. Хотын нэг хүний хоногт хоол хүнснээсээ авч байгаа өөх тос физиологийн нормоос 10.3 граммаар их байхад хөдөөгийн нэг хүнийх 47.4 граммаар илүү байна. Мөн хотын нэг хүний хоногт хоол хүнснээсээ авч байгаа нүүрс ус 325.7 грамм буюу физиологийн норм хэмжээнээс 49.3 граммаар бага, харин хөдөөгийн нэг хүнийх 388.2 грамм буюу 13.2 граммаар илүү байна. Эндээс харахад хөдөөгийн хүн амын хоол хүнснээсээ авч байгаа уураг, өөх тосны зохистой харьцаа алдагдсан хэвээр байна.

### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

#### 3.2 ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, ЯДУУРАЛ

Хүн амын амьжиргааны түвшин, ядуурлыг тодорхойлохдоо өмнөх онуудын судалгааны адилаар мөнгөөр илэрхийлэгдэх үзүүлэлтээр буюу хүн амын хэрэглээнд үндэслэн тооцох арга зүйг баримталсан. Ядуурлын шугам нь хүн амын ядуу эсэхийг тодорхойлох босго үзүүлэлт бөгөөд нэг хүнд ногдох хэрэглээ нь ядуурлын шугамнаас доогуур байвал тэр хүнийг ядуу гэж тодорхойлдог. Хүн амын хэрэглээнд үндэслэн гаргасан 2010 оны ядуурлын шугамыг үнийн индексээр индексжүүлэн 2014 оны ядуурлын шугамыг тооцоход 146.7 мянган төгрөг болж байна.

**Хүснэгт 3.10. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дундаж, хот, хөдөөгөөр, хувиар, 2012, 2014**


	Ядуурлын хамралтын хүрээ		Ядуурлын гүнзгийрэлт		Ядуурлын мэдрэмж	
	2012	2014	2012	2014	2012	2014
Улсын дундаж	27.4	21.6	7.1	5.2	2.7	1.9
Хот	23.3	18.8	6.2	4.9	2.4	1.9
Үүнээс:						
Улаанбаатар	19.9	16.4	5.1	4.5	2.0	1.7
Хөдөө	35.4	26.4	8.8	5.8	3.2	2.0

Ядуурлын хамралтын хүрээний индекс гэдэг нь нийт хүн амд ядуу хүмүүсийн эзлэх хувь бөгөөд энэ нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувийг харуулдаг. Монгол Улсад ядуурлын түвшин буюу ядуурлын хамралтын хүрээ 2014 оны байдлаар 21.6 хувь (Хүснэгт 3.10) болсон бөгөөд 634.0 мянга орчим хүн ядууралд өртсөн байна. Өөрөөр хэлбэл, 100 хүн тутмын 22 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна. Ядуурлын хамралтын хүрээ 2012 онд 27.4 хувь байснаа 2014 онд 21.6 хувь болж 5.8 пунктээр буурсан байна. Хотод ядуурал 23.3 хувиас 18.8 хувь болж 4.5 пунктээр, хөдөөд 35.4 хувиас 26.4 хувь болж 9.0 пунктээр буурсан байна. Ядуурлын байдлыг бүрэн тодорхойлохын тулд ядуурлын гүнзгийрэлт, ядуурлын мэдрэмж гэсэн 2 хэмжүүрийг хамтад нь авч үздэг.

Ядуурлын гүнзгийрэлтийн индекс нь ядуучуудын хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамаас дунджаар хэдэн хувиар доогуур байгааг илэрхийлдэг үзүүлэлт юм. Хүн амын 21.6 хувь нь 2014 оны байдлаар ядуу байгаа бөгөөд эдгээр ядуучуудын хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамнаас 5.2 хувиар доогуур буюу ойролцоогоор 139.1 мянган төгрөг байна.

Ядуурлын мэдрэмжийн индекс нь ядуучуудын дундах хэрэглээний тархалтын мэдрэмж бөгөөд ядуурлын түвшинд ядуучуудын дундаж хэрэглээ, хэрэглээний тархалт нөлөөлж байгааг илэрхийлэх үзүүлэлт юм. Судалгааны дүнгээр ядуурлын мэдрэмжийн хэмжигдэхүүн 2014 онд 1.9 хувь болж, 2012 оныхоос 0.8 пунктээр буурсан байна.

**Зураг 3.2. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дундаж, хот, хөдөөгөөр, хувиар, 2012, 2014**



### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Нэг хүнд ногдох хэрэглээнд тулгуурлан тооцсон буюу хэрэглээний тэгш бус хуваарилалтыг харуулах Жини коэффициент 2012 онд 0.34 байсан бол 2014 онд 0.32 болж буурсан нь хүн амын дундах хэрэглээний тэгш бус байдал буурч, орлогын ялгаа багассаныг харуулж байна.

Тэгш бус байдлыг тодорхойлох өөр нэг үндсэн үзүүлэлт болох хүн амыг хэрэглээний түвшнээр нь тэнцүү 10 бүлэгт хуваах (нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээгээр нь хүн амыг ядуугаас нь баян руу нь эрэмбэлэн, улмаар 10 хувиар буюу тэнцүү 10 бүлэгт хуваана) арга юм. Хүснэгт 3.11-ээс харахад 2012 онд хүн амын чинээлэг 10 хувийн хэрэглээний дундаж хэмжээ хамгийн ядуу 10 хувийнхнаас 8.3 дахин их хэрэглээтэй байсан бол 2014 онд энэ тоо 7.7 болж багассан байна. Энэ харьцаа хотод 8.4, хөдөөд 6.0 байгаа нь хотод хэрэглээний тэгш бус байдал өндөр байгааг мөн харуулж байна.

**Хүснэгт 3.11. Нэг хүнд сард ногдох хэрэглээ, өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр, төг, 2012, 2014**

Бүлэг	2012			2014		
	Улсын дундаж	Хот	Хөдөө	Улсын дундаж	Хот	Хөдөө
I	65 164	66 429	63 442	88 611	88 907	88 581
II	93 230	98 139	87 106	128 173	133 029	122 782
III	113 720	121 835	102 922	155 666	165 292	144 426
IV	133 639	144 933	118 124	181 615	194 110	164 995
V	156 140	169 481	135 364	208 190	225 003	187 187
VI	181 585	196 164	154 622	238 753	259 267	209 543
VII	210 767	229 876	180 338	275 102	299 655	238 075
VIII	252 699	275 821	209 716	323 319	352 307	274 787
IX	320 200	348 351	260 437	398 638	437 597	331 202
X	542 172	588 195	424 339	682 905	746 900	533 354
Нийт	206 886	223 880	173 587	268 069	290 123	229 471

Улсын хэмжээнд нэг хүнд ногдох сарын хэрэглээ 2014 онд дунджаар 268.1 мян. төг болж, 2012 оныхоос 61.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт өрхийн 60 хувь нь улсын дунджаас доогуур, 40 хувь нь улсын дунджаас дээгүүр хэрэглээтэй байна. Улс оронд нийгмийн тогтвортой байдал, хөгжил дэвшлийг хангахад дундаж анги чухал үүрэгтэй байдаг. Цаашдаа ядуу хэсгийн эзлэх хувийг бууруулж дундажчуудын эзлэх байр суурийг нэмэгдүүлэх нь нийгмийн хөгжлийг хангах болон хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх чиглэлээр дэвшүүлэх гол зорилт болж байна.

### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

#### 3.3. НИЙГМИЙН ДААТГАЛ

Монгол Улсад даатгуулагч, ажил олгогч шимтгэл төлөх замаар тэтгэврийн хуримтлал бий болгон түүнээс тэтгэвэр авагчдынхаа тэтгэвэр, тэтгэмжийг төвлөрсөн журмаар олгодог хуваарилалтын систем үйлчилж байна. Нийгмийн даатгалын төрөл тус бүр нь мөнгөн хөрөнгийн бие даасан сантай байдаг.

**Хүснэгт 3.12. Нийгмийн даатгалын сангийн орлого, 2012-2015**

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							% 2008-2011 оны дундаж
<b>Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг</b>	<b>564 466.1</b>	<b>799 217.0</b>	<b>1 018 823.3</b>	<b>1 140 580.6</b>	<b>1 187 436.3</b>	<b>1 036 514.3</b>	<b>1.8*</b>
Үүнээс:							
Тэтгэврийн даатгалын сан	410 091.6	491 924.4	635 012.0	704 409.0	718 716.6	637 515.5	1.6*
Тэтгэмжийн даатгалын сан	17 825.0	35 450.1	67 283.0	78 408.3	81 098.1	65 559.9	3.7*
Эрүүл мэндийн даатгалын сан	86 750.2	166 612.8	204 087.2	231 728.0	248 068.4	212 624.1	2.5*
ҮОМШӨ*-ний даатгалын сан	<b>31 198.1</b>	<b>67 942.8</b>	<b>86 676.0</b>	<b>99 740.8</b>	<b>109 748.0</b>	<b>91 026.9</b>	<b>2.9*</b>
Ажилгүйдлийн даатгалын сан	19 351.4	37 286.9	25 765.1	26 294.5	29 805.2	29 787.9	1.5*
<b>Нийгмийн даатгалд даатгуулагчид мян.хүн</b>	<b>655.9</b>	<b>863.2</b>	<b>978.3</b>	<b>1 018.6</b>	<b>989.0</b>	<b>962.3</b>	<b>1.5*</b>
Үүнээс:							
Заавал даатгуулагчид	<b>594.3</b>	<b>761.9</b>	<b>830.2</b>	<b>832.9</b>	<b>799.8</b>	<b>806.2</b>	<b>1.4*</b>
Сайн дураар даатгуулагчид	<b>61.6</b>	<b>101.3</b>	<b>148.1</b>	<b>185.7</b>	<b>189.2</b>	<b>156.1</b>	<b>2.5*</b>

\* дахин

\*\* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: НДЕГ-ын мэдээлэл

Нийгмийн даатгалын сангийн орлого 2015 онд 1187.4 тэрбум төгрөгт хүрч, 2012 оныхоос 1.5 дахин нэмэгджээ. Нийгмийн даатгалын сангийн орлого 2012-2015 онд жилд дунджаар 1036.5 тэрбум.төг болж, 2008-2011 оны дунджаас 83.6 хувь, нийгмийн даатгалд даатгуулагчид 962.3 мянга болж, өмнөх 4 жилийн дунджаас 46.7 хувиар нэмэгдлээ.

Сүүлийн 4 жилийн дунджаас харахад нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид 351.2 мянга болж, 2008-2011 оны дундажтай харьцуулахад 7.6 хувиар буурчээ. Тэтгэвэр авагч хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2012-2015 онд 68.4 мянга болж, 2008-2011 оны дунджаас 7.5 мянга буюу 12.3 хувиар өсчээ.

**Хүснэгт 3.13. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид, төрлөөр, мян.хүн, 2012-2015**

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							% 2008-2011 оны дундаж
<b>Тэтгэвэр авагчид</b>	<b>326.5</b>	<b>334.6</b>	<b>336.9</b>	<b>345.8</b>	<b>387.3</b>	<b>351.2</b>	<b>107.5</b>
Өндөр настан	211.2	224.7	230.3	242.5	268.4	241.5	114.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	67.6	65.8	64.5	65.4	77.9	68.4	101.2
Тэжээгчээ алдсан	34.6	29.9	27.4	23.3	25.6	26.6	76.8
Цэргийн тэтгэвэр	13.1	14.2	14.7	14.6	15.4	14.7	112.4

Эх үүсвэр: НДЕГ-ын мэдээлэл

### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Тэтгэвэр авагчдын жилийн дундаж тоог тэтгэврийн төрлөөр нь харвал, 2012-2015 онд нийт тэтгэврийн 68.8 хувийг эзэлж буй өндөр настны тэтгэвэр авагчид 2012-2015 онд 241.5 мянгад хүрч, 2008-2011 оны дундажтай харьцуулахад 14.3 хувиар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнх 1.2 хувь, цэргийн тэтгэвэр авагчдынх 12.4 хувиар өсч, харин тэжээгчээ алдсаных 23.2 хувиар буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас 2015 онд 1198.9 тэрбум төгрөгийг тэтгэвэрт зарцуулсан нь 2012 оныхоос 464.8 тэрбум.төг буюу 63.3 хувиар өссөн байна. Нийгмийн даатгалын сангаас 2012-2015 онд олгосон тэтгэврийн дундаж хэмжээ 2008-2011 оныхоос 565.5 тэрбум төг буюу 2.5 дахин өслөө.

**Хүснэгт 3.14. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэрт зарцуулсан хөрөнгийн хэмжээ, тэрбум төг, 2012-2015**

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							%
							2008-2011 оны дундаж
<b>Олгосон тэтгэврийн хэмжээ</b>	<b>380.0</b>	<b>734.1</b>	<b>837.5</b>	<b>1 011.9</b>	<b>1 198.9</b>	<b>945.6</b>	<b>2.5*</b>
Өндөр настан	267.1	516.5	593.3	724.8	867.7	675.6	2.5*
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	60.9	111.8	124.9	156.3	184.8	144.4	2.4*
Тэжээгчээ алдсан	29.1	47.1	50.4	54.9	59.8	53.0	1.8*
Цэргийн тэтгэвэр	23.0	58.6	68.9	76.0	86.6	72.5	3.2*

\* дахин

Эх үүсвэр: НДЕГ-ын мэдээлэл

Эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлсний үр дүнд 2012-2015 оны дундажийг 2008-2011 оныхтой харьцуулахад бүрэн тэтгэврийн доод хэмжээ 2.1 дахин, хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ 2.6 дахин, дундаж тэтгэврийн хэмжээ 2.2 дахин нэмэгдлээ.

**Хүснэгт 3.15. Тэтгэврийн хэмжээ, төг, 2012-2015**

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							%
							2008-2011 оны дундаж
Бүрэн тэтгэврийн доод хэмжээ	93 150	180 300	180 300	207 300	230 000	199 475	2.1*
Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ	62 100	145 200	145 200	172 200	195 000	164 400	2.6*
Дундаж тэтгэвэр	111 753	222 000	222 000	256 500	283 800	241 075	2.2*

\* дахин

Эх үүсвэр: НДЕГ-ын мэдээлэл

### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Нийгмийн даатгалд 2015 онд 989.0 мян.хүн хамрагдсаны 799.8 мянга буюу 80.9 хувь нь заавал даатгуулагчид, 189.2 мянга буюу 19.1 хувь нь сайн дурын даатгуулагчид байна.

#### Хүснэгт 3.16. Нийгмийн даатгалд даатгуулагчид мян.хүн, 2012-2015

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							%
							2008-2011 оны дундаж
<b>Даатгуулагчид</b>	<b>655.9</b>	<b>863.2</b>	<b>978.3</b>	<b>1018.6</b>	<b>989.0</b>	<b>962.3</b>	<b>1.5*</b>
Заавал даатгуулагчид	594.3	761.9	830.2	832.9	799.8	806.2	1.4*
Сайн дурын даатгуулагчид	61.6	101.3	148.1	185.7	189.2	156.1	2.5*

\* дахин

Эх үүсвэр: НДЕГ-ын мэдээлэл

Нийгмийн даатгалд 2012-2015 онд дунджаар 962.3 мян.хүн даатгуулсан нь 2008-2011 оны дунджаас 306.4 мянга буюу 46.7 хувь, заавал даатгуулагчид 211.9 мян.хүн буюу 35.7 хувь, сайн дурын даатгуулагчид 94.5 мян.хүн буюу 2.5 дахин өслөө.

#### 3.4. НИЙГМИЙН ХАЛАМЖ

Монголын Улсын Засгийн газраас иргэдийнхээ аж байдлыг дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах, хүнээ хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах чиглэлээр явуулж буй цогц бодлогуудын хүрээнд нийгмийн халамжийн сангаас олгож буй тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хувь хишиг нэмэгдсээр байна.

#### Хүснэгт 3.17. Халамжийн сангийн зардал, тэрбум төг, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							%
							2008-2011 оны дундаж
Халамжийн сангийн зардал	173.5	181.4	233.2	241.8	256.9	228.3	131.6

Эх үүсвэр: НДЕГ-ын мэдээлэл

Нийгмийн халамжийн сангийн зардал сүүлийн 4 жилд тасралтгүй өссөн бөгөөд 2012-2015 онд дунджаар 228.3 тэрбум төгрөгт хүрч, 2008-2011 оныхоос 31.6 хувиар өссөн байна.

#### 3.5. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газраас иргэдийнхээ аж байдлыг дээшлүүлэх зорилгоор 2012-2015 онд явуулсан нийгмийн хамгааллын бодлогын үр дүнд нэг хүнд сард ногдох тэтгэвэр 2015 онд 120402 төгрөг, тэтгэмж, тусламж авагчдын нэг хүнд сард ногдох хэмжээ 43889 төгрөг болж, 2012 оныхтой харьцуулахад халамжийн тэтгэвэр 30320 төгрөг буюу 33.7 хувь, тэтгэмж, тусламж 3569 төг буюу 8.9 хувиар өсчээ.

#### Хүснэгт 3.18. Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн хэмжээ, нэг хүнд ногдохоор, төг, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							%
							2008-2011 оны дундаж
Халамжийн тэтгэвэр	41 575	90 082	104 456	105 478	120 402	105 105	2.5*
Тэтгэмж, тусламж	19 694	40 320	43 523	40 768	43 889	42 125	2.1*

\* дахин


Эх үүсвэр: НДЕГ-ын мэдээлэл



### III. ХҮН АМЫН АМЖИРГААНЫ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 2015 онд 2012 оныхоос 20.5 тэрбум төг буюу 31.2 хувь, 2013 оныхоос 6.6 тэрбум төг буюу 8.4 хувь, 2014 оныхоос 4.0 тэрбум төг буюу 4.8 хувиар өсчээ. Тэтгэмж, тусламжийн хэмжээ 2015 онд 2012 оныхоос 31.9 хувь, 2013 оныхоос 8.1 хувиар, 2014 оныхоос 12.9 хувиар өслөө. Нийгмийн халамжийн зардалд халамжийн тэтгэврийн эзлэх хувь нэмэгдсэн нь тэтгэврийн доод хэмжээг удаа дараа нэмсэнтэй холбоотой байна.

Зураг 3.3. Нийгмийн халамжийн сангийн зардал, төрлөөр, 2012-2015



Нийгмийн халамжийн зардалд тэтгэмж, тусламжийн эзлэх хувь өссөн нь 2011 онд “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай” хуульд өөрчлөлт оруулж, “Алдарт эх”-ийн одонтой эхчүүдийн тоо өссөнтэй холбоотой юм.

Хүснэгт 3.19. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт авсан хүний тоо, тэтгэмжийн төрлөөр, мян.хүн, 2012-2015

	2012	2013	2014	2015
<b>Бүгд</b>	<b>1 478.4</b>	<b>1 587.8</b>	<b>1 665.6</b>	<b>1 703.5</b>
<b>Халамжийн тэтгэвэр</b>	<b>60.7</b>	<b>63.4</b>	<b>64.9</b>	<b>59.6</b>
<b>Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>123.3</b>	<b>131.6</b>	<b>140.7</b>	<b>137.5</b>
Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	91.4	94.9	98.6	92.3
Ахмад настныг асарч буй иргэний	14.8	16.7	20.0	21.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний	15.1	17.7	19.6	21.0
Бусад	2.0	2.3	2.5	2.4
<b>Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>25.3</b>	<b>36.4</b>	<b>31.0</b>	<b>42.5</b>
Байнгын асаргаа шаардлагатай иргэн	21.7	26.5	25.2	29.8
Гурав хүртэлх насны ихэр хүүхдэд жилд 1 удаа олгох мөнгөн тусламж	1.3	0.3	0.0	0.0
Бусад	2.3	9.6	5.8	12.7
<b>Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт</b>	<b>372.9</b>	<b>396.1</b>	<b>434.8</b>	<b>434.4</b>
Нийгмийн халамжийн үйлчилгээ	21.9	24.1	32.4	7.7
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт	112.1	126.0	140.0	161.8
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлсэн тусламж	205.0	202.5	208.1	208.7
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн тусламж	4.1	4.8	4.9	4.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт	29.8	38.7	49.5	51.4
<b>Хүний хөгжлийн сангаас 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт олгох хүүхдийн мөнгө*</b>	<b>896.2</b>	<b>960.3</b>	<b>994.1</b>	<b>1 029.4</b>

\* Засгийн газрын 2012 оны 9-р сарын 22-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор “Хүний хөгжил сан”-гийн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу 2012 оны 10-р сарын 1-ний өдрөөс 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр 20.0 мянган төгрөг олгож байна.

Эх үүсвэр: НХҮЕГ-ын мэдээлэл

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтөд хамрагдагчид 2015 онд 2012 оныхоос 15.2 хувь, 2013 оныхоос 7.2 хувь, 2014 оныхоос 2.2 хувиар өссөн байна.

Хүний хөгжил сангаас 2015 онд давхардсан тоогоор 1.0 сая хүүхдэд 246.6 тэрбум төг зарцуулсан бол 2012 онд 896.2 мянган хүүхдэд 53.3 тэрбум төг олгосон байна.





## IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### 4.1. БОЛОВСРОЛ

#### 1. Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)

Ерөнхий боловсролын сургууль 2005-2006 оны хичээлийн жилээс 11 жилийн тогтолцоонд шилжиж, 7 настай хүүхдийг 1-р ангид элсүүлэх болсноор 6 хүртэлх насны хүүхдийг, 2008-2009 оны хичээлийн жилээс 12 жилийн тогтолцоонд шилжиж, 6 настай хүүхдийг нэгдүгээр ангид элсүүлэх болсноор 5 хүртэлх насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж байна.

Цэцэрлэгийн тоо 2012-2015 онд дунджаар 1118 болж, 2008-2011 оны дунджаас 289 буюу 34.9 хувиар нэмэгдсэний зэрэгцээ цэцэрлэгт хүмүүжиж байгаа хүүхэд 2012-2015 оны дунджаар 175.7 мянга болж, 2008-2011 оны дунджаас 58.8 мянга буюу 50.3 хувиар нэмэгдэв. Мөн хувилбарт сургалтад 2015 онд 23.6 мянган хүүхэд хамрагдсан нь 2012 оныхоос 7.2 мянган хүүхэд буюу 18 хувиар буурсан байна.

**Хүснэгт 4.1. Цэцэрлэг, түүнд хамрагдсан хүүхэд, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж % 2008-2011 оны дундаж
Цэцэрлэгийн тоо	829	945	1 067	1 171	1 288	1 118	134.9
Хүүхдийн тоо (мян. хүүхэд)	116.9	150.2	167.9	183.0	201.8	175.7	150.3

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

Нийт 127 цэцэрлэгийн барилгыг 2012-2015 онд шинээр ашиглалтад оруулж, хүүхдийн цэцэрлэгийн хүчин чадлыг 12735 ороор нэмэгдүүлэв. Шинэ цэцэрлэг ашиглалтад орсноор 31750 хүүхэд хамрагдаж, 1016 багш, 2540 иргэн шинээр ажилтай боллоо. Мөн хугацаанд 296 гэр цэцэрлэгийг шинээр байгууллаа. Энэ бүхний үр дүнд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 2015-2016 оны хичээлийн жилд 68.5 хувь, бохир жин 78.1 хувь болж өслөө.

**Хүснэгт 4.2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хүүхэд, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж % 2008-2011 оны дундаж
СӨБ-д хамрагдсан хүүхэд	148.6	181.0	193.7	206.6	225.4	201.7	135.7
Хувилбарт сургалтад хамрагдсан хүүхэд	31.7	30.8	25.8	23.7	23.6	26.0	82.0
Цэцэрлэгт хамрагдсан хүүхэд	116.9	150.2	167.9	183.0	201.8	175.7	150.3

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

Өмчийн хэлбэрийг үл харгалзан цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох норматив зардлыг төрөөс олгох, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 50 хувиар нэмэгдүүлсэн нь сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлсэн байна.

#### IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

##### 2.Бага, суурь боловсрол.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2007 оны 405 дугаар тушаалын дагуу ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг 2008-2009 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж, 2014-2015 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүллээ.

**Хүснэгт 4.3. Ерөнхий боловсролын сургуулийн тоо, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж	
							%	
							2012-2015 оны дундаж	2008-2011 оны дундаж
Баруун бүс	152	155	155	155	155	155		102.0
Хангайн бүс	168	167	167	168	172	169		100.6
Төвийн бүс	156	156	158	158	158	158		101.3
Зүүн бүс	67	66	68	67	68	67		100.0
Улаанбаатар	208	211	208	214	215	212		101.9
<b>Бүгд</b>	<b>752</b>	<b>755</b>	<b>756</b>	<b>762</b>	<b>768</b>	<b>760</b>		<b>101.1</b>


Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн тоо 2012-2015 оны дунджаар 760 болж, 2008-2011 оны дунджаас 8-аар буюу 1.1 хувиар нэмэгджээ. Харин ЕБС-д суралцагчид тоо 2015-2016 оны хичээлийн жилд 535.1 мянга болж, 2012-2013 оны хичээлийн жилийнхээс 39.0 мянгаар буюу 7.9 хувиар өссөн байна.

Бага, суурь боловсролын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, бага ангийн суралцагчид “Үдийн цай” хөтөлбөрт хамруулах, эмзэг бүлгийн өрхийн хүүхдийг хичээлийн хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэн, төрөөс сурагчдыг сурах бичгээр хангах, дотуур байрны хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд бага боловсролын хамран сургалтын бохир жин 2015 онд 2012 оныхтой харьцуулахад 1.4 пунктээр өсч, 99.3 хувь, суурь боловсролын хамран сургалтын бохир жин 2.6 пунктээр өсч 96.9 хувь боллоо.

Бага боловсролын цөм хөтөлбөрийг 283 эрдэмтэн, багш, судлаачид үндэсний болон олон улсын судалгаа, туршилтын үр дүнд боловсруулж Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 240 тоот тушаалаар батлагдан 756 сургуулийн 13817 багш, 229800 сурагчийн хүрээнд хэрэгжүүлж байна.


**Зураг 4.1. Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт, хувиар, 2011-2015**



#### IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн тоо 2015 онд 28.5 мянга болж, 2012 оныхоос 2.0 мянга буюу 7.5 хувиар өссөн бөгөөд бага ангийн багш 1.0 мянга, дунд ангийн багш 0.6 мянга, ахлах ангийн багш 0.1 мянгаар нэмэгджээ.

**Зураг 4.2. Ерөнхий боловсролын сургуулийн багш, мян.хүн, 2012-2015**



ЕБС-ийн нэг багшид ногдох сурагчийн тоо 2008-2011 онд дунджаар 19.8 байсан бол 2012-2015 онд дунджаар 18.5 болж буурсан байна.

**Хүснэгт 4.4. Ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагчид, мян.хүн, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
Үндсэн багш	26.1	26.9	27.2	27.4	28.5	27.5	105.4
Суралцагчид	518.0	496.1	497.0	505.8	535.1	508.5	98.2
1 багшид ногдох сурагчийн тоо	19.8	18.4	18.3	18.5	18.8	18.5	93.4

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

### 3. Техникийн болон мэргэжлийн боловсрол

2015-2016 оны хичээлийн жилд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 81 төв (МСҮТ) үйл ажиллагаа явуулж байгаагийн 49 нь төрийн өмчийн, 32 нь хувийн өмчийн сургууль байна. МСҮТ 2012-2015 онд 2008-2011 оны дундажтай харьцуулахад 14-өөр буюу 21.9 хувиар нэмэгдсэн байна.

**Хүснэгт 4.5. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тоо, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв	64	75	79	76	81	78	121.9
Үүнээс: Төрийн өмчийн	45	49	53	52	49	51	113.3
Хувийн өмчийн	20	26	26	24	32	27	135.0

Эх үүсвэр: Хөдөлмөрийн яамны мэдээлэл

МСҮТ-д 2012-2015 онд дунджаар 43.4 мянган оюутан суралцаж байсан нь 2008-2011 оны дундажтай харьцуулахад 0.8 мянга буюу 1.8 хувиар буурав. МСҮТ-д 2015-2016 оны хичээлийн жилд шинээр элсэгчдийн 49.6 хувь нь суурь боловсрол эзэмшигчид байна.

#### IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

##### Хүснэгт 4.6. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчид, төгсөгчид, багш, мян.хүн, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж % 2008-2011 оны дундаж
Суралцагчид	44.2	45.2	42.8	42.8	42.7	43.4	98.2
Төгсөгчид	12.5	23.4	18.4	19.0	-	20.3	162.4
Үндсэн багш	2.0	2.2	2.5	2.3	2.5	2.4	120.0

Эх үүсвэр: Хөдөлмөрийн яамны мэдээлэл

МСҮТ-ийг төгсөгчид 2008-2011 онд жилд дунджаар 12.5 мянга төгсөж байсан бол 2012-2015 онд 20.3 мянга болж, 62.4 хувиар нэмэгджээ. МСҮТ-д багшлах боловсон хүчний тоо сүүлийн 4 жилд өсөх хандлагатай байна.

#### 4. Дээд боловсрол

2015-2016 оны хичээлийн жилийн эхэнд нийт 100 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байгаагийн 17 нь төрийн өмчийн, 78 нь төрийн өмчийн бус сургууль, 5 нь гадаадын их сургуулийн салбар сургууль байна. Эдгээрийн 91 нь Улаанбаатар хотод, 9 сургууль нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

##### Хүснэгт 4.7. Дээд боловсролын сургалтын байгууллага, суралцагчид, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж % 2008-2011 оны дундаж
Их, дээд сургууль, коллежийн тоо	129	99	100	101	100	100	77.8
Суралцагчид	167 202	175 591	174 045	178 295	162 626	172 639	103.3

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллеж 2008-2011 онд жилд дунджаар 129 байсан бол 2012-2015 онд энэ үзүүлэлт 100 болж, 22.2 хувиар буурсан байна. Сургуулийн тоо цөөрсөн нь Засгийн газрын 2010 оны 15, 2011 оны 229 дүгээр тогтоолоор төрийн өмчийн 42 сургуулийг 15 болгон өөрчлөн зохион байгуулсан, хувийн өмчийн зарим сургуулиуд өөр хоорондоо нэгдэх, сургалтын үйл ажиллагаагаа зогсоох зэргээр бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөд орсон, аттестатчилалд тэнцээгүй 6 сургуулийг татан буулгасан зэрэгтэй холбоотой юм.

Их, дээд сургууль, коллежид 2012-2015 онд дунджаар 172.6 мянган хүн суралцаж байгаа нь 2008-2011 оны дунджаас 3.3 хувиар нэмэгджээ.

##### Хүснэгт 4.8. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, сургалтын хэлбэрээр

	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2012-2015 оны дундаж % 2008-2011 оны дундаж
Бакалавр	155 801	152 708	155 839	140 296	90.0
Магистрантур	16 630	18 063	19 065	19 005	114.3
Докторантур	3 160	3 304	3 391	3 325	105.2
Бүгд	175 591	174 075	178 295	162 626	92.6

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

#### IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

Их, дээд сургууль, коллежид суралцагчид 2015-2016 оны хичээлийн жилд 140.3 мянга буюу 86.3 хувь нь бакалаврын түвшний сургалтад хамрагдаж, 2012-2013 оныхтой харьцуулахад 15.5 мянга буюу 10.0 хувиар буурлаа. Сүүлийн 4 жилийн дүнгээс харахад бакалаврын боловсрол олгох сургалтад хамрагдагчид буурч, магистр болон докторын сургалтад хамрагдагчид нэмэгдэж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагад багш, инженер, технологи, байгалийн шинжлэл, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн мэргэжлээр бакалаврын түвшинд суралцагчид 2012-2013 оны хичээлийн жилд нийт бакалаврын түвшинд суралцагчдын дотор 48.8 хувийг эзэлж байсан бол 2015-2016 оны хичээлийн жилд 51.4 хувь байна.

#### Хүснэгт 4.9. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, мэргэжлийн чиглэлээр

Мэргэжлийн чиглэл		2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016
Бакалаврын түвшинд суралцагчид		155 801	152 708	155 839	140 296
Үүнээс:	Багш	20 317	19 596	20 492	18 884
	Байгалийн шинжлэл	5 061	5 070	6 334	5 009
	Инженер, технологи	31 219	31 464	31 278	29 084
	Эрүүл мэнд	14 323	15 261	16 671	16 086
	Хөдөө аж ахуй	5 062	4 516	3 862	3 032
	<b>Бүгд</b>	<b>75 982</b>	<b>75 907</b>	<b>78 637</b>	<b>72 095</b>
Бакалаврын түвшний суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувь		48.8	49.7	50.5	51.4

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

Засгийн газрын “Өрсөлдөх чадвартай Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд өндөр хөгжилтэй оронд суралцагчдын тоог нэмэгдүүлж, гадаадын нэр хүндтэй сургуулиудад монголын хөгжилд тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр бакалавр, магистрантур, докторантурт 2012 онд 920 оюутан суралцуулахаар илгээж байсан бол 2015 онд 1082, 2012-2015 онд нийтдээ 3915 оюутан илгээсэн байна.

#### Хүснэгт 4.10. Гадаадын их, дээд сургуульд элсэгчид, 2012-2015

	2012	2013	2014	2015	Бүгд
Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр суралцаж буй оюутан, магистр, доктор	150	139	186	158	633
Засгийн газрын хэлэлцээрийн дагуу суралцаж буй оюутан	518	506	538	924	2486
Засгийн газрын хэлэлцээрийн дагуу суралцаж буй магистр, доктор	252	254	290	-	796
<b>Бүгд</b>	<b>920</b>	<b>899</b>	<b>1014</b>	<b>1082</b>	<b>3915</b>

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

## IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### 4.2. СОЁЛ, УРЛАГ

Улсын хэмжээнд 2015 онд мэргэжлийн урлагийн 36 байгууллага, 44 музей, нийтийн 370 номын сан, 341 соёлын төв, ордон, 4 кино театр, 26 кино үзвэрийн цэг буюу төрийн болон хувийн өмчийн соёл, урлагийн 821 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

**Хүснэгт 4.11. Соёл, урлагийн байгууллагын тоо, 2012-2015**

Үзүүлэлт	2012	2013	2014	2015
Урлагийн байгууллага	36	36	35	36
Музей	43	43	43	44
Нийтийн номын сан	377	376	380	370
Соёлын ордон	342	342	343	341
Кино үзвэрийн байгууллага	21	23	30	30
<b>Бүгд</b>	<b>819</b>	<b>820</b>	<b>831</b>	<b>821</b>


Улсын соёл урлагийн байгууллагын ажиллагчдын тоо 2012-2015 онд дунджаар 6863 болж, 2008-2011 дундажтай харьцуулахад 768 буюу 12.6 хувиар нэмэгдсэн байна. Ажиллагчдын тооны өсөлт соёлын төв, музей, киноны байгууллагуудад хамгийн өндөр байна. Засгийн газрын шийдвэрээр сумын төвийн орон тоог 5 (соёлын төвийн эрхлэгч, номын санч, дуу хөгжмийн багш, бүжгийн багш, үйлчлэгч) байхаар тогтоож өгсөн нь нөлөөлжээ.

**Хүснэгт 4.12. Соёл, урлагийн байгууллагын ажиллагчид, 2012-2015**

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
Урлагийн байгууллага (театр, чуулгаа, цирк)	2 554	2 800	2 822	2 707	2 687	2 754	107.8
Музей	578	646	671	634	645	649	112.3
Нийтийн номын сан	455	515	575	571	560	555	122
Соёлын төв, ордон	2 342	2 602	2 669	2 607	2 594	2 618	111.8
Киноны байгууллага	167	282	274	294	297	287	171.8
<b>Бүгд</b>	<b>6 095</b>	<b>6 845</b>	<b>7 011</b>	<b>6 813</b>	<b>6 783</b>	<b>6863</b>	<b>112.6</b>

Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын тоо 2015 онд 4442 болж, 2012 оныхоос 5.4 хувиар буурсан боловч Олон улсын бүжгийн фестиваль, Морин хуурын фестиваль, Авьяаслаг Монголчууд зэрэг олон томоохон арга хэмжээ 2015 онд зохион байгуулснаар мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчид 4642.7 мянга болж өссөн байна.

**Зураг 4.3. Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолт, үзэгчид, 2012-2015**





#### IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД


Нийт номын сангийн 355 нь төрийн өмчийн номын сан, 15 нь төрийн бус өмчийн номын сан байна. Номын сангаар 2012-2015 онд жилд дунджаар 283.3 мян.хүн үйлчлүүлсэн нь 2008-2011 оныхоос 18.5 мян. хүн буюу 5.1 хувиар буурчээ.

**Хүснэгт 4.13. Номын сан, суудлын тоо, байнгын уншигчид, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Номын сан	370	377	376	380	370	376
Номын сангийн суудлын тоо	10.4	10.7	10.6	10.7	10.7	10.8
Номын фонд, мян.ш	6779.9	6726.5	6818.9	6767.8	6592.2	6726.3
Байнгын уншигчид мян.хүн	301.8	311.5	284.4	286.1	263.2	286.3

Музейн үзмэр 2015 онд 269.0 мянга болж, 2012 оныхоос 6.8 хувиар өсч, үзэгчид 2015 онд 583.4 мянга болж, 2012 оныхоос 2.5 хувиар буурчээ. Нийт үзэгчдийн 2015 онд 121.8 мянга буюу 21.9 хувь нь гадаадын үзэгчид, 193.1 мянга буюу 33 хувь нь хүүхэд байна.

**Зураг 4.4. Музейн үзмэр, үзэгчид, 2012-2015**



#### **Соёлын өв**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар түүх, соёлын дурсгалт зүйлийг хосгүй үнэт, үнэт, ердийн гэсэн 3 зэрэглэлд ангилдаг. Хосгүй үнэт дурсгал нь Засгийн газрын тогтоолоор улсын бүртгэлд авсан түүх, археологийн ховор нандин олдвор, цутгуур баримал, зураг, зээгт наамал, цаасан шуумал зэрэг дүрслэх урлагийн бүтээлүүд, түүхэн бие хүний холбогдолтой эд өлгийн зүйлс, палеонтологийн олдвор болон байгалийн ховор дээжис зэрэг төрөл зүйлийн дурсгал юм. Соёлын өвийн төвд бүртгэгдсэн түүх, соёлын хосгүй үнэт дурсгал зүйл 2013 онд 776 болж, 2010 оныхоос 30.9 хувиар өссөн байна (Зураг 4.5).

**Зураг 4.5. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгал зүйл, 2006-2013**



## IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### 4.3. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ

Улсын хэмжээнд 2015 оны байдлаар төрийн өмчийн 32, төрийн бус өмчийн 6 эрдэм шинжилгээний байгууллага ажиллаж байна. Түүнчлэн их сургуулиудын дэргэд судалгаа, шинжилгээний ажил хийгдэж байна.

**Хүснэгт 4.14. Шинжлэх ухааны байгууллага, 2012-2015**

	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2012}$ %
Төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага	49	49	49	32	65.3
Төрийн бус өмчийн эрдэм шинжилгээний байгууллага	10	7	7	6	60.0
Их сургууль	11	15	15	21	190.9
<b>Бүгд</b>	<b>70</b>	<b>71</b>	<b>71</b>	<b>59</b>	<b>84.3</b>

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

Төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага 2015 онд 2012 оныхоос 34.7 хувь, төрийн бус өмчийн эрдэм шинжилгээний байгууллагынх 40.0 хувиар буурч, харин их сургууль 90.9 хувиар өссөн байна.

**Хүснэгт 4.15. Шинжлэх ухааны байгууллагын ажиллагчид, 2012-2015**

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	$\frac{2012-2015 \text{ оны дундаж}}{2008-2011 \text{ оны дундаж}}$ %
Нийт ажиллагчид	3 893	4 071	4 411	4 374	4 125	4 245	109.0
Үндсэн ажиллагчид	2 501	2 672	2 694	2 724	2 515	2 651	106.0
Үүнээс: Эрдэм шинжилгээний ажилтан	1 582	1 633	1 712	1 725	1 720	1 698	107.3
Гэрээт ажиллагчид	1 392	1 399	1 717	1 650	1 610	1 594	114.5

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

Шинжлэх ухааны байгууллагын нийт ажиллагчид 2012-2015 онд дунджаар 4245 болж, 2008-2011 оны дундажтай харьцуулахад 352 буюу 9.0 хувиар нэмэгджээ. Энэ хугацаанд гэрээгээр хавсран ажиллагчид 14.5 хувь, эрдэм шинжилгээний ажилтны тоо 7.3 хувь, орон тооны үндсэн ажиллагчид 6.0 хувиар өсчээ.

Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, УИХ-ын Нийгмийн бодлого, Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2014 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн 07 тоот тогтоолоор шинжлэх ухааны салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх сайжруулах талаар арга хэмжээ авах зорилгоор 2014 оны байдлаар Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр нийт 192 төсөл санхүүжүүлэн хэрэгжүүлж, эдгээр ажилд 2 тэрбум 766 сая төгрөгийн эрдэм шинжилгээний зардал олгосон байна.


Шинжлэх ухаан технологийн сангаас Шинжлэх ухааны байгууллагуудад хуваарилагддаг төсвийн хэмжээ сүүлийн 3 жилийн байдлаар өсч, эрдэм шинжилгээний ажлын зардалд 9.2 тэрбум төгрөгийг зарцуулсан нь ДНБ-ий 0.2 хувийг эзэлж байна.

4.4. ЭРҮҮЛ МЭНД

**Эрүүл мэндийн салбарын хүний нөөц**

Эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчид 2015 онд 47.4 мянга байгаагийн 9.6 мянга нь их эмч, 11.4 мянга нь сувилагч, 1.5 мянга нь эм зүйч байна. Улсын хэмжээнд 2012-2015 оны дунджаар 10 000 хүн амд ногдох их эмч 32, сувилагч 37 байгаа нь 2008-2011 оны дундажтай харьцуулахад их эмч 4, сувилагч 3 пунктээр нэмэгдсэн байна.

**Зураг 4.6. 10 000 хүн амд ногдох эмнэлгийн ажилтан, 2012-2015**



Нэг их эмчид 1.2 сувилагч байгаа нь олон улсын жишгээс 2 дахин бага байна. Эмнэлгийн орны тоо 2015 онд 21.7 мянга болж, 2012 оныхоос 10.9 хувиар өсчээ.

**Эх хүүхдийн эрүүл мэнд**

Нялхсын эндэгдэл 2015 онд 1234 болж, 2012 оныхоос 7.9 хувь, 2013 оныхоос 5.8 хувиар өсч, 2014 оныхоос 1.4 хувиар буурсан байна. Нялхсын эндэгдэл 2012-2015 онд 2008-2011 оныхоос 5.1 хувиар буурчээ. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2015 онд 1476 болж, 2012 оныхоос 5.7 хувь, 2013 оныхоос 2.6 хувиар өсч, 2014 оныхоос 1.9 хувиар буурсан байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2012-2015 оны дунджийг 2008-2011 оныхтой харьцуулахад 5.3 хувиар буурсан байна.

**Зураг 4.7. Эх, хүүхдийн эндэгдэл, 2012-2015**



Улсын хэмжээнд 2015 онд 21 эх эндсэн нь 2012 оныхоос 44.7 хувь, 2013 оныхоос 38.2 хувь, 2014 оныхоос 16.0 хувиар, 2012-2015 оны дунджийг 2008-2011 оныхтой харьцуулахад 22.4 хувиар буурсан байна.

Манай улсын хувьд нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буурай хөгжилтэй, хөгжиж буй орон, дэлхийн дундажтай харьцуулахад доогуур түвшинд байна.

#### IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

##### Хүснэгт 4.16. Нялхсын болон тав хүртэлх насны хүүхэд, эхийн эндэгдлийн түвшин, 2012-2015


Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	19	15	15	15	15	15
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	23	19	18	18	18	22
Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	56	51	43	30	26	38

Хүснэгтээс харахад нялхсын, тав хүртэлх насны хүүхдийн болон эхийн эндэгдлийн түвшин 2012-2015 оны дунджийг 2008-2011 оныхтой харьцуулахад буурсан байна. Манай улсад 2004 оноос хойш улсын хэмжээнд эх, хүүхдийн эндэгдэл тогтвортой буурч байгаа нь хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчинг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2004 оны 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” (2004-2015), төрөлтийг дэмжих замаар хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, улмаар хүн амаа өсгөх бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 2008 оны 12 дугаар тогтоолоор “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2007-2015), эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих замаар монгол хүний хөгжлийг хангах таатай орчинг бүрдүүлж, Мянганы Хөгжлийн Зорилтыг хэрэгжүүлэхээр Засгийн газраас 2012 оны 61 дүгээр тогтоолоор “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний дөрөв дэх хөтөлбөр (2012-2016)-ийг баталж, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой.

#### Халдварт, халдварт бус өвчлөл

Улсын хэмжээнд 2015 онд 30 төрлийн цочмог халдварт өвчин бүртгэгдэж, халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 59.4 мянгад хүрчээ. Энэ нь 2012 оныхоос 37.2 хувь, 2013 оныхоос 59.2 хувь, 2014 оныхоос 77.2 хувиар, 2012-2015 оны дунджийг 2008-2011 оныхтой харьцуулахад 4.0 хувиар өсчээ. Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид дунд вирүст гепатитаар өвчлөгчид 2008-2011 оны дунджаар хамгийн их хувийг эзэлдэг байсан бол 2012-2015 онд дунджаар 3.6 дахин буурсан байна.


Зураг 4.8. 10 000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчид, 2012-2015



Гахайн хавдраар өвчлөгчид 2012 онд 9060 буюу 20.9 хувийг эзэлж байсан бол 2013 онд 5268 буюу 14.1 хувь болж, 2012 оныхоос 41.9 хувиар буурчээ.

Тэмбүүгээр өвчлөгчид 2013 онд 6246 болж, 2012 оныхоос 26.1 хувиар өсч, нийт халдварт өвчлөлд хамгийн их хувийг эзэлж байна. Гар, хөл, амны өвчин 2013 онд 2012 оныхтой харьцуулахад 3.5 дахин өсчээ.


Зураг 4.9. Халдварт өвчнөөр өвчлөгчид, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2012-2015



Халдварт өвчнийг төрлөөр авч үзвэл улаанбурхан өвчний тохиолдол 2015 онд шинээр 23464 бүртгэгдсэн бөгөөд нийт халдварт өвчлөлийн хамгийн их буюу 39.5 хувийг эзэлж байна. Халдварт өвчнөөр өвчлөгчид 2015 онд 2014 оныхоос 25884 хүн буюу 77.2 хувиар өсөхөд тэмбүүгээр өвчлөгчид 788 буюу 11.4 хувь, салхин цэцгээр өвчлөгчид 985 буюу 21.2 хувь, цусан суулгаар өвчлөгчид 425 буюу 18.4 хувь, гонококкт халдвараар өвчлөгчид 419 буюу 9.2 хувь, трихомонизаар өвчлөгчид 215 буюу 5.6 хувь, сүрьеэгээр өвчлөгчид 98 буюу 2.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын хэмжээнд 10 000 хүнд ногдох улаанбурхан өвчний тохиолдол 2015 онд 79 болж аймаг, нийслэлээр харвал Улаанбаатар хотод хамгийн их буюу улсын дунджаас 67-оор, Өмнөговь аймагт 3-аар их, бусад аймагт улсын дунджаас бага байна.

Зураг 4.10. Улаанбурхан өвчнөөр өвчлөгчид, 10 000 хүн амд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2015




#### IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

Улаанбурханаар өвчлөгчдийг насны бүлгээр авч үзвэл нийт өвчлөгчдийн 30.6 хувийг 0-14 насны хүүхэд, үүнээс 1 хүртэлх насны хүүхэд 15.5 хувь, 48.1 хувийг 15-24 насныхан, 16.4 хувийг 25-34 насныхан, 5.0 хувийг 35-аас дээш насныхан эзэлж байна.

Сүүлийн 4 жилд халдварт өвчнөөр өвчлөгчдийн дунд тэмбүүгээр өвчлөгчид хамгийн их хувийг эзэлж, 2012-2015 оны дунджийг 2008-2011 оныхтой харьцуулахад 42.4 хувиар өссөн байна.

**Зураг 4.11. ХДХВ/ДОХ, тэмбүүгээр өвчлөгчид, 2012-2015**



Улсын хэмжээнд ХДХВ/ДОХ-ын тохиолдол 2015 онд 18 илэрч, нийт 199 тохиолдол бүртгэгджээ. ХДХВ/ДОХ-ын тохиолдол 2012 онд 27, 2013 онд 23 болж буурсан бол 2014 онд хамгийн их буюу 31 тохиолдол бүртгэгдсэн байна.

**Зураг 4.12. Хүн амын халдварт бус өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд ногдохоор, 2012-2015**



Халдварт бус өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж байгаа амьсгалын тогтолцооны өвчлөл (10 000 хүн амд ногдох) 2012 оныхоос 351, 2013 оныхоос 103-аар нэмэгдэж, 2014 оныхоос 131-ээр буурчээ. Харин 2012-2015 оны дунджийг 2008-2011 оныхтой харьцуулахад 349-өөр нэмэгдсэн байна. Зүрх, судасны тогтолцооны өвчин 2008-2011 онд халдварт бус өвчлөлийн тэргүүлэх 5 өвчлөлийн 4 дүгээрт орж байсан бол 2012-2015 онд 3 дугаарт орсон байна.



**Хүн амын нас баралт**

Манай улсын хүн амын нас баралтыг зонхилох шалтгаанаар авч үзвэл, 1991 онд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 1992 оноос эхлэн одоог хүртэл зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна.

Нас баралтын шалтгааныг өвчний ангиллаар нь сүүлийн 8 жилийн байдлаар авч үзвэл нийт нас баралтад зүрх, судасны тогтолцооны өвчин 2009 онд хамгийн их буюу 38.0 хувийг эзэлж байсан бол үүнээс хойш буурсаар 2015 онд 34.1 хувийг эзэлж байна. Нас баралтын 2 дахь шалтгаан болсон хавдрын өвчлөлд хорт хавдрын өвчлөл их байгаа бөгөөд 10 000 хүнд 13.5 ногдож байна.

**Хүснэгт 4.17. Нас баралт, өвчний ангилал, дүнд эзлэх хувиар, 2008-2015**

Өвчний бүлэг	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:								
Зүрх судасны тогтолцооны өвчин	36.1	38.0	37.7	36.7	35.1	35.1	34.4	34.1
Хавдар	20.8	20.8	20.8	20.6	21.2	23.4	24.3	24.6
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант өвчин	16.4	15.2	16.1	18.3	18.9	17.2	16.7	15.7
Амьсгалын тогтолцооны өвчин	4.2	4.8	4.3	3.9	3.8	3.4	3.5	3.7
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	9.3	8.5	8.5	9.0	8.9	8.4	7.7	8.0
Халдварт ба шимэгчит зарим өвчин	2.2	1.7	2.1	1.8	1.8	1.9	1.9	2.0
Шээс, бэлгийн тогтолцооны эмгэг	1.9	1.9	1.6	1.5	1.2	1.1	1.3	1.6
Төрөх тойрны (перинаталь) үед үүсэх зарим эмгэг	4.3	4.7	3.8	3.4	3.7	3.8	4.2	4.5
Мэдрэлийн тогтолцооны өвчин	1.7	1.5	1.8	1.6	1.9	1.8	1.9	1.9
Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг	0.2	0.1	0.2	0.1	0.1	0.1	0.1	0.2
Бусад	3.0	2.9	3.0	3.3	3.4	3.8	3.9	3.7

10 000 хүн амд ногдох нас баралт 2015 онд 55.2, эрэгтэйчүүдийнх 33.1, эмэгтэйчүүдийнх 22.1 байна. Нийт нас барсан хүмүүсийн 60.0 хувийг эрэгтэйчүүд, 40.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Зүрх судасны тогтолцооны өвчин хүйс харгалзахгүйгээр хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан хэвээр байна. Хавдраар нас барагчдыг хүйсээр авч үзэхэд 55.1 хувь нь эрэгтэйчүүд байна.

**Зураг 4.13. Нас баралтын шалтгаан, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2015**





#### IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

Нас баралтын 3 дахь шалтгаанд эрэгтэйчүүдийн хувьд гэмтэл, хордлого ба гадны шалтгаант өвчин, эмэгтэйчүүдийн хувьд хоол боловсруулах тогтолцооны өвчин орж байна. Зүрх, судасны тогтолцооны өвчнөөс зүрхний шигдээс, тархины цус харвалт, хавдраар нас барагчдын дунд элэг, ходоодны хавдар ихэнх хувийг эзэлж байна.

#### 4.5 ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд төрөөс иргэдийг орон сууцаар хангах ажлыг шат дараатай авч хэрэгжүүлсний үр дүнд сүүлийн жилүүдэд сууцны талбайгаар тооцсон орон сууцны сан тасралтгүй өссөн байна.

Орон сууцны сан 2015 онд 14365.6 мянган м<sup>2</sup> болж, 2012 оныхоос 3772.8 мянган м<sup>2</sup> буюу 35.6 хувиар, 2013 оныхоос 2866.4 мянган м<sup>2</sup> буюу 24.9 хувиар, 2014 оныхоос 1262.9 мянган м<sup>2</sup> буюу 9.6 хувиар өсчээ.

#### Хүснэгт 4.18. Ашиглалтад оруулсан орон сууц, орон сууцны сан, талбайгаар, 2012-2015

	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2012}$ %
Орон сууцны сан*, сууцны талбайгаар, мян.м <sup>2</sup>	10 592.8	11 499.2	13 102.7	14 365.6	135.6
<b>Ашиглалтад оруулсан орон сууц, мян.м<sup>2</sup></b>					
Нийт талбай	606.4	1 237.3	1 898.2	2 308.7	380.7
Төрийн	12.5	17.4	31.3	27.2	218.0
Хувийн	593.9	1 219.9	1 866.9	2 281.5	384.2
Сууцны талбай	530.5	906.4	1 603.5	1 262.9	238.1
Төрийн	9.6	9.4	30.0	22.3	231.8
Хувийн	520.9	897.0	1 573.5	1 240.6	238.2

Тайлбар: \* Гэрийн талбайг оруулаагүй.

Ашиглалтад оруулсан орон сууцны нийт талбайн хэмжээ 2012 онд 606.4 мянган м<sup>2</sup> байсан бол 2015 онд 2308.7 мянган м<sup>2</sup> болж, 1702.3 мянган м<sup>2</sup> буюу 3.8 дахин өссөн байна. Харин ашиглалтад оруулсан орон сууцыг сууцны талбайгаар авч үзвэл 2015 онд 1262.9 мянган м<sup>2</sup> болж, 2012 оныхоос 732.4 мянган м<sup>2</sup> буюу 2.4 дахин өсчээ.

Улсын хэмжээнд 2012-2015 онд нийт 75948 айлын сууц ашиглалтад оруулсан байна (Хүснэгт 4.19).

#### Хүснэгт 4.19. Ашиглалтад оруулсан орон сууц, сууцны зориулалтаар, 2012-2015

	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2012}$ %
Ашиглалтад оруулсан орон сууц	10819	17070	26905	21154	195.5
Нийтийн зориулалттай байшин	8048	14536	24380	19480	242.0
Сууцны тусдаа байшин	2771	2534	2525	1674	60.4

Ашиглалтад оруулсан сууцны дийлэнх нь нийтийн зориулалттай байшин эзэлж байна. Тухайлбал, 2012 онд 10819 айлын сууцыг ашиглалтад оруулсан бол 2015 онд 21154 айлын сууц ашиглалтад оруулж 95.5 хувиар нэмэгдсэн. Нийтийн зориулалттай орон сууцны байшин 2015 онд 2012 оныхоос 11432 айл буюу 2.4 дахин нэмэгдэж, харин сууцны тусдаа байшин 1097 буюу 39.6 хувиар буурсан байна.

Улсын хэмжээнд ус түгээх цэг 2015 онд 1725, ус тээврийн машин 191 байна. Ус түгээх цэгийн тоо 2012 оныхоос 23.1 хувиар, ус тээврийн машин 10.4 хувиар өсчээ.

#### IV. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

##### Хүснэгт 4.20. Ус түгээх цэг, ус тээврийн машин, 2012-2015

	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2012}$ %
Ус түгээх цэг	1 401	1 497	1 617	1 725	123.1
Ус тээврийн машин	173	185	178	191	110.4
Зөөврийн ус хэрэглэдэг өрх (мянгаар)	439.8	460.5	467.7	482.3	109.7

Зөөврийн ундны ус хэрэглэдэг өрхийн тоо 2015 онд 482.3 мянга болж, 2012 оныхоос 9.7 хувь, 2013 оныхоос 4.7 хувь, 2014 оныхоос 3.1 хувиар нэмэгдсэн байна.

##### Хүснэгт 4.21. Хог устгах цэгийн тоо, халуун усны үйлчилгээний цэг, 2012-2015

	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2012}$ %
Хог устгах цэг	417	380	391	389	93.3
Хог тээврийн машин	681	733	753	773	113.5
Халуун усны үйлчилгээний цэг	732	844	871	920	125.7

Хог устгах цэг 2015 онд 389 болж, 2012 оныхоос 6.7 хувиар буурсан байна. Харин хог тээврийн машин 2015 онд 773 болж, 92 буюу 13.5 хувиар, халуун усны үйлчилгээний цэг 2015 онд 920 болж, 2012 оныхоос 25.7 хувиар нэмэгджээ.



## V. БАЙГАЛЬ ОРЧИН

Байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 2015 онд урьдчилсан гүйцэтгэлээр 28.4 тэрбум төгрөгт хүрч, 2012 оныхоос 5.8 тэрбум төг буюу 25.7 хувь, 2014 оныхоос 2.9 тэрбум төг буюу 11.2 хувиар нэмэгдсэн бөгөөд 2015 онд зарцуулсан нийт хөрөнгийн 1.7 хувийг газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд, 6.4 хувийг байгаль орчны төвлөрсөн арга хэмжээнд, 14.2 хувийг ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд, 18.8 хувийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтад, 28.9 хувийг байгаль орчны алба, байгаль хамгаалагчдын үйл ажиллагаанд, 29.9 хувийг байгаль хамгаалах санд зарцуулжээ.

Ойн түймэр 2012 онд 105 удаа, 2013 онд 34 удаа, 2014 онд 62 удаа гарч байсан бол 2015 онд 184 болж, өмнөх оныхоос нэмэгдэв. Нийт түймэр гаралт 2015 онд 31 нь баруун бүсэд, 56 нь хангайн бүсэд, 74 нь төвийн бүсэд, 12 нь зүүн бүсэд, 11 нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гарчээ.

### 5.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САН

Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолын дагуу газрын нэгдмэл сангийн мэдээллийг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас жил бүр гаргаж, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлж байна.

#### Хүснэгт 5.1. Монгол Улсын газрын нэгдмэл сан, үндсэн ангиллаар, мян.га, 2012-2015

	2012	2013	2014	2015
Нийт талбайн хэмжээ	156 411.6	156 411.6	156 411.6	156 411.6
Хөдөө аж ахуйн газар	115 399.9	115 361.4	115 008.6	114 982.8
Хот, тосгон, бусад суурины газар	702.0	699.6	712.1	716.9
Зам, шугам, сүлжээний газар	435.3	437.3	454.8	462.5
Ойн сан бүхий газар	14 256.5	14 295.4	14 320.5	14 334.4
Усны сан бүхий газар	686.8	686.7	686.7	686.1
Тусгай хэрэгцээний газар	24 931.1	24 931.1	25 228.9	25 228.9

Эх үүсвэр: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын мэдээлэл

Монгол Улсын “Газрын тухай” хуулинд заасан газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзэхэд 2015 онд нийт нутгийн 73.5 хувийг хөдөө аж ахуйн газар, 16.1 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 9.2 хувийг ойн сан бүхий газар, 0.5 хувийг хот, тосгон, бусад суурины газар, 0.4 хувийг усны сан бүхий газар, 0.3 хувийг зам, шугам, сүлжээний газар эзэлж байна.

Хохирол учирсан газрын талбай 2012 онд 8370.0 мян.га, 2013 онд 9014.7 мян.га, 2014 онд 9390.5 мян.га байсан бол 2015 онд 9575.4 мян.га болж, 2014 оныхоос 184.9 мян.га буюу 2.0 хувиар өсчээ. Хохирол учирсан газрын 2015 онд 9099.9 мян.га буюу 95.0 хувь нь бэлчээр болон бусад өвслөг газар, 339.2 мян.га буюу 3.5 хувь нь ойн сан бүхий газар, 120.3 мян.га буюу 1.3 хувь нь тариалангийн газар, 10.0 мян.га буюу 0.1 хувь нь хот, суурины газар, 5.9 мян.га буюу 0.1 хувь нь ухагдаж эвдэрсэн газар, 0.2 мян.га буюу 0.002 хувь нь усны сан бүхий газар байна.

## V. БАЙГАЛЬ ОРЧИН

### 5.2. ЦАГ УУР

Олон улсын шинжээчдийн хамтран гаргасан дэлхийн цаг агаарын үнэлгээнд тулгуурлаж тооцсоноор 1990 оныхтой харьцуулахад 2020 онд Монголын цаг агаар бүхэлдээ 2 хэмээр дулаарах төлөвтэй байна. Манай улсын ДНБ-ний 10.0 гаруй хувийг эзэлдэг хөдөө аж ахуйн салбар нь байгаль орчин, ус цаг уур, уур амьсгалын шууд нөлөөн дор оршдог онцлогтой тул сүүлийн жилүүдэд цаг уур, уур амьсгалд гарч буй өөрчлөлт зүй ёсоор анхаарал татаж байна.

**Хүснэгт 5.2. Агаарын жилийн дундаж температур (C°)  
аймгийн төв, нийслэлээр, 2012-2015**

Аймгийн төв, нийслэл	2012	2013	2014	2015
<b>Баруун бүс</b>				
Өлгий	0.2	2.4	1.2	2.3
Алтай	-1.6	0.3	-0.4	0.2
Улиастай	-2.3	-1.0	-1.2	-0.6
Улаангом	-3.1	-0.9	-1.9	-0.4
Ховд	0.6	2.2	1.6	3.1
<b>Хангайн бүс</b>				
Цэцэрлэг	0.2	1.8	1.4	2.1
Баянхонгор	-0.5	1.4	1.1	1.5
Булган	-2.0	-0.7	-0.2	0.5
Эрдэнэт	-0.7	0.4	1.2	2.2
Арвайхээр	0.7	2.2	2.2	3.1
Мөрөн	-1.1	0.5	0.8	1.5
<b>Төвийн бүс</b>				
Чойр	0.0	1.5	3.0	2.9
Сайншанд	4.1	6.6	7.6	5.4
Мандалговь	1.2	2.5	3.3	3.2
Даланзадгад	4.4	6.5	6.4	6.1
Дархан	-0.3	0.7	1.6	1.9
Сүхбаатар	-0.1	0.3	1.0	1.0
Зуунмод	-2.3	-0.9	-0.1	0.6
<b>Зүүн бүс</b>				
Чойбалсан	0.2	1.2	2.8	2.8
Баруун-Урт	0.3	1.2	2.7	2.6
Өндөрхаан	-1.3	0.1	1.1	1.1
<b>Улаанбаатар</b>				
Улаанбаатар	-1.1	0.1	1.0	1.7

Эх үүсвэр: Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны мэдээлэл

Аймгийн төв, нийслэл хотын агаарын дундаж хэмийг авч үзвэл 2012 онд -0.2 хэм, 2013 онд 1.3 хэм, 2014 онд 1.6 хэм, 2015 онд 2.0 хэм болж, 2015 онд 2012 оныхоос 2.2 хэмээр дулаан байлаа. Хамгийн дулаан нь 2015 оны дунджаар Өмнөговь аймгийн Даланзадгад суманд 6.1 хэм, хамгийн хүйтэн нь Завхан аймгийн Улиастай суманд -0.6 хэмд хүрлээ.

**Хүснэгт 5.3. Хур тунадастай өдрийн тоо, хур тунадасны нийлбэр,  
аймгийн төв, нийслэлээр, 2012-2015**

Аймгийн төв, нийслэл	2012		2013		2014		2015	
	Өдрийн тоо	Тунадас /мм/	Өдрийн тоо	Тунадас /мм/	Өдрийн тоо	Тунадас /мм/	Өдрийн тоо	Тунадас /мм/
<b>Баруун бүс</b>								
Өлгий	104	153.0	83	115.9	79	98.8	82	102.3
Алтай	103	173.4	97	183.5	87	174.6	107	217.3
Улиастай	149	156.5	150	239.5	123	157.8	155	260.4
Улаангом	107	166.3	119	153.4	109	103.7	117	118.8
Ховд	90	159.9	61	175.1	47	140.2	66	104.1
<b>Хангайн бүс</b>								
Цэцэрлэг	189	330.7	153	263.6	138	388.4	142	402.0
Баянхонгор	80	182.3	58	158.3	77	213.0	73	198.7
Булган	154	318.7	144	423.9	112	320.1	123	302.4
Эрдэнэт	193	559.5	169	495.9	128	351.0	145	447.5
Арвайхээр	111	325.5	100	305.0	97	246.6	78	222.1
Мөрөн	137	260.4	126	308.8	119	242.4	118	252.3
<b>Төвийн бүс</b>								
Чойр	82	135.6	81	125.7	76	98.7	70	118.0
Сайншанд	77	151.2	81	160.6	63	148.0	81	79.7
Дархан	90	175.6	90	198.2	81	87.9	63	107.0
Мандалговь	109	186.6	72	124.4	86	126.6	85	167.4
Даланзадгад	157	394.1	129	420.3	109	335.0	111	329.0
Сүхбаатар	160	273.2	128	296.3	110	271.2	126	348.6
Зуунмод	184	308.4	156	239.5	123	269.0	134	269.9
<b>Зүүн бүс</b>								
Чойбалсан	149	261.0	133	431.6	112	270.2	120	186.3
Баруун-Урт	138	311.9	120	297.9	93	225.0	115	195.3
Өндөрхаан	111	319.1	115	282.0	112	248.5	106	161.0
<b>Улаанбаатар</b>								
Улаанбаатар	182	287.4	131	258.3	119	294.2	123	268.5

*Эх үүсвэр: Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны мэдээлэл*

Аймгийн төв, нийслэл хотын хур тунадасны дундаж 2012 онд 254.1 мм, 2013 онд 257.2 мм, 2014 онд 218.7 мм, 2015 онд 220.8 мм болж, 2015 онд 2012 оныхоос 33.3 мм-ээр буурсан байна. Хур тунадастай өдрийн тоо улсын хэмжээнд 2015 онд дунджаар 106 өдөр болж, 2012 оны дунджаас 24 өдрөөр бага байна.

### 5.3. АГААРЫН БОХИРДОЛ

Монгол Улсад хүн амын суурьшил, хотжилт, үйлдвэржилт нэмэгдэж, техникийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой орчны бохирдол түүний дотор агаарын бохирдол ихэсч, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлж, экологи, эрүүл ахуйн тэнцэл алдагдах явдал төдийлөн буурахгүй байна.

Хот суурингийн агаарыг бохирдуулах зарим хорт бодисын хяналт, шинжилгээг агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, жижиг ширхэглэгт тоосонцорын агууламжаар тодорхойлж байна.

## V. БАЙГАЛЬ ОРЧИН

### Хүснэгт 5.4. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын агууламж, бодисын төрлөөр, мг/м3, 2012-2015

	Хүлцэх хэм хэмжээ	2012	2013	2014	2015
Хүхэрлэг хийн агууламж	0.020	0.032	0.023	0.021	0.025
Азотын давхар ислийн агууламж	0.040	0.051	0.066	0.042	0.042
10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж	0.100	0.290	0.195	0.181	0.118
2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж	0.050	0.092	0.084	0.064	0.057

Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийг бохирдуулагч бодисын төрлөөр авч үзвэл, 2015 онд 2012 оныхоос хүхэрлэг хийн агууламж 0.007 мг/м3 -ээр, азотын давхар ислийн агууламж 0.009 мг/м3 -ээр, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 0.172 мг/м3 -ээр, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 0.035 мг/м3 –ээр буурсан боловч хүлцэх хэм хэмжээнээс өндөр түвшинд хэвээр байна.

### 5.4. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Аюулт үзэгдэл, осол 2015 онд нийт 5422 удаа гарч, объектын түймэр 4561 удаа, ой, хээрийн түймэр 354 удаа, 3.5-аас дээш магнитудын хүчтэй газар хөдлөлт 54 удаа, аадар бороо, үерийн аюул 23 удаа, хүчтэй цасан болон шороон шуурга 21 удаа бүртгэгдсэн байна.

Ой хээрийн түймэр 2015 онд 2012 оныхоос 125, 2013 оныхоос 156, 2014 оныхоос 73аар нэмэгдсэн бол объектын түймэр 2012 оныхоос 1060, 2013 оныхоос 742, 2014 оныхоос 339-өөр тус бүр нэмэгдсэн байна.

Гамшиг, аюулт үзэгдлийн улмаас 2012-2015 онд нийтдээ 811 хүн амь насаа алдсан байна.

### Хүснэгт 5.5. Тохиолдсон гамшигт үзэгдэл, учирсан хохирол

	2012	2013	2014	2015
<b>Тохиолдсон гамшигт үзэгдэл</b>				
Нийт гамшгийн тохиолдлын тоо	4 040	4 467	4 928	5 422
Ой, хээрийн түймрийн тоо	229	198	281	354
Шатсан ой, хээр, сая га	5.0	5.6	2.9	6.5
Объектын түймэр	3 501	3 819	4 222	4 561
Хүчтэй цасан болон шороон шуурга	26	37	25	21
Аадар бороо, үерийн аюул	34	52	32	23
Газар хөдлөлт (3.5-аас дээш магнитудын хүчтэй)	15	49	63	54
Хорогдсон, устгасан мал, амьтан, мян.толгой	13.0	235.6	15.1	175.3
Гамшгийн улмаас нас барсан хүн	237	201	175	198
Гамшгийн улмаас учирсан хохирлын хэмжээ, тэрбум төг	94.5	22.0	25.2	79.9

Эх үүсвэр: Онцгой байдлын ерөнхий газрын мэдээлэл




## VI. ГЭМТ ХЭРЭГ

Улсын хэмжээнд 2015 онд 27.8 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2012 оныхоос 5.7 мянга буюу 25.7 хувиар нэмэгдсэн байна (Зураг 6.1).


Бүртгэгдсэн гэмт хэрэг 2012-2015 онд жилд дунджаар 25.6 мянга болж, 2008-2011 оны дунджаас 5.6 мянга буюу 28.0 хувиар өссөн байна. Сүүлийн 4 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг өсөхөд 2014-2015 онд гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 6.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг, 2012-2015



Гэмт хэргийн илрүүлэлт 2015 онд улсын хэмжээнд 62.1 болж, 2012 оныхоос 5.8 пунктээр, нийслэлийн хэмжээнд 58.9 болж, 2012 оныхоос 7.2 пунктээр өссөн байна.

Зураг 6.2. Гэмт хэргийн илрүүлэлт, хувиар, 2012-2015



Улсын дунджаар 18, түүнээс дээш насны 10 000 хүн тутамд 2015 онд 141 гэмт хэрэг ногдож, 2012 оныхоос 24 хэрэг буюу 20.5 хувь, 2014 оныхоос 1 хэрэг буюу 0.7 хувиар өссөн байна.

Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, яллагдагчид 2015 онд 24.9 мянга болж, 2012 оныхоос 5.1 мянга буюу 26.0 хувиар өссөн байна.

**Хүснэгт 6.1. Сэжигтэн холбогдогч ба шүүхээр ял шийтгүүлэгчид, 2012-2015**

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогч	18904	19734	22286	23737	24857	22654
Шүүхээр ял шийтгүүлсэн хүн	7878	8324	8065	8178	7696	8066

Гэмт хэрэгт 2008-2011 онд дунджаар 18.9 мян.хүн холбогдож, 7.9 мян.хүн ял шийтгүүлж байсан бол 2012-2015 онд 22.7 мян.хүн гэмт хэрэгт холбогдож, 8.1 мян.хүн ял шийтгүүлсэн байна.

**Хүснэгт 6.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хохирогч иргэн, мян.хүн, 2012-2015**

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Бүртгэгдсэн гэмт хэрэг	20.0	22.1	25.4	27.3	27.8	25.7
Хохирсон иргэн	19.4	21.3	25.0	27.5	27.9	25.4

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2008-2011 онд жилд дунджаар 20.0 мянга, хохирсон иргэн 19.4 мянга байсан бол 2012-2015 онд дунджаар 25.7 мянган хэрэг бүртгэгдэж, 25.4 мян.хүн гэмт хэргийн улмаас хохирчээ.

Гэмт хэргийн улмаас 2015 онд 27.9 мянган иргэн хохирсон нь 2012 оныхоос 31.0 хувь, 2013 оныхоос 11.6 хувь, 2014 оныхоос 1.5 хувиар нэмэгдсэн байна.

**Хүснэгт 6.3. Гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн хүн, 2012-2015**

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	1424	901	949	1078	847	944
Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн	325	369	424	503	429	431
Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн	8234	8436	9797	11281	11287	10200
Зам тээврийн улмаас гэмтсэн хүн	923	1078	1282	1460	1382	1301

Зам тээврийн ослоор 2008-2011 онд дунджаар 325 хүн нас барсан бол 2012-2015 онд дунджаар 431 хүн нас барж, 106 буюу 32.6 хувиар өссөн байна.

Зам тээврийн ослоос гэмтсэн хүн 2008-2011 онд дунджаар 923 байсан бол 2012-2015 онд дунджаар 1301 болж, 378 буюу 41.0 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирол 2015 онд 144.3 тэрбум төг болж, 2012 оныхоос 91.0 тэрбум төг буюу 2.7 дахин, нөхөн төлүүлэлт 49.0 тэрбум төг болж, 23.9 тэрбум төг буюу 2.0 дахин өссөн байна.


Учирсан хохирлын 2008-2011 онд дунджаар 33.5 хувийг нөхөн төлүүлж байсан бол 2012-2015 онд 45.4 хувийг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэлт өмнөх 4 жилийнхээс 11.9 пунктээр өссөн байна. Харин 2012 онд 47.1 хувийг нөхөн төлүүлж байсан бол 2015 онд учирсан хохирлын 34.0 хувийг төлж, нөхөн төлүүлэлт 13.1 пунктээр буурчээ.

Зураг 6.3. Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, тэрбум төг, 2012-2015




Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2015 онд 1307 хүн хохирсон нь 2014 оныхоос 201 буюу 18.2 хувиар нэмэгдэв. Эдгээр хүмүүсийн 1151 буюу 88.1 хувь нь эмэгтэйчүүд, 126 буюу 9.6 хувь нь хүүхдүүд байна. Хүчирхийлэлд өртсөн иргэдийн 565 буюу 43.2 хувь нь ажилгүй иргэд байна.

Зураг 6.4. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, 2012-2015



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 2012-2015 онд дунджаар 796 болж, 2008-2011 оны дунджаас 497 буюу 2.7 дахин өссөн байна. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2015 онд 1356 болж, 2012 оныхоос 923 буюу 3.1 дахин өссөн байна.

Зураг 6.5. Эрүүлжүүлэгдсэн хүн, мян.хүн, 2012-2015



## VI. ГЭМТ ХЭРЭГ

Эрүүлжүүлэгдсэн хүн 2012-2015 онд дунджаар 114.5 мянга болж, 2008-2011 оныхоос 8.9 мянга буюу 7.2 хувиар буурчээ. Харин 2015 онд 97.6 мян.хүн эрүүлжүүлэгдсэн нь 2012 оныхоос 20.4 мянга буюу 17.3 хувиар буурсан байна.

### Хүснэгт 6.4. Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, 2012-2015

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Эрүүгийн хэрэг	5639	6161	6169	6375	6756	6365
Иргэний хэрэг	35710	27792	35314	33996	40674	34444
Захиргааны хэрэг	1140	961	1106	1187	1439	1173

Анхан шатны шүүхээр 2012-2015 онд дунджаар 6365 эрүүгийн хэрэг, 34444 иргэний хэрэг, 1173 захиргааны хэрэг шийдвэрлэгдсэн нь 2008-2011 оныхоос эрүүгийн хэрэг 12.9 хувь, захиргааны хэрэг 2.9 хувиар өсч, харин иргэний хэрэг 3.5 хувиар буурсан байна. Эрүүгийн хэрэг 2015 онд 2012 оныхоос 595 буюу 9.7 хувь, иргэний хэрэг 12882 буюу 46.4 хувь, захиргааны хэрэг 478 буюу 49.7 хувиар өссөн байна.

### Зураг 6.6. Шүүхээр ял шийтгүүлсэн эмэгтэйчүүд, хүүхэд, 2012-2015



Шүүхээр ял шийтгүүлсэн хүүхэд 2012-2015 онд дунджаар 520 болж, 2008-2011 оныхоос 38 буюу 7.9 хувь, эмэгтэйчүүд 700 болж, 2008-2011 оныхоос 2 буюу 0.3 хувиар өссөн байна.

## VII. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО

## 7.1 ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ ӨСӨЛТ

Эдийн засгийн бодит өсөлт 2008-2011 онд жилд дунджаар 7.7 хувь байсан бол 2012-2015 онд жилд дунджаар 8.5 хувь болж 0.8 пунктээр өслөө. ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр, 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15837.7 тэрбум төгрөгт хүрч, 2014 оныхоос 355.4 тэрбум төг буюу 2.3 хувиар өслөө.

## Хүснэгт 7.1.1 ДНБ-ий жилийн бодит өсөлт, бууралт, хувиар, 2012-2015

Салбар	2008-2011 оны жилийн дундаж өсөлт, бууралт (%)	2012	2013	2014	2015*	2012-2015 оны жилийн дундаж өсөлт (%)
ДНБ	7.7	12.3	11.6	7.9	2.3	8.5
Хөдөө аж ахуй	-2.6	21.1	19.2	13.7	10.7	16.1
Уул уурхай, олборлох	3.7	8.3	18.5	19.4	13.0	14.7
Уул уурхайн бус үйлдвэрлэл	2.9	7.6	9.1	4.4	1.7	5.7
Барилга	-2.6	85.3	8.0	-4.3	-1.4	17.2
Худалдаа	18.2	12.0	8.9	2.4	-3.6	4.7
Тээвэр	10.7	8.1	-1.4	14.8	5.7	6.6
Бусад үйлчилгээ	7.6	9.8	9.9	9.6	2.8	8.0

\* Урьдчилсан гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлтийн хувь 2012 оноос хойш жил бүр буурч байгаа ч ДНБ-ий 2012-2015 оны жилийн дундаж өсөлт өмнөх 4 жилийнхээс 0.8 пунктээр нэмэгдсэн. Энэхүү өсөлтөд ДНБ-ий 2012 оны бодит өсөлт 12.3 хувь болж, малын тоо 2011 оныхоос 19.3 саяар өссөн, мөн уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж хэмжээ 2012-2015 онд 2008-2011 оныхоос 14.7 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн. Тухайлбал, олборлосон алтны хэмжээ 2008-2011 онд 2004-2007 оныхоос жилд дунджаар 11.7 тонноор бага байсан бол 2012-2015 онд 2008-2011 оныхоос жилд дунджаар 1.1 тонноор нэмэгдсэн. Мөн олборлосон зэсийн баяжмалын хэмжээ 2008-2011 онд 2004-2007 оныхоос жилд дунджаар 9.0 мянган тонноор бага байсан бол 2012-2015 онд 2008-2011 оныхоос жилд дунджаар 261.5 мянган тонноор нэмэгдсэн байна.

## 7.2 ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ

ДНБ 2015 онд урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 23166.8 тэрбум төгрөгт хүрч, 2014 оныхоос 939.7 тэрбум төг буюу 4.2 хувиар өслөө (Хүснэгт 7.2.1). ДНБ-ий 2015 онд 13.6 хувь нь хөдөө аж ахуйд, 33.7 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 52.7 хувь нь үйлчилгээний салбарт ногдож байна.

ДНБ-ий бүтцийг салбараар хүснэгт 7.2.2-д үзүүлэв. ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь 2012 онд 11.2, 2013 онд 13.4, харин 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр 13.6 хувь болж өссөн байна. Үйлдвэрлэлийн салбар 2012 онд ДНБ-ий 34.5 хувь, 2013 онд 34.4 хувь, 2014 онд 34.7 хувийг эзэлж байсан бол 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр 33.7 хувь болж буурсан байна.

## VII. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО


### Хүснэгт 7.2.1 ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, тэрбум төг, 2012-2015

Салбар	2012	2013	2014	2015*
<b>ДНБ</b>	<b>16 688.4</b>	<b>19 174.2</b>	<b>22 227.1</b>	<b>23 166.8</b>
Хөдөө аж ахуй	1 878.8	2 572.0	2 965.4	3 167.6
Уул уурхай, олборлолт	2 742.8	2 849.4	3 661.0	3 867.7
Боловсруулах үйлдвэрлэл	1 248.7	1 672.3	1 950.9	1 939.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	233.9	270.5	313.6	380.4
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	72.5	77.5	86.5	106.5
Барилга	837.5	979.7	989.0	973.1
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	2 231.1	2 267.2	2 544.8	2 751.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	894.4	843.6	1 109.2	1 144.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	186.2	205.5	196.6	206.3
Мэдээлэл, холбоо	379.6	413.9	492.1	519.6
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	583.5	782.3	1 041.8	1 150.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	957.3	1 162.3	1 495.1	1 557.5
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	424.2	446.8	504.4	536.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	177.6	213.4	210.6	229.5
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал	699.1	788.8	907.2	989.1
Боловсрол	745.0	854.6	996.0	1 087.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	317.0	359.1	412.3	439.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	87.0	87.2	98.1	98.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	137.8	149.3	177.3	186.9
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1 854.4	2 178.6	2 075.3	1 836.0

\* Урьдчилсан гүйцэтгэл

Нэг хүнд ногдох ДНБ (Дэлхийн банкны атласын аргаар) 2008-2011 оны жилийн дундаж хэмжээ 2301 ам.долл байсан бол 2012-2015 оных 4308 ам долларт хүрч, 1.9 дахин нэмэгдлээ.

### Зураг 7.1.1 Нэг хүнд ногдох ДНБ (Дэлхийн банкны атласын аргаар), 2003-2015



\* Урьдчилсан гүйцэтгэл

## VII. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО

### Хүснэгт 7.2.2 ДНБ-ий бүтэц, хувиар, 2012-2015

Салбар	2012	2013	2014	2015*
<b>ДНБ</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Хөдөө аж ахуй</b>	<b>11.2</b>	<b>13.4</b>	<b>13.3</b>	<b>13.6</b>
<b>Үйлдвэрлэлийн салбар</b>	<b>34.5</b>	<b>34.4</b>	<b>34.7</b>	<b>33.7</b>
Уул уурхай, олборлолт	17.8	15.9	17.0	17.0
Боловсруулах үйлдвэрлэл	9.0	10.7	10.6	9.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.3	1.5	1.6	1.8
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.5	0.4	0.4	0.5
Барилга	5.9	5.8	5.1	4.7
<b>Үйлчилгээний салбар</b>	<b>54.1</b>	<b>52.3</b>	<b>52.0</b>	<b>52.7</b>
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	19.9	18.4	16.9	17.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.2	4.3	4.8	4.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1.2	1.2	1.0	1.0
Мэдээлэл, холбоо	2.6	2.5	2.5	2.5
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	3.5	4.1	4.7	5.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	5.8	6.2	6.8	6.8
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.8	2.8	2.5	2.5
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.2	1.2	1.1	1.1
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал	4.2	4.1	4.1	4.3
Боловсрол	4.5	4.5	4.5	4.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.9	1.9	1.9	1.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.5	0.5	0.4	0.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.8	0.8	0.8	0.8

\*Урьдчилсан гүйцэтгэл

Монгол Улсын эдийн засагт хувийн хэвшлийн эзлэх хувь харьцангуй өндөр байна. Хувийн хэвшлийн ДНБ-д эзлэх хувийг хүснэгт 7.2.3-т харуулав.

Хувийн хэвшлийн ДНБ-д эзлэх хувь хөдөө аж ахуй, барилга, боловсруулах аж үйлдвэр, бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, зоогийн газрын салбар, мэдээлэл холбоо, үл хөдлөх хөрөнгө, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 90.0-100.0 хувийг эзэлж байгаа нь бусад салбарынхаас өндөр байна.



## VII. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО

### Хүснэгт 7.2.3 Хувийн хэвшлийн ДНБ-д эзлэх хувь, 2012-2015

Салбар	2012	2013	2014	2015*
ДНБ-д хувийн хэвшлийн эзлэх хувь	78.7	80.1	79.9	80.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	100.0	100.0	100.0	100.0
Уул уурхай, олборлолт	62.6	63.6	69.1	76.5
Боловсруулах үйлдвэрлэл	95.8	97.0	97.1	97.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	12.8	13.3	12.9	13.9
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	38.5	40.9	42.1	41.4
Барилга	97.8	98.7	98.2	98.9
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	99.7	99.7	99.8	99.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	64.3	66.6	64.6	62.6
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	97.9	98.5	97.3	98.0
Мэдээлэл, холбоо	87.4	92.2	92.5	91.2
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	96.7	93.5	82.6	83.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	99.8	99.9	99.9	100.0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	82.1	81.4	81.2	80.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	91.4	99.3	94.0	95.8
Боловсрол	19.9	18.0	19.8	23.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	20.5	18.3	18.8	22.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	24.3	25.7	25.7	26.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	99.0	99.0	99.1	99.3

\* Урьдчилсан гүйцэтгэл

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 23106.9 тэрбум төг болж, 2014 оныхоос 879.9 тэрбум төг буюу 4.0 хувиар өслөө. Уг өсөлтөд эцсийн хэрэглээ 883.4 тэрбум төг буюу 5.7 хувиар өссөн нь нөлөөллөө. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-д 2012 онд эцсийн хэрэглээ 66.5 хувийг эзэлж байсан бол 2015 онд 70.8 хувь болж 4.3 пунктээр нэмэгджээ. Харин хөрөнгийн нийт хуримтлалын эзлэх хувь 2012 онд 55.9 хувь байсан бол 2015 онд 26.3 хувь болж, 29.6 пунктээр буурсан байна. ДНБ-ий эцсийн ашиглалтын бүтцийг хүснэгт 7.2.5-д харуулав.

## VII. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО

### Хүснэгт 7.2.4 ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр, 2012-2015

Бүрэлдэхүүн	ДНБ, тэрбум төг			
	2012	2013	2014	2015*
<b>ДНБ</b>	<b>16 688.4</b>	<b>19 174.2</b>	<b>22 227.1</b>	<b>23 106.9</b>
Эцсийн хэрэглээ	11 105.4	13 279.3	15 480.9	16 364.3
Өрхийн хэрэглээ, ӨҮАББ-ын хэрэглээ	8 848.0	10 699.0	12 587.6	13 617.7
Төрийн байгууллагын хэрэглээ	2 257.4	2 580.3	2 893.3	2 746.6
Хөрөнгийн нийт хуримтлал	9 328.6	10 215.2	7 818.4	6 072.1
Үндсэн хөрөнгийн хуримтлал	7 529.2	7 528.5	6 351.1	4 213.6
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	1 799.4	2 686.7	1 467.3	1 858.6
Цэвэр экспорт	-3 745.6	-4 320.2	-1 072.3	670.5
Экспорт	7 271.5	7 456.9	11 613.4	10 410.5
Импорт (-)	11 017.1	11 777.2	12 685.7	9 740.0

\* Урьдчилсан гүйцэтгэл

### Хүснэгт 7.2.5 ДНБ, эцсийн ашиглалтын бүтэц, 2012-2015

Бүрэлдэхүүн	Бүтэц, хувиар			
	2012	2013	2014	2015*
<b>ДНБ</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Эцсийн хэрэглээ	66.5	69.3	69.6	70.8
Өрхийн хэрэглээ, ӨҮАББ-ын хэрэглээ	53.0	55.8	56.6	58.9
Төрийн байгууллагын хэрэглээ	13.5	13.5	13.0	11.9
Хөрөнгийн нийт хуримтлал	55.9	53.3	35.2	26.3
Үндсэн хөрөнгийн хуримтлал	45.1	39.3	28.6	18.2
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	10.8	14.0	6.6	8.0
Цэвэр экспорт	- 22.4	- 22.5	- 4.8	2.9
Экспорт	43.6	38.9	52.2	45.1
Импорт (-)	66.0	61.4	57.1	42.2

\* Урьдчилсан гүйцэтгэл

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 15928.8 тэрбум төг болж, 2014 оныхоос 374.5 тэрбум төг буюу 2.4 хувиар өслөө.

### Хүснэгт 7.2.6 ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг, 2012-2015


Бүрэлдэхүүн	2012	2013	2014	2015*	$\frac{2015^*}{2012}$ %
<b>ДНБ</b>	<b>12 898.9</b>	<b>14 391.4</b>	<b>15 554.3</b>	<b>15 928.8</b>	<b>102.4</b>
Эцсийн хэрэглээ	8 762.7	10 121.6	10 876.0	11 376.9	104.6
Хөрөнгийн нийт хуримтлал	7 847.8	7 953.8	5 562.6	4 020.5	72.3
Цэвэр экспорт	-3 711.6	-3 684.1	- 884.3	531.4	-

\* Урьдчилсан гүйцэтгэл

Эцсийн ашиглалтын аргаар, зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ 2015 онд 2.4 хувиар өсөхөд эцсийн хэрэглээ 500.9 тэрбум төг буюу 4.6 хувиар өссөн нь нөлөөлөв.

## VII. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО

Зураг 7.2.1 ДНБ-ий бодит өсөлтөд бүрэлдэхүүн хэсгийн оролцоо, хувиар, 2012-2015



\* Урьдчилсан гүйцэтгэл

Эцсийн ашиглалтын аргаар, зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий 2015 оны 2.4 хувийн өсөлтийн 3.2 нэгжийг эцсийн хэрэглээ, (9.9) нэгжийг хөрөнгийн нийт хуримтлал, 9.1 нэгжийг цэвэр экспорт бүрдүүлж байна. ДНБ-ий 2015 оны бодит өсөлт өмнөх оныхоос 5.7 пунктээр буурахад цэвэр экспорт 2014 оныхоос 10.4 пунктээр буурсан нь нөлөөлсөн.

### 7.3 ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО

ҮНО урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 2015 онд 21048.5 тэрбум төгрөгт хүрч, 2014 оныхоос 628.4 тэрбум төг буюу 3.1 хувиар өслөө (Хүснэгт 7.3.1). 1 хүнд ногдох ҮНО, оны үнээр 2015 онд 6953.9 мянган төгрөгт хүрч, 2014 оныхоос 0.9 хувиар өслөө.

Хүснэгт 7.3.1 Үндэсний нийт орлого, оны болон зэрэгцүүлэх үнээр, 2012-2015

Бүрэлдэхүүн	2012	2013	2014	2015*
<b>Оны үнээр</b>				
ҮНО, тэрбум төг	15 399.6	18 091.3	20 420.1	21 048.5
1 хүнд ногдох ҮНО, мян.төг	5 422.9	6 240.5	6 891.4	6 953.9
<b>2010 оны зэрэгцүүлэх үнээр</b>				
ҮНО, тэрбум төг	11 860.7	13 540.2	14 223.6	14 389.5
1 хүнд ногдох ҮНО, мян төг	4 176.8	4 670.6	4 800.2	4 753.9

\* Урьдчилсан гүйцэтгэл

### 7.4 БҮТЭЭМЖ

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд нэгж зардалд ногдох бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлох хэмжигдэхүүн юм.

Улсын түвшинд бүтээмжийг ДНБ-ээр, салбарын түвшинд нэмэгдэл өртгөөр тооцох бөгөөд 2015 онд улсын дүнгээр хөдөлмөрийн бүтээмжийн хэмжээ 13416.9 мян.төг болж, 2012 оныхоос 1741.7 мянган төгрөгөөр нэмэгджээ.

## VII. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО

### Хүснэгт 7.4.1 Хөдөлмөрийн бүтээмж, салбараар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг, 2012-2015

Салбар	2012	2013	2014	2015*
<b>Улсын түвшинд</b>	<b>11 675.2</b>	<b>12 731.4</b>	<b>13 404.0</b>	<b>13 416.9</b>
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан	3 875.7	4 709.4	5 850.1	6 488.9
Уул уурхай, олборлолт	53 424.2	59 913.9	76 083.5	93 792.9
Боловсруулах үйлдвэрлэл	11 931.5	11 784.5	10 759.3	10 883.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	16 153.5	15 884.3	16 297.1	15 982.7
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	5 346.8	4 563.9	4 397.7	4 731.7
Барилга	10 230.9	9 335.0	7 662.6	6 854.1
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	13 851.7	14 894.5	13 434.8	12 122.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	12 785.0	13 622.7	14 058.5	14 149.7
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2 678.4	2 570.7	2 078.0	1 953.0
Мэдээлэл, холбоо	23 993.2	22 999.8	21 897.9	22 853.8
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	29 942.4	34 779.7	40 309.6	40 341.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5 564.6	5 687.0	5 760.4	5 751.6

\*Урьдчилсан гүйцэтгэл

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл, 2015 онд санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар, уул уурхай, олборлолтын салбарт хөдөлмөрийн бүтээмж 40.3-93.8 сая төг болж, бусад салбарын дунджаас өндөр байна.



## VIII. ҮНЭ, ХАНШНЫ БАЙДАЛ

## 8.1 ИНФЛЯЦИ

Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар нь өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний зардлын жинг шинэчлэн 2010 оны 12 дугаар сарын суурь үетэй харьцуулснаар 2012 оны 1 дүгээр сараас хэрэглээний үнийн индексийг тооцон нийтэд мэдээлж байна.

Махны дундаж үнийг илүү бодитой болгох үүднээс худалдааны зах, цэгүүдийн борлуулалтын хэмжээг тодорхойлох тусгайлсан судалгаа явуулж, үр дүнд нь махны дундаж үнийг жигнэж тооцдог болсон. Энэхүү арга зүйн өөрчлөлтийг ХҮИ тооцох аргачлалд тусган, 2014 оны 1 дүгээр сараас эхлэн шинэчилсэн аргачлалын дагуу тооцсон ХҮИ-ийг тархааж байна.

Хэрэглээний үнийн улсын индекс өмнөх оныхоос 2012 оны эцэст 14.0 хувь, 2013 онд 12.5 хувь, 2014 онд 11.0 хувиар өссөн бол 2015 онд 1.9 хувиар өсч, өсөлтийн хурдац 2014 оныхоос 9.1 пунктээр саарлаа.

**Хүснэгт 8.1.1. ИНФЛЯЦИЙН ТҮВШИН, 2012-2015 оноор, хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгээр, хувиар, 2012-2015**

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2012	2013	2014	2015	2012-2015 оны инфляци
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	17.5	13.3	8.4	-6.1	35.5
Согтууруулах ундаа, тамхи	3.2	54.4	13.4	10.3	1.4	95.7
Хувцас, бөс бараа, гутал	16.1	16.1	17.6	14.3	5.5	64.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	11.0	7.8	16.3	3.2	43.8
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	10.2	18.2	11.5	5.1	52.6
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	9.0	13.2	9.1	4.1	40.1
Тээвэр	12.2	6.5	3.0	8.6	1.4	20.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	-1.5	-0.3	0.0	-0.8	-2.6
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	3.5	0.3	8.1	2.4	14.9
Боловсролын үйлчилгээ	4.7	15.2	27.2	16.8	23.1	110.6
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	23.0	17.8	8.6	4.4	64.3
Бусад бараа, үйлчилгээ	4.1	7.4	17.2	11.8	5.1	47.9
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>14.0</b>	<b>12.5</b>	<b>11.0</b>	<b>1.9</b>	<b>45.0</b>


Инфляци 2015 оны эцэст 2011 оныхоос 45.0 хувиар өссөн байна. Үүний 10.7 нэгж (23.8 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс, 10.4 нэгж (23.0 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс, 5.6 нэгж (12.3 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс, 5.3 нэгж (11.7 хувь) нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2015 онд 1.9 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 23.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний үнийн улсын индексийн 2015 оны 1.9 хувийн өсөлтийн 1.3 нэгж нь боловсролын бүлгийн; 1.0 нэгж хувцас, гутал, бөс барааны бүлгийн; 0.4 нэгж нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс голлон шалтгаалсан байна.

## VIII. ҮНЭ, ХАНШНЫ БАЙДАЛ

Зураг 8.1.1. Инфляцийн түвшин, оны эхнээс, хувиар, 2012-2015



Хүснэгт 8.1.2. ИНФЛЯЦИЙН ЖИЛИЙН ДУНДАЖ ТҮВШИН, хувь, 2012-2015

Он	2012	2013	2014	2015
Инфляцийн жилийн дундаж түвшин	14.3	10.5	12.8	6.6


Инфляцийн жилийн дундаж түвшин 2015 онд 6.6 хувь болж, 2014 оныхоос 1.9 дахин буурлаа.

Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2012 онд 17.5 хувь, 2013 онд 13.3 хувь, 2014 онд 8.4 хувиар өсч байсан бол 2015 онд 6.1 хувиар буурсан байна.

Монгол өрхийн хэрэглээнд хүнсний бараа, үүн дотроо гурил, мах, махан бүтээгдэхүүн өндөр жин эзэлдэг. Үнийн өсөлтөд голлон нөлөөлдөг хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн болон бензин, шатахууны үнийн өөрчлөлтийг авч үзье.

**Гурил:** 1-р зэргийн гурилын 1 кг-ын үнэ 2012 оны 1 сард 700 төг байсан бол, 2015 оны 12 дугаар сард 1132 төг болж, 432 төг буюу 61.7 хувиар өсчээ. Энэ хугацаанд 2012 оны 6 дугаар сард 680 төг байсан нь хамгийн хямд үнэ байна.

Зураг 8.1.2. Гурилын үнэ, 1-р зэрэг, задгай, кг, сараар, төг, 2012-2015




**Махны үнэ:** Улаанбаатар хотын өрхийн хэрэглээний нийт мөнгөн зардлын 10.1 хувийг мах махан бүтээгдэхүүн эзэлдэг. Иймд инфляцийн түвшин махны үнээс ихээхэн хамаардаг. Махны үнэ нийлүүлэлттэйгээ холбоотойгоор байнга хэлбэлздэг бөгөөд хавар, зуны улиралд өсч, намар, өвлийн улиралд буурдаг хандлага 2012-2015 онд мөн хэвээр хадгалагдав.

Өнгөрсөн дөрвөн жилд хонины махны 1 кг-ын үнэ хамгийн хямд буюу 2014 оны 5 дугаар сард хамгийн үнэтэй буюу 7800 төгрөгт хүрч байв.




Зураг 8.1.3. Хонины махны үнэ, ястай, кг, сараар, төг, 2012-2015



**Шатахуун:** Инфляцийн өөрчлөлтөд бодитойгоор нөлөө үзүүлэгч нэг хүчин зүйл нь шатахууны үнийн өөрчлөлт юм. Бензин, шатахууны үнийн төлөөлөл болгож (АИ-92)-ын үнийн мэдээллийг авч үзье. 1 литр тутмын үнэ 2012 оны 1 дүгээр сард хамгийн өндөр буюу 1780 төг болж, үүнээс хойш буурч, тухайн оны 11 дүгээр сард 1570 төгрөгт хүрсэн нь энэ дөрвөн жилийн хамгийн хямд үнэ байлаа.

Зураг 8.1.4. Бензин, АИ-92, 1 литр, сараар, төг, 2012-2015



**Бүсийн инфляци.** Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар бүсийн инфляцийг 2012 оноос эхлэн 2010 оны 12 дугаар сарын суурьтайгаар 4 бүсээр тооцон, нийтэд тархааж байна.

Хүснэгт 8.1.3. БҮСИЙН ИНФЛЯЦИЙН ЖИЛИЙН ТҮВШИН, хувь, 2012-2015

Бүс	2012	2013	2014	2015
Баруун бүс	15.7	11.3	12.6	1.2
Хангайн бүс	15.1	14.1	12.7	4.3
Төвийн бүс	12.5	13.1	9.7	2.0
Зүүн бүс	12.5	10.7	11.2	3.4

Баруун, хангайн болон зүүн бүсийн инфляцийн түвшин 2012 онд хамгийн өндөр байсан бол төвийн бүсийнх 2013 онд өндөр байна. 2015 онд инфляцийн түвшин хамгийн бага байв.

Бүсийн инфляцийн түвшинг улсын түвшинтэй харьцуулахад, 2012 онд баруун болон хангайн бүсэд инфляцийн түвшин 15.1-15.7 хувь байсан нь улсын инфляцийн түвшнээс 1.1-1.7 пунктээр өндөр, төвийн болон зүүн бүсэд 12.5 байсан нь улсын инфляцийн түвшнээс 1.5 пунктээр доогуур байлаа. Харин 2013 онд улсын инфляциас хангайн болон төвийн бүсийн инфляци 0.6-1.6 пунктээр өндөр, баруун болон зүүн бүсийн инфляци 1.2-1.8 пунктээр доогуур байна. Төвийн бүсээс бусад бүсийн инфляци 2014 онд улсын инфляциас 0.2-1.7 пунктээр өндөр, төвийн бүсийн инфляци 1.3 пунктээр доогуур байна. Баруун бүсийн инфляцийн түвшин 2015 онд улсын инфляциас 0.7 пунктээр доогуур, бусад бүсийнх 0.1-2.4 пунктээр өндөр байв.


## VIII. ҮНЭ, ХАНШНЫ БАЙДАЛ

### 8.2 МӨНГӨ, ЗЭЭЛ, ВАЛЮТЫН ХАНШ

#### Мөнгөний агрегатууд

2015 оны эцэст мөнгөний нийлүүлэлтийн 54.1 хувийг төгрөгийн хадгаламж, 19.4 хувийг гадаад валютын хадгаламж, 9.8 хувийг гадаад валютын харилцах, 12.2 хувийг төгрөгийн харилцах, 4.6 хувийг банкнаас гадуурх мөнгө эзэлж байна (Зураг 8.2.1).

Зураг 8.2.1 Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, хувиар, 2012-2015



Эх үүсвэр: Монголбанкны мэдээлэл

Нийт мөнгө /M2/ 2015 онд 2012 оныхоос 32.0 хувиар өсөж, 10.1 их наяд төгрөгт хүрчээ. Энэхүү өсөлтийн 80.0 хувийг төгрөгийн хадгаламж, 21.1 хувийг гадаад валютын хадгаламж, 5.0 хувийг гадаад валютын харилцах бүрдүүлжээ.

Санхүүгийн зуучлалын гол үзүүлэлтүүдийг хүснэгт 8.2.1-д харуулав.

Хүснэгт 8.2.1 Санхүүгийн зуучлалын гол үзүүлэлтүүд, хувиар, 2012-2015

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
M2/ДНБ	43.6	45.6	49.3	47.9	43.4	46.6
Нийт зээл/ДНБ	39.1	41.9	56.1	56.2	50.5	51.1
Хадгаламж/ДНБ	20.7	29.5	33.3	33.2	31.9	32.0
Банкнаас гадуурхи мөнгө/M2	10.2	7.9	6.2	4.7	4.6	5.8
Банкны салбарын нийт актив/ДНБ	59.7	64.3	92.8	86.3	79.3	80.4
Чанаргүй зээл/Нийт зээл	10.4	4.2	5.3	5.0	7.4	5.5

Эх үүсвэр: Монголбанкны мэдээлэл


Банкны салбарын үзүүлэлтүүд сайжирч, нийт актив 2015 онд 2012 оныхоос 71.3 хувиар өссөн байна. Эдийн засагт мөнгөжих процесс эрчимтэй үргэлжилсний дүнд санхүүгийн зуучлалын гүнзгийрэлт үргэлжилж, санхүүгийн зуучлалын гол үзүүлэлтүүдийн нэг болох нийт мөнгө (M2) болон ДНБ-ий харьцаа 2012 онд 45.6 хувь байсан бол 2015 онд 43.4 хувь болж буурч, зээл болон ДНБ-ий харьцаа 8.7 пункт, хадгаламж болон ДНБ-ий харьцаа 2.5 пункт, нийт актив болон ДНБ-ий харьцаа 15.2 пунктээр нэмэгдсэн байна.

## Хүснэгт 8.2.2 Зээл, мөнгөний агрегатууд, тэрбум төг, 2012-2015

Үзүүлэлт	2008-2011 оны жилийн дундаж өсөлт(%)	2012	2013	2014	2015	2012-2015 оны жилийн дундаж өсөлт(%)
Нийт зээл	28.8	6 988.4	10 764.2	12 502.5	11 695.8	20.0
Нийт мөнгө (M2)	27.8	7 613.7	9 454.9	10 635.8	10 050.2	11.9
Бараг мөнгө	26.7	5 778.8	7 361.7	8 819.1	8 364.8	15.7
Хадгаламж	27.1	4 919.7	6 387.5	7 380.1	7 383.0	17.4
Төгрөгийн	27.1	3 485.0	4 911.3	5 410.3	5 434.0	16.9
Валютын	27.0	1 434.7	1 476.2	1 969.8	1 949.0	18.8
Бага мөнгө (M1)	31.0	1 834.9	2 093.2	1 816.7	1 685.4	-0.8

Эх үүсвэр: Монголбанкны мэдээлэл

## Зураг 8.2.2 Зээлийн өрийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн эзлэх хувь, 2012-2015



Эх үүсвэр: Монголбанкны статистикийн сарын мэдээлэл

Хадгаламжийн байгууллагуудын гол бүтээгдэхүүн болох нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 онд 2012 оныхоос 67.4 хувиар нэмэгдэж, харин чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2012 онд 4.2 байсан бол 2015 оны эцэст 7.4 болж, 3.2 пунктээр өсчээ. Арилжааны банкуудын зээлийн өрийн үлдэгдлийг хүснэгт 8.2.3-т харуулав.

## Хүснэгт 8.2.3 Арилжааны банкуудын зээлийн өрийн үлдэгдэл, салбараар, тэрбум төгрөг, 2012-2015

	2012	2013	2014	2015	Салбарын бүтэц, хувиар	
					2012	2015
ХАА	186.3	227	316.8	241.3	2.7	2.1
Аж үйлдвэр	1 624.5	2 516.1	2 524.4	2 510.2	23.4	21.6
Барилга	899.9	1 457.2	1 647.4	1 526.8	13.0	13.1
Худалдаа	1 141.8	1 746.3	1 803.4	1 678.5	16.4	14.4
Тээвэр	215.1	196.2	174.8	133.7	3.1	1.1
Холбоо	38.2	46.3	118.1	90.2	0.6	0.8
Бусад	2 835.3	4 526.5	5 856.0	5 452.9	40.8	46.9
<b>Нийт</b>	<b>6 941.1</b>	<b>10 715.6</b>	<b>12 440.9</b>	<b>11 633.6</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Эх үүсвэр: Монголбанкны мэдээлэл

## VIII. ҮНЭ, ХАНШНЫ БАЙДАЛ

Арилжааны банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдэл хэмжээ 2015 оны байдлаар 21.6 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 14.4 хувь нь худалдааны салбарт, 13.1 хувь барилгын салбарт ногдож байна. ХАА, аж үйлдвэр, худалдаа, тээврийн салбарт олгосон зээлийн хэмжээ 2012 оныхтой харьцуулахад 0.6-2.0 пунктээр буурч, барилга, холбооны салбарынх 0.2 пункт, үйлчилгээний бусад салбар 6.1 пунктээр нэмэгджээ.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2012 онд 18.2 хувь байснаа 2013 онд 17.4 хувь болж 0.8 пунктээр буурч, 2014 онд 19.5 хувь, 2015 оны эцэст 19.1 хувьд хүрсэн бол валютынх 2012 оны эцэст 13.5 хувь байснаа 2015 оны эцэст 12.0 хувь болж, 1.5 пунктээр буурчээ. Зээлийн хүүг хүснэгт 8.2.4-д үзүүлэв.

**Хүснэгт 8.2.4 Зээлийн хүү, хувиар, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Төгрөгийн зээлийн хүү	18.7	18.2	17.4	19.5	19.1	18.6
өөрчлөлт /пункт/		2.7	-0.8	2.1	-0.4	
Валютын зээлийн хүү	14.5	13.5	12.7	12.9	12.0	12.8
өөрчлөлт /пункт/		1.4	-0.8	0.2	-0.9	

Эх үүсвэр: Монголбанкны мэдээлэл

### Төгрөгийн ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 2015 онд 2012 оныхоос 45.0 хувь, 2014 оныхоос 8.4 хувиар суларчээ.

**Хүснэгт 8.2.5 Гадаад валютын ханш, жилийн дундаж, төг, 2012-2015**

	2012	2013	2014	2015
АНУ-ын доллар	1 359.40	1 525.72	1 818.28	1 970.66
Евро	1 748.62	2 029.01	2 414.27	2 187.42
ОХУ-ын рубль	43.81	47.83	48.05	32.46
БНХАУ-ын юань	215.5	248.36	295.11	313.53
БНСУ-ын вон	1.21	1.40	1.73	1.74
Японы иен	17.06	15.63	17.21	16.29
Английн фунт	2 155.55	2 392.01	2 994.67	3 011.98

Эх үүсвэр: Монголбанкны мэдээлэл

### Гадаад валютын цэвэр албан нөөц

Гадаад валютын цэвэр албан нөөц 2012 оныхоос 3.1 дахин буурч, 2015 оны эцэст 1323.1 сая ам.доллар болсон байна.

### Үнэт цаасны зах зээл

Үнэт цаасны арилжаа 2015 онд 2012 оныхоос 6.2 дахин нэмэгдэж, харин ТОП 20 дундаж индекс 2012 онд 19072.0 нэгж байсан бол 2015 онд 13434.2 болж 29.6 хувиар буурчээ. Үнэт цаасны үндсэн үзүүлэлтүүдийг хүснэгт 8.2.6-д харуулав.

## Хүснэгт 8.2.6 Үнэт цаасны зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд, 2012-2015

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012- 2015 оны дундаж
Бүртгэлтэй компаний тоо	351	329	261	237	235	266
Зах зээлийн үнэлгээ, тэрбум төг	1 169.8	1 799.9	1 670.5	1 442.7	1 262.5	1 543.9
Хувьцааны арилжаа						
Үнийн дүн, тэрбум төг	63.9	144.7	97.6	24.2	30.5	74.3
Үнэт цаасны арилжаа						
Засгийн газрын үнэт цаас, тэрбум төг	89.4	0.0	1.0	36.1	510.3	136.9
Компаний бонд, тэрбум төг	2.4	0.3	-	-	0.5	0.4
Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа*, тэрбум төг	-	-	300.5	135.9	357.2	264.6
ТОП-20 индекс						
Дундаж	11 819.6	19 072.0	15 094.9	15 745.0	13 434.2	15 836.5
Хамгийн их	17 251.7	22 286.7	18 301.9	17 160.5	15 737.2	18 371.6
Хамгийн бага	7 720.0	15 101.9	13 188.5	14 475.2	11 962.1	13 681.9
Хаалт	12 055.1	17 714.5	16 301.8	14 854.2	12 897.6	15 442.0
Хийгдсэн хэлцлийн тоо, мянга	30.4	27.0	16.3	13.4	11.5	17.1
Брокер, дилерийн компаний тоо	52	80	79	62	58	70

Эх үүсвэр: Монголын Хөрөнгийн биржийн эцсийн мэдээлэл  
\*Монголбанкны арилжаалсан үнэт цаас

## Даатгал

Даатгалын хураамжийн орлого 2012-2015 онд 44.7 хувь, нөхөн төлбөр 94.9 хувиар өсчээ. Даатгалын байгууллагуудын үндсэн үзүүлэлтүүдийг хүснэгт 8.2.7-д харуулав.

## Хүснэгт 8.2.7 Даатгалын байгууллагын үндсэн үзүүлэлтүүд, 2012-2015

Үзүүлэлт	2008- 2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012- 2015 оны дундаж
Даатгалын хураамжийн орлого, тэрбум төг	30.9	79.0	93.9	108.7	114.3	99.0
Нөхөн төлбөр, тэрбум төг	7.4	16.9	26.5	30.9	33.0	26.8
Даатгалын сангийн өөрчлөлт, тэрбум төг	4.0	13.6	10.5	14.4	6.7	11.3
Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагын тоо	17	18	17	17	17	17
Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагын ажиллагчдын тоо	550	868	1 101	1 183	1 122	1 069

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хорооны мэдээлэл

## Банк бус санхүүгийн байгууллага

Банк бус санхүүгийн байгууллагууд(ББСБ)-ын санхүүгийн цэвэр ашиг 2012 онд 42.0 тэрбум төг байсан бол 2015 онд 96.3 тэрбум төгрөг болж 2.3 дахин, үйл ажиллагаа явуулсан ББСБ-ын тоо 2012-2015 онд 2.1 дахин өсчээ. ББСБ-уудын үндсэн үзүүлэлтүүдийг хүснэгт 8.2.8-д харуулав.

Хүснэгт 8.2.8 Банк бус санхүүгийн байгууллагуудын  
үндсэн үзүүлэлтүүд, тэрбум төг, 2012-2015

Үзүүлэлт	2012	2013	2014	2015
Санхүүгийн орлого	67.7	102.0	127.1	152.2
Санхүүгийн зардал	23.3	39.7	44.8	39.4
Болзошгүй эрсдлийн зардал	2.3	3.4	11.4	16.4
Санхүүгийн цэвэр ашиг	42.0	59.0	71.0	96.3
Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан ББСБ-ын тоо	212	263	378	450

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хорооны мэдээлэл

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Хадгаламж зээлийн хоршоо

Хадгаламж зээлийн хоршоо(ХЗХ)-дын хүүгийн орлого 2015 онд 2012 оныхоос 36.1 хувь, хүүгийн зарлага 31.9 хувиар өсчээ. ХЗХоршоодын үндсэн үзүүлэлтүүдийг хүснэгт 8.2.9-д харуулав.

**Хүснэгт 8.2.9 Хадгаламж зээлийн хоршоодын үндсэн үзүүлэлтүүд, тэрбум төг, 2012-2015**

Үзүүлэлт	2012	2013	2014	2015
Хүүгийн орлого	15.4	16.9	18.4	21.0
Хүүгийн зарлага	8.3	8.9	9.8	11.0
Хүүгийн цэвэр орлого	7.1	8.0	8.6	10.0
Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан ХЗХ-дын тоо	148	141	159	253


Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хорооны мэдээлэл

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### 9.1 МАЛ АЖ АХУЙН САЛБАР

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл, арьс, ширэн эдлэл зэрэг боловсруулах үйлдвэрийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах үндсэн нөхцөл болж байдаг. Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д 13.6 хувийг ХАА-н салбар, экспортын 8.9 хувийг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн эзэлж байна.

Зураг 9.1.1 ДНБ-д ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь, 2011-2015



\* Урьдчилсан гүйцэтгэл

#### Мал аж ахуйн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Манай улс сүүлийн 4 жилд дунджаар 325.7 мян.т мах, 723.7 мян.т сүү, 7.5 мян.т ноолуур, 22.9 мян.т ноос, 11.3 сая ширхэг арьс шир үйлдвэрлэж, өмнөх 4 жилийнхээс бэлтгэсэн мах 80.0 мян.т, сүү 262.0 мян.т, ноолуур 1.5 мян.т, бэлтгэсэн арьс, шир 1.1 сая ширхэгээр өссөн байна.

Хүснэгт 9.1.1 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, биет хэмжээгээр, 2012-2015

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012- 2015 оны дундаж
<b>Мах, нядалгааны жингээр, мян.т</b>	<b>245.7</b>	<b>263.4</b>	<b>299.3</b>	<b>291.7</b>	<b>448.3</b>	<b>325.7</b>
Адууны	30.6	31.1	29.8	29.5	50.8	35.3
Үхрийн	53.7	59.7	57.7	54.9	93.2	66.4
Тэмээний	6.1	5.3	6.7	6.4	8.2	6.7
Хонины	80.0	67.2	91.0	91.3	134.6	96.0
Ямааны	54.7	56.3	64.0	60.5	86.3	66.8
<b>Сүү, мян.т</b>	<b>461.7</b>	<b>588.0</b>	<b>667.0</b>	<b>765.4</b>	<b>874.4</b>	<b>723.7</b>
Гүүний	43.7	55.8	65.1	75.0	85.1	70.3
Үнээний	292.0	337.0	380.6	440.4	512.4	417.6
Ингэний	5.3	8.3	7.5	9.3	9.0	8.5
Хонины	42.7	64.5	74.2	84.7	95.2	79.7
Ямааны	78.0	122.4	139.5	156.0	172.6	147.6
<b>Ноос, ноолуур, мян.т</b>						
Тэмээний ноос	1.1	1.1	1.4	1.5	1.6	1.4
Хонины ноос	19.1	17.5	20.2	22.3	25.8	21.5
Ямааны ноолуур	6.0	6.3	7.0	7.7	8.9	7.5
<b>Арьс, шир, сая.ш**</b>	<b>10.2</b>	<b>8.6</b>	<b>11.0</b>	<b>10.2</b>	<b>15.2</b>	<b>11.3</b>

\* урьдчилсан гүйцэтгэл

\*\*хурга, ишигийн арьсыг оруулсан.



## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Малтай өрх, малчид

Мал тооллогын дүнгээр 2015 оны эцэст улсын хэмжээнд малтай 216.7 мянган өрх тоологдсон байна. Үүний 70.6 хувь буюу 153.1 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх байна.

### Хүснэгт 9.1.2 Өрх, малчдын тоо, насны бүтэц, 2012-2015

Үзүүлэлт	2012	2013	2014	2015
<b>Малтай өрх, мян.өрх</b>	<b>207.8</b>	<b>209.9</b>	<b>213.4</b>	<b>216.7</b>
<b>Малчин өрх, мян.өрх</b>	<b>146.1</b>	<b>145.3</b>	<b>149.7</b>	<b>153.1</b>
<b>Малчдын тоо, мян.хүн</b>	<b>289.6</b>	<b>285.7</b>	<b>293.6</b>	<b>297.8</b>
- 15-34 насны	117.8	110.1	108.6	107.3
- 35-59 насны эмэгтэй, 35-60 насны эрэгтэй	144.0	147.9	156.4	161.9
- тэтгэврийн насны	27.9	27.7	28.6	28.6
<b>Нийт малчдаас эмэгтэй</b>	<b>136.1</b>	<b>134.7</b>	<b>137.4</b>	<b>137.9</b>
<b>Насны бүтэц %</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
- 15-34 насны	40.7	38.5	37.0	36.0
- 35-59 насны эмэгтэй, 35-60 насны эрэгтэй	49.7	51.8	53.3	54.4
- тэтгэврийн насны	9.6	9.7	9.7	9.6

Мал аж ахуйн үйлдвэрлэлд 2015 оны байдлаар 297.8 мянган малчид ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл, 36.0 хувь нь 15-34 насны, 54.4 хувь нь 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насныхан, 9.6 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Сүүлийн 4 жилд малчдын дотор 15-34 насны залуу малчдын эзлэх хувь буурч, харин 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насныхны эзлэх хувь өссөн хэвээр байна.

**Малтай өрхийн бүлэглэлт.** Мал тооллогын дүнгээр 2015 оны эцэст малтай өрх 216.7 мянгад хүрч, малын тоогоор нь бүлэглэвэл, 11 хүртэлх малтай 14.2 мянган өрх буюу нийт малтай өрхийн 6.6 хувь, 11-30 малтай 19.9 мянган өрх буюу 9.2 хувь, 31-50 малтай 15.5 мянган өрх буюу 7.1 хувь, 51-100 малтай 29.3 мянган өрх буюу 13.5 хувь, 101-200 малтай 46.3 мянган өрх буюу 21.3 хувь, 201-500 малтай 60.1 мянган өрх буюу 27.7 хувь, 501-ээс дээш малтай 31.5 мянган өрх буюу 14.5 хувийг эзэлж байна.

### Хүснэгт 9.1.3 Хувийн малтай өрхийн бүлэглэлт, 2012-2015

Малын тооны бүлэг	Малтай өрхийн тоо				Дүнд эзлэх хувь			
	2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015
Дүн	207 818	209 933	213 363	216 734	100.0	100.0	100.0	100.0
≤10	16 827	16 712	14 980	14 226	8.1	8.0	7.0	6.6
11-30	23 449	22 528	20 343	19 933	11.3	10.7	9.5	9.2
31-50	17 792	17 088	15 770	15 478	8.6	8.1	7.4	7.1
51-100	32 902	31 432	29 392	29 266	15.8	15.0	13.8	13.5
101-200	48 474	47 005	46 847	46 250	23.3	22.4	22.0	21.3
201-500	50 468	53 143	58 131	60 075	24.3	25.3	27.2	27.7
501-999	14 276	17 123	21 092	23 070	6.9	8.2	9.9	10.6
1000-1499	3 046	4 076	5 620	6 950	1.5	1.9	2.6	3.2
1500-2000	385	566	816	993	0.2	0.3	0.4	0.5

200 хүртэлх малтай өрх 2012-2015 онд 14.3 мянган өрхөөр буурч, 200-500 толгой малтай өрх 9.6 мянгаар, 500-гаас дээш малтай өрх 13.6 мянгаар өссөн нь малтай өрхийн амьжиргааны түвшин нэмэгдэж байгааг харуулж байна.

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Малын тоо, бүтэц

**Малын тоо.** Сүүлийн жилүүдэд малын тоо толгой тасралтгүй өсч, 2015 онд 56.0 сая толгойд хүрч, хамгийн олон мал тоолуулсан жил боллоо. Малын тоо өмнөх 4 жилийн дундажтай харьцуулахад нийт дүнгээрээ 24.1 хувь, малын төрлөөр 18.6-33.2 хувиар өссөн байна.

### Хүснэгт 9.1.4 Малын тоо, төрлөөр, мян.толгой, 2012-2015

Малын төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
<b>Бүгд</b>	<b>39 094.4</b>	<b>40 920.9</b>	<b>45 144.3</b>	<b>51 982.6</b>	<b>55 979.8</b>	<b>48 506.9</b>
Адуу	2 110.4	2 330.4	2 619.4	2 995.8	3 295.3	2 810.2
Үхэр	2 404.6	2 584.6	2 909.5	3 413.9	3 780.4	3 172.1
Тэмээ	273.3	305.8	321.5	349.3	368.0	336.2
Хонь	16 946.5	18 141.4	20 066.4	23 214.8	24 943.1	21 591.4
Ямаа	17 359.7	17 558.7	19 227.6	22 008.9	23 592.9	20 597.0

Нийт малын 86.7 хувийг бог мал, 5.9 хувийг адуу, 6.8 хувийг үхэр, 0.7 хувийг тэмээ эзэлж байна. Сүрэгт бод малын эзлэх хувь өмнөх 4 жилийн дунджаас 0.6 пунктээр өсч, бог малын эзлэх хувь 0.7 пунктээр буурсан байна.

### Хүснэгт 9.1.5 Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь, 2012-2015

Малын төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
<b>Бод мал</b>	<b>12.3</b>	<b>12.7</b>	<b>12.9</b>	<b>13.1</b>	<b>13.3</b>	<b>13.0</b>
Адуу	5.4	5.7	5.8	5.8	5.9	5.8
Үхэр	6.2	6.3	6.4	6.6	6.8	6.5
Тэмээ	0.7	0.7	0.7	0.7	0.7	0.7
<b>Бог мал</b>	<b>87.7</b>	<b>87.2</b>	<b>87.1</b>	<b>86.9</b>	<b>86.7</b>	<b>87.0</b>
Хонь	43.4	44.3	44.5	44.6	44.6	44.5
Ямаа	44.3	42.9	42.6	42.3	42.1	42.5

Сүүлийн 4 жилийн дунджаар нийт сүрэгт адууны эзлэх хувь 5.8 хувь, үхэр 6.5 хувь, тэмээ 0.7 хувь, 87.0 хувийг бог мал эзэлж, өмнөх 4 жилийн дунджаас адуу, үхэр, хонины хувьд 0.3-1.1 пунктээр өсч, ямааных 1.8 пунктээр буурч, харин тэмээний нийт сүрэгт эзлэх хувь өөрчлөгдөөгүй байна.

**Нэг малчин өрхөд ногдох малын тоо.** Сүүлийн 4 жилийн дунджаар нэг малчин өрхөд 259 толгой мал, төрлөөр авч үзвэл адуу 15, үхэр 17, тэмээ 2, хонь 116, ямаа 110 толгой ногдож байна.

### Хүснэгт 9.1.6 Нэг малчин өрхөд ногдох малын тоо, 2012-2015

Малын төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
<b>Бүгд</b>	<b>211</b>	<b>213</b>	<b>242</b>	<b>257</b>	<b>323</b>	<b>259</b>
Адуу	12	12	14	15	19	15
Үхэр	12	14	16	17	20	17
Тэмээ	1	2	2	2	2	2
Хонь	93	95	108	114	146	116
Ямаа	94	91	103	108	136	110

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

**Хээлтэгч мал.** Хээлтэгч мал 2008-2011 оны дунджаар 17.2 сая байсан бол 2012-2015 онд 20.8 сая болж, 3.6 сая буюу 21.1 хувиар өссөн байна.

Төрлөөр авч үзвэл, гүү 213.9 мян.толгой буюу 34.0 хувь, үнээ 281.4 мян.толгой буюу 29.1 хувь, ингэ 25.8 мян.толгой буюу 28.5 хувь, эм хонь 1973.6 мян.толгой буюу 25.3 хувь, эм ямаа 1139.0 мян.толгой буюу 14.8 хувиар өссөн байна.

### Хүснэгт 9.1.7 Хээлтэгч малын тоо, мян.толгой, 2012-2015

Малын төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
<b>Бүгд</b>	<b>17 190.9</b>	<b>17 748.9</b>	<b>19 436.7</b>	<b>22 248.6</b>	<b>23 863.8</b>	<b>20 824.5</b>
Гүү	628.9	700.9	784.7	895.5	990.0	842.8
Үнээ	965.7	1 046.0	1 151.0	1 333.4	1 458.1	1 247.1
Ингэ	90.5	105.1	112.0	120.2	127.8	116.3
Эм хонь	7 785.3	8 257.1	9 094.9	10 478.0	11 205.4	9 758.9
Эм ямаа	7 720.5	7 639.7	8 294.3	9 421.6	10 082.4	8 859.5

Хээлтэгч мал 2015 онд нийт малын 42.6 хувийг эзэлж байгаа бөгөөд адуун сүргийн 30.0 хувь, үхэр сүргийн 38.6 хувь, тэмээн сүргийн 34.7 хувь, хонин сүргийн 44.9 хувь, ямаан сүргийн 42.7 хувийг эзэлж байна. Сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь сүүлийн 4 жилд өмнөх 4 жилийнхээс дүнгээрээ 1.0 пунктээр, үнээ, эм хонь, эм ямааных 0.7-1.5 пунктээр буурч, гүү, ингэний эзлэх хувь 0.2-1.5 пунктээр өссөн байна.

### Хүснэгт 9.1.8 Сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь, 2012-2015

Малын төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
<b>Бүгд</b>	<b>44.0</b>	<b>43.4</b>	<b>43.1</b>	<b>42.8</b>	<b>42.6</b>	<b>42.9</b>
Гүү	29.8	30.1	30.0	29.9	30.0	30.0
Үнээ	40.2	40.5	39.6	39.1	38.6	39.3
Ингэ	33.1	34.4	34.8	34.4	34.7	34.6
Эм хонь	45.9	45.5	45.3	45.1	44.9	45.2
Эм ямаа	44.5	43.5	43.1	42.8	42.7	43.0

**Төл бойжилт.** 2015 оны байдлаар оны эхний эх малын 89.6 хувь буюу 19931.2 мянган эх мал төллөж, гарсан төлийн 95.8 хувь буюу 19179.5 мянган төл бойжуулсан. Бойжуулсан төл 2014 оныхоос 1933.5 мян.толгой буюу 11.2 хувиар өсч, бойжилтын хувь 2.0 пунктээр буурсан байна.

### Хүснэгт 9.1.9 Бойжуулсан төл, мян.толгой, 2012-2015

Малын төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
<b>Бүгд</b>	<b>11 621.8</b>	<b>13 379.0</b>	<b>15 221.0</b>	<b>17 246.0</b>	<b>19 179.5</b>	<b>16 256.4</b>
Унага	375.3	476.9	550.6	638.5	726.4	598.1
Тугал	648.2	751.3	845.5	974.1	1 135.8	926.7
Ботго	39.9	52.4	49.2	59.2	57.0	54.5
Хурга	5 584.2	6 327.9	7 287.5	8 299.5	9 299.9	7 803.7
Ишиг	4 974.2	5 770.5	6 488.2	7 274.7	7 960.5	6 873.5

Бойжуулсан төл 2008-2011 онд жилд дунджаар 11.6 сая байсан бол 2012-2015 онд 16.3 сая болж, 4.6 сая буюу 39.9 хувиар өсчээ.

**Том малын зүй бус хорогдол.** Сүүлийн 4 жилд ган, зуд зэрэг байгалийн ноцтой үзэгдэл тохиолдоогүй учир малын хорогдол буурч, нийтдээ 2.2 сая, жилд дунджаар 0.6 сая мал хорогдсон нь өмнөх 4 жилийн дунджаас 6.4 дахин буурсан байна.

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Хүснэгт 9.1.10 Том малын зүй бус хорогдол, мян.толгой, 2012-2015

Малын төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
<b>Бүгд</b>	<b>3 586.2</b>	<b>428.9</b>	<b>792.6</b>	<b>401.4</b>	<b>625.6</b>	<b>562.1</b>
Адуу	145.6	21.0	35.9	23.3	31.2	27.9
Үхэр	218.5	36.5	75.0	34.0	41.2	46.7
Тэмээ	6.4	1.4	1.8	1.5	1.9	1.7
Хонь	1 495.5	175.5	347.2	155.6	269.6	237.0
Ямаа	1 720.2	194.4	332.7	186.9	281.8	249.0

Улсын хэмжээнд 2015 оны байдлаар 2877 эрчимжсэн фермерийн аж ахуй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оныхтой харьцуулахад фермерийн аж ахуйн тоо 140 буюу 4.6 хувиар буурсан байна.

### Хүснэгт 9.1.11 Эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо, 2012-2015

Төрөл	2012	2013	2014	2015	2015/2014	
					Хувь	Зөрүү
<b>Бүгд</b>	<b>1 706</b>	<b>11 983</b>	<b>3 017</b>	<b>2 877</b>	<b>95.4</b>	<b>- 140</b>
Сүүний үхрийн ферм	977	912	1 432	1 440	100.6	8
Махны үхрийн ферм	78	88	351	248	70.7	- 103
Мах, ноосны хонины ферм*	229	10 259	236	397	168.2	161
Гахайн ферм	181	314	476	331	69.5	- 145
Тахианы ферм	152	319	405	244	60.2	- 161
Зөгийн ферм	89	64	83	161	194.0	78

\* 2013 онд мах ноосны хонь үржүүлж буй өрхийг оруулан тооцсон.

### Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл

**Тариалсан талбай.** Тариалсан талбайн хэмжээ 2008-2011 оны дунджаар 285.1 мян.га байсан бол сүүлийн 4 жилийн дунджаар 440.2 мян.га болж, 155.1 мян.га буюу 54.4 хувиар өссөн байна.

Улсын хэмжээгээр 2015 онд нийт 525.0 мян.га талбайд тариалалт хийснээс 390.7 мян.га-д үр тариа, 12.8 мян.га-д төмс, 7.7 мян.га-д хүнсний ногоо, 23.8 мян.га-д тэжээлийн ургамал, 84.5 мян.га-д техникийн ургамал тариалсан нь өмнөх оныхоос нийт тариалсан талбай 84.4 мян.га буюу 19.2 хувиар нэмэгдсэн байна.

### Хүснэгт 9.1.12 Тариалсан талбай, мян.га , 2012-2015

Малын төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							%
							2008-2011 оны дундаж
Тариалсан талбай, бүгд	285.1	379.8	415.4	440.6	525.0	440.2	154.4
Үр тариа	241.4	306.2	293.3	315.0	390.7	326.3	135.2
Буудай	235.1	297.3	275.6	291.2	361.2	306.3	130.3
Төмс	13.8	16.8	15.5	13.2	12.8	14.6	105.6
Хүнсний ногоо	6.9	7.9	8.3	8.7	7.7	8.2	118.1

### Хураасан ургац

Хураан авсан үр тариа 2008-2011 оны дунджаар 351.5 мян.т байсан бол 2012-2015 оны дунджаар 400.4 мян.т болж, 48.9 мян.т буюу 13.9 хувиар өсчээ.

2008-2011 оны дунджаар 163.9 мян.т төмс, 84.5 мян.т хүнсний ногоо хураан авч байсан бол сүүлийн 4 жилийн дунджаар 190.7 мян.т төмс, 94.5 мянган тонн хүнсний ногоо хураан авч, төмс 26.8 мян.т буюу 16.4 хувиар, хүнсний ногоо 10.0 мян.т буюу 11.8 хувиар нэмэгдсэн байна.

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Хүснэгт 9.1.13 Хураасан ургац, мян.тн, 2012-2015

Малын төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							% 2008-2011 оны дундаж
Үр тариа	351.5	479.3	387.0	518.8	216.3	400.4	113.9
Буудай	344.8	465.3	368.5	488.3	203.9	381.5	110.6
Төмс	163.9	245.9	191.6	161.5	163.8	190.7	116.4
Хүнсний ногоо	84.5	98.9	101.8	104.8	72.3	94.5	111.8

#### Ургац хураалтад нөлөөлсөн хүчин зүйл

Үр тарианы тариалсан талбай 2015 онд 75.7 мян.га буюу 24.0 хувиар нэмэгдсэн ч нэг га-гаас хураасан ургацын хэмжээ өмнөх оныхоос 10.9 цн буюу 66.4 хувиар буурсан нь ургацын хэмжээг 302.5 мян.т буюу 58.3 хувиар буурахад нөлөөлсөн байна.

Төмсний тариалсан талбай 2015 онд 0.4 мян.га буюу 2.8 хувиар буурсан ч нэг га-гаас хураасан ургацын хэмжээ өмнөх оныхоос 5.3 цн буюу 4.3 хувиар нэмэгдсэн нь ургацын хэмжээг 2.3 мян.т буюу 1.4 хувиар нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

### Хүснэгт 9.1.14 Ургацын хэмжээнд нөлөөлсөн зарим хүчин зүйл, мян.т, 2012-2015

	Ургац хураалтын нийт өсөлт, бууралт		Га-гийн ургац		Тариалсан талбай	
	Хувь	Зөрүү	хувь	Зөрүү	хувь	Зөрүү
Үр тариа	-58.3	-302.5	-66.4	-10.9	24.0	75.7
Төмс	1.4	2.3	4.3	5.3	-2.8	-0.4

#### Га-гийн ургац

Улсын хэмжээнд 2015 онд нэг га-аас дунджаар 5.5 цн үр тариа, үүнээс 5.6 цн буудай, 3.8 цн арвай, 2.6 цн овьёос, 127.5 цн төмс хураан хураан авсан байна.

### Хүснэгт 9.1.15 Нэг га талбайгаас хураасан ургац, центнерээр, 2012-2015

Малын төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж
							% 2008-2011 оны дундаж
Үр тариа	14.5	15.7	13.2	16.5	5.5	12.7	87.8
Улаанбуудай	14.6	15.6	13.4	16.8	5.6	12.9	88.0
Арвай	11.7	14.1	13.6	12.3	3.8	11.0	93.6
Овьёос	11.5	17.9	13.4	17.9	2.6	13.0	112.6
Төмс	118.5	146.2	123.6	122.3	127.5	129.9	109.6

Үр тариа, төмсний га-гийн ургацын 2012-2015 оны дундажийг 2008-2011 оныхтой харьцуулахад үр тарианых 1.8 центнер буюу 12.2 хувиар буурч, төмснийх 11.4 центнер буюу 9.6 хувиар өссөн байна.

#### Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт.

Гааль, татварын ерөнхий газар, УБСЕГ-ын албан ёсны статистик мэдээллээр 2012-2015 оны дунджаар 393.0 мян.т улаан буудай, 195.4 мян.т төмс, 163.7 мян.т хүнсний ногоо зах зээлд нийлүүлснээс улаан буудайн 97.1 хувь, төмсний 90.6 хувь хүнсний ногооны 57.7 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, үлдсэн хувийг импортын бүтээгдэхүүнээр хангасан байна.

Дотоодын үйлдвэрлэгчдийн улаан буудайн нийт үйлдвэрлэл 2008-2011 оны дунджаас 36.7 мян.т буюу 10.6 хувь, төмснийх 26.8 мян.т буюу 16.4 хувь, хүнсний ногооных 10.0 мян.т буюу 11.8 хувиар нэмэгдсэн байна



## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Хүснэгт 9.1.16 Үйлдвэрлэл, нийлүүлэлтийн харьцаа, 2012-2015

	Нийт нийлүүлэлт, (мян.т) (дотоодын үйлдвэрлэл+импорт)		Дотоодын үйлдвэрлэл, мян.т		Нийт нийлүүлэлтэд дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь	
	2008-2011 оны дундаж	2012-2015 оны дундаж	2008-2011 оны дундаж	2012-2015 оны дундаж	2008-2011 оны дундаж	2012-2015 оны дундаж
Улаан буудай	435.2	393.0	344.8	381.5	79.2	97.1
Төмс	182.1	195.4	163.9	190.7	90.0	97.6
Хүнсний ногоо	143.6	163.7	84.5	94.5	58.8	57.7

Төмсний нийт үйлдвэрлэлд дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь нь сүүлийн 4 жилийн дунджийг 2008-2011 оныхтой харьцуулахад 7.6 пункт, улаан буудайнх 17.9 пунктээр нэмэгдэж, хүнсний ногооных 1.1 пунктээр буурсан байна.

### 9.2 АЖ ҮЙЛДВЭР

ДНБ-д аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь 2015 онд 32.2 болж, 2012 оныхоос 6.4 пункт, 2013 оныхоос 6.8 пункт, 2014 оныхоос 5.2 пунктээр өссөн байна.

#### Хүснэгт 9.2.1 Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг, оны үнээр\*, сая төг, 2012-2015

Салбар	2012	2013	2014	2015**	ДНБ-д эзлэх хувь			
					2012	2013	2014	2015**
<b>Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг, сая төг</b>	<b>4 297.8</b>	<b>4 869.8</b>	<b>6 012.0</b>	<b>6 294.4</b>	<b>25.8</b>	<b>25.4</b>	<b>27.0</b>	<b>32.2</b>
Уул уурхай, олборлолт	2 742.8	2 849.4	3661	3867.7	19.1	20.2	22.4	24.7
Боловсруулах үйлдвэрлэл	1 248.7	1 672.3	1 950.9	1 939.8	6.1	6.0	5.8	5.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	233.9	270.5	313.6	380.4	1.7	1.6	1.5	1.6
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	72.5	77.5	86.5	106.5	0.2	0.2	0.2	0.2

\* Нөөц, ашиглалтын хүснэгтийн 2012-2014 оны үр дүнгээр тодотгосон.

\*\* Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, 2015 онд урьдчилсан гүйцэтгэлээр 13734.6 тэрбум төгрөгт хүрч, 2012 оныхоос 39.8 хувь буюу 3913.2 тэрбум төг, 2013 оныхоос 31.5 хувь буюу 3290.9 тэрбум төгрөгөөр өсч, харин 2014 оныхоос 4.6 хувь буюу 668.4 тэрбум төгрөгөөр буурлаа.

#### Хүснэгт 9.2.2 Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, оны үнээр, тэрбум төг\*, 2012-2015

Малын төрөл	2012	2013	2014	2015**	2015 / 2014 %	
					Зөрүү	Хувь
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл	9 821.3	10 443.7	14 402.9	13 734.6	- 668.4	95.4
Уул уурхай, олборлолт	5 787.0	6 099.8	9 271.3	8 685.7	- 585.6	93.7
Боловсруулах үйлдвэрлэл	3 012.1	3 212.8	4 042.7	3 741.1	- 301.5	92.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	824.1	904.5	842.8	1 024.6	181.9	121.6
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	198.1	226.7	246.2	283.1	36.9	115.0


\* Нөөц, ашиглалтын хүснэгтийн 2012-2014 оны үр дүнгээр тодотгов.

\*\* Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ нь уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлээс ихээхэн хамаарах хандлагатай байна. Тухайлбал, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, оны үнээр 2015 онд 2012 оныхоос 39.8 хувь буюу 3913.2 тэрбум төгрөгөөр өсөхөд нийт өсөлтийн 74.1 хувь буюу 2898.6 тэрбум төг нь уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлээс, харин өмнөх оныхоос 4.6 хувиар буюу 668.4 тэрбум төгрөгөөр буурахад 87.6 хувь нь буюу 585.6 тэрбум төг нь уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаарсан байна.

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

**Зураг 9.2.1 Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, оны үнээр, тэрбум төг, 2012-2015**



\* Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарт 400 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаас зэсийн баяжмал, газрын тос, алт, нүүрс, төмрийн хүдэр, молибдений баяжмал, цайрын баяжмал, шар айраг, архи, гурил, амтат ус, ундаа, самнасан ноолуур, тамхи, жүүс, шингэн сүү, сүлжмэл эдлэл, металл цувимал, талх, нарийн боов, цахилгаан эрчим хүч, дулаан, түгээсэн цэвэр ус зэрэг гол нэр төрлийн 20 гаруй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нийт үйлдвэрлэлтэд 90 гаруй хувийг эзэлж байна. Эдгээр гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл цаашид нэмэгдэх хандлагатай байна.

**Хүснэгт 9.2.3 Уул уурхай, олборлох салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 2012-2015**

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015* оны дундаж
Нүүрс	сая т	20.4	29.9	30.1	25.3	24.2	27.4
Газрын тос	сая барр	1.9	3.6	5.1	7.4	8.8	6.2
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	сая т	0.5	0.5	0.8	1.1	1.3	0.9
Молибдений баяжмал, металл агуулгаараа	мян.т	4.3	3.9	3.7	4.1	5.2	4.2
Алт	т	9.2	6.0	8.9	11.5	14.6	10.2
Хайлуур жонш	сая т	0.6	0.5	0.2	0.3	0.2	0.3
Хайлуур жоншны баяжмал	сая т	0.1	0.2	0.1	0.1	0.0	0.1
Төмрийн хүдэр	сая т	2.8	6.9	5.0	6.3	4.3	5.6
Төмрийн хүдрийн баяжмал	сая т	0.3	5.2	6.1	4.0	1.9	4.3

\* Урьдчилсан гүйцэтгэл

Сүүлийн жилүүдэд төр, засгаас үйлдвэржилтийг дэмжсэн бодлого, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн үүний үр дүнд боловсруулах салбарт эмчилгээний цай, аяны уутан хөнжил, даавуун, савхин, цаасан уут, тор, нэхий нуруувч, нэхий гутал, бэлхэнз, амны хаалт (маск), баяжмалын даавуун шүүлтүүр, стикер, даавуун хэвлэл, шахмал түлш, эмнэлгийн боолтын материал, тосон түрхлэг, эмнэлэгийн зориулалттай спирт, гар нүүрийн саван, аяга, таваг угаагч, лед гэрэл, ванн, угаалтуур, барилгын шавардлагын зориулалттай хар замаск, пилтаны цавуу, бетон зуурмагийн уян налархайжуулагч, сэндвичэн хавтан, хөнгөн цагаан эдлэл, барилгын дээврийн хавтан төмөр, цахилгаан дамжуулагч уртасгагч залгуур, таблет, өнгөт телевизэр зэрэг бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж эхэллээ.



## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Хүснэгт 9.2.4 Боловсруулах салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 2012-2015

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015* оны дундаж
Катодын зэс, 99%	мян.т	2.5	2.3	2.3	7.0	15.0	6.7
Металл бэлдэц	мян.т	63.9	68.1	56.0	64.4	43.7	58.1
Металл цувимал	мян.т	57.7	57.0	69.3	73.9	49.5	62.4
Цемент	мян.т	313.1	349.4	258.8	411.3	410.1	357.4
Шохой	мян.т	48.4	68.2	56.7	58.0	52.3	58.8
Улаан тоосго	сая ш	26.6	59.2	66.5	58.9	41.5	56.5
Хүрмэн блок	сая ш	0.7	1.7	2.2	3.9	2.3	2.5
Самнасан ноолуур	мян.т	1.3	0.4	0.5	0.6	0.8	0.6
Хивс	сая м2	0.7	0.9	0.9	0.7	0.7	0.8
Савхин гутал, ботинк	мян.хос	7.5	18.3	26.5	49.3	70.6	41.2
Нэхий дээл	мян.ш	15.6	9.0	16.8	14.2	10.2	12.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн	сая л	32.9	72.8	63.9	71.1	70.3	69.6
Малын мах	мян.т	13.9	13.2	19.8	16.8	12.6	15.6
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	мян.т	1.8	2.2	2.3	3.5	3.5	2.9
Спирт	сая л	4.3	10.8	10.0	9.1	8.7	9.6
Архи, дарс	сая л	19.7	26.9	24.9	24.3	21.2	24.3
Шар айраг	сая л	38.6	65.1	63.8	67.7	74.9	67.9
Амтат ус, ундаа	сая л	58.2	74.6	78.9	92.5	112.6	89.6
Гурил	мян.т	104.0	145.6	246.5	228.4	209.2	207.4
Талх	мян.т	23.7	25.4	25.0	30.2	28.6	27.3
Тамхи	сая блок	7.5	7.0	6.3	6.4	5.1	6.2

\* Урьдчилсан гүйцэтгэл

#### Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл

Цахилгаан эрчим хүчний нийт нөөц 2015 онд 6930.0 сая квт.цаг болж, 2012 оныхоос 1748.4 сая квт.цаг буюу 33.7 хувь, 2013 оныхоос 715.0 сая квт.цаг буюу 11.5 хувь, 2014 оныхоос 205.0 сая квт.цаг буюу 3.0 хувиар нэмэгдсэн байна.

Цахилгаан эрчим хүчний нийт нөөцийн 79.6 хувийг дотооддоо үйлдвэрлэж, 20.4 хувийг БНХАУ болон ОХУ-аас импортоор авч хэрэглэсэн байна.

Цахилгаан станцууд 2015 онд дотоод хэрэглээндээ нийт үйлдвэрлэсэн цахилгааныхаа 14.1 хувийг хэрэглэсэн нь 2012 оныхоос 0.7 пункт, 2013, 2014 оныхоос тус бүр 0.3 пунктээр буурчээ.

Түгээлтийн болон шугамын алдагдлын нийт үйлдвэрлэлд эзлэх хувь 2015 онд 14.2 хувь болж, 2012 оныхоос 0.2 пунктээр өсч, харин 2013, 2014 оныхоос 0.5 пунктээр буурчээ.

#### Хүснэгт 9.2.5 Цахилгаан эрчим хүчний тэнцэл, сая квт.цаг, 2012-2015

Үзүүлэлтүүд	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2014 оны дундаж
Нөөц-Бүгд	4 445.3	5 181.6	6 215.0	6 725.0	6 930.0	6 262.9
Үйлдвэрлэсэн	4 222.2	4 815.6	5 019.5	5 375.8	5 513.2	5 181.0
Импорт	223.1	366.0	1 195.5	1 349.2	1 416.8	1 081.9
Хуваарилалт-Бүгд	4 445.3	5 181.6	6 215.0	6 756.8	6 895.0	6 262.1
Хэрэглэсэн	3 239.1	3 772.6	4 732.1	5 158.4	5 283.5	4 736.7
Аж үйлдвэр, барилга	2 009.0	2 338.9	2 930.7	3 171.6	3 261.4	2 925.6
Тээвэр, холбоо	134.8	156.8	196.9	211.4	216.5	195.4
Хөдөө аж ахуй	34.2	39.8	49.9	63.7	54.8	52.1
Өрх, орон сууц, нийтийн аж ахуй	777.3	906.7	1 139.2	1 251.4	1 277.5	1 143.7
Бусад	283.8	330.4	415.4	460.4	473.3	419.9
Түгээлтийн болон шугамын алдагдал	519.9	675.4	739.5	792.6	782.6	747.5
Цахилгаан станцын дотоодын хэрэглээ	666.4	712.4	725.3	772.4	778.2	747.1
Экспорт	20.0	21.2	18.2	33.4	50.8	30.9
Нэг хүн амд ногдох үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч, кВт.ц	1 568.3	1 762.3	1 797.9	1 866.2	1 860.0	1 821.6

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Дулааны эрчим хүч

Дулаан үйлдвэрлэл 2015 онд 10679.5 мян.гкал-т хүрч, 2012 оныхоос 1357.6 мян.гкал буюу 14.6 хувь, 2013 оныхоос 1167.8 мян.гкал буюу 12.3 хувь, 2014 оныхоос 647.2 мян.гкал буюу 6.5 хувиар өсчээ.

Цахилгаан, дулааны станцууд 2015 онд нийт үйлдвэрлэлийн 6.1 хувьтай тэнцэх дулааныг дотооддоо хэрэглэж, 90.9 хувийг нь айл өрх, аж ахуйн нэгжид түгээсэн байна. Харин нийт дулааны хэрэглээний 325.2 мян.гкал буюу 3.0 хувийг нь дулаан түгээх явцад алдсан нь 2012 оныхоос 0.3 пунктээр өсч, харин 2013, 2014 оныхоос 0.3 пунктээр тус буурсан байна.

**Хүснэгт 9.2.6 Дулааны эрчим хүчний тэнцэл, мян.гкал, 2012-2015**

Үзүүлэлтүүд	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2014 оны дундаж
Үйлдвэрлэсэн	8 281.4	9 321.8	9 511.7	10 032.3	10 679.5	9 886.3
Дулааны цахилгаан станцын дотоод хэрэглээ	359.1	378.7	522.5	536.6	647.3	521.3
Аж ахуйн нэгж, байгууллага болон өрхөд түгээсэн-Бүгд	7 729.8	8 692.7	8 671.7	9 163.1	9 706.9	9 058.6
Аж үйлдвэр, барилга	2 079.9	2 108.7	2 161.8	2 176.6	2 358.5	2 201.4
Тээвэр, холбоо	275.8	281.1	309.1	299.9	316.7	301.7
Хөдөө аж ахуй	40.2	33.4	49.0	43.3	47.6	43.3
Өрх, орон сууц, нийтийн аж ахуй	3 459.8	3 737.0	3 818.5	3 930.2	4 039.6	3 881.3
Бусад	1 874.0	2 532.5	2 333.3	2 713.1	2 944.5	2 630.8
Түгээлтийн алдагдал	192.5	250.4	317.5	332.6	325.2	306.4

### 9.3 БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2015 онд 2359.4 тэрбум төгрөгт хүрч, 2012 оныхоос 2.3 дахин буюу 1325.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Барилга угсралт, их засварын ажлын бүтцийг авч үзвэл, 2012 онд нийт барилга угсралт, их засварын ажлын 32.5 хувийг орон сууцны барилга, 34.8 хувийг орон сууцны бус худалдаа, үйлчилгээний барилга, 19.6 хувийг эрчим хүчний, авто замын зэрэг инженерийн байгууламж, 13.1 хувийг их засварын ажил эзэлж байсан бол 2015 онд 46.2 хувийг орон сууцны барилга, 27.1 хувийг орон сууцны бус барилга, 24.1 хувийг инженерийн байгууламж, 2.6 хувийг их засварын ажил эзэлж байна.

**Зураг 9.3.1 Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр, 2012-2015**



## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

Их засварын ажил нийт барилга, угсралт их засварын нийт ажилд эзлэх хувь буурч, орон сууцны барилгынх нэмэгдсэн байна. Үүнд Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж байгаа иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ажлууд нөлөөлсөн байна.

### Хүснэгт 9.3.1 Барилгын салбарын үндсэн үзүүлэлт, 2012-2015

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015* оны дундаж
Барилга угсралт, их засварын ажил, тэрбум төг	533.6	1034.1	1845.9	2582.8	2359.4	1955.5
Ашиглалтад оруулсан барилга угсралт, их засварын ажил, тэрбум төг	512.9	895.7	1564.7	2921.5	2878.7	2065.2
Барилгын салбарын нэмэгдэл өртөг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг	64.8	568.8	614.2	588.0	580.0*	587.8
Барилгын салбарын НӨ-ийн өөрчлөлт, (%)	-	207.9	117.0	100.9	98.4*	-
Барилгын салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь, (%)	-	5.9	5.8	5.1	4.7*	-
Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо	1 665	3 135	3 541	4 770	5 390	4 209
Ажиллагчдын тоо, мян.хүн	54.3	59.2	72.4	81.1	88.1	75.2
Ажиллагчдын сарын дундаж цалин, мян.төг	261.9	485.2	704.1	678.7	724.3	648.1

\* Урьдчилсан гүйцэтгэл

Улсын хэмжээнд ашиглалтад оруулсан барилга байгууламж 2015 онд 2012 оныхоос 3.2 дахин буюу 1983.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2878.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Сүүлийн 4 жилийн хугацаанд жилд дунджаар 18684 айлын орон сууцны барилга баригджээ.

### Хүснэгт 9.3.2 Ашиглалтад оруулсан үндсэн фонд, 2012-2015

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
<b>Барилгын төрлөөр, тэрбум төг</b>	<b>512.9</b>	<b>895.7</b>	<b>1 564.7</b>	<b>2 921.5</b>	<b>2 878.7</b>	<b>2 065.2</b>
Орон сууцны барилга	302.9	389.4	856.9	1 430.9	1 496.1	1 043.3
Худалдаа, үйлчилгээний барилга	35.0	30.7	49.9	140.9	151.9	93.4
Эмнэлгийн барилга	5.4	20.5	5.5	16.3	30.2	18.1
Сургууль, соёлын барилга	25.1	68.4	64.8	187.6	287.7	152.1
Авто зам	24.4	44.9	335.2	412.1	330.1	280.6
Гүүр, гүүрэн гарц	3.4	13.4	7.9	18.3	15.5	13.8
Бусад	116.6	328.4	244.5	715.4	567.3	463.9
<b>Хүчин чадал, биет хэмжээгээр</b>						
Орон сууцны барилга, айлын тоогоор	8 250.5	11 413	18 012	22 546	22 766	18 684.3
Эмнэлэг, орны тоогоор	299	613	228	530	1 011	595.5
Сургууль, соёлын барилга, суудлын тоогоор	12 997.8	19 628	20 012	24 806	30 026	23 618
Авто зам, км-ээр	123.5	120.2	1 213.1	866.3	716.9	729.1
Гүүр, гүүрэн гарц, метрээр	318.4	618.9	551.6	1 454.2	882.4	876.8

\* Урьдчилсан дүн

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

Аж ахуйн нэгж, байгууллагууд 2012 онд 11413 айлын сууц барьсан бол 2015 онд 22766 айлын 293 барилга барьсан байна. Мөн эрчим хүчний 277, албан тасалгааны зориулалтаар 77, сургууль, соёлын 112, далан, суваг, шугам сүлжээний 108, худалдаа, үйлчилгээний зориулалтын 90, үйлдвэрлэлийн зориулалтаар 20, зочид буудлын 5, нийтдээ 1697 барилга, байгууламжийг ашиглалтад оруулсан байна.

Барилгын гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2012 - 2015 оны дунжийг 2008-2011 оныхтой харьцуулахад цемент 14.1 хувиар, бетон зуурмаг 4.5 дахин, улаан тоосго 2.1 дахин, металл цувимал 8.1 хувь өссөн нь сүүлийн жилүүдэд барилгын ажлын хэмжээ нэмэгдэж байгаатай шууд холбоотой байна.

### Хүснэгт 9.3.3 Барилгын зарим нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2012-2015

Барилгын материалын нэр	Хэмжих нэгж	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Цемент	мян.тн	313.1	349.4	258.8	411.3	410.1	357.4
Бетон зуурмаг	мян.м <sup>3</sup>	58.4	176.2	317.8	432.6	129.0	263.9
Шохой	мян.тн	48.4	68.2	56.7	58.0	52.3	58.8
Улаан тоосго	сая.ш	26.6	59.2	66.5	58.9	41.5	56.5
Металл бэлдэц	мян.тн	63.9	68.1	56.0	64.4	43.7	58.1
Металл цувимал	мян.тн	57.7	57.0	69.3	73.9	49.5	62.4

Барилгын материалын 2015 онд импортын хэмжээ 2012 оныхтой харьцуулахад шохой 64.4 хувиар, цемент 25.8 хувиар, барилгын блок 69.1 хувиар, хар төмрөн хийц, барилгын хийц 76.1 хувиар буурсан байна.

### Хүснэгт 9.3.4 Барилгын зарим материалын импортын хэмжээ, 2012-2015

Барилгын нэр төрөл	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015
Шохой	т	87.2	18.0	54.0	31.0
Цемент	мян.т	1 192.3	1 525.0	1 506.0	884.3
Зүсмэл материал	м <sup>3</sup>	6 321.2	18 768.4	33 528.8	13 762.4
Барилгын блок	м <sup>3</sup>	70 404.2	71 084.8	52 864.6	21 759.9
Асбест-цемент	т	1 695.0	2 255.0	1 526.0	547.9
Галд тэсвэртэй гулдмай, хавтанцар	т	5 261.9	4 377.0	3 147.0	5 215.6
Хар төмөр хийц, барилгын хийц	т	80 458.0	60 695.0	52 710.5	19 191.1

## 9.4 ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2015 онд 35.8 сая т ачаа, давхардсан тоогоор 260.0 сая зорчигч тээвэрлэж, ачаа эргэлт 14610.2 сая т.км, зорчигч эргэлт 4061.2 сая хүн км, орлого 1080.7 тэрбум төгрөгт хүрэв. Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 2012 оныхтой харьцуулахад 29.2 хувь, зорчигчид 18.2 хувиар буурч, харин тээврийн нийт орлого 3.8 хувиар өсчээ. Тээсэн ачаа жилд дунджаар 2012-2015 онд 2008-2011 оныхоос 42.0 хувь, зорчигчид 21.7 хувиар өссөн байна.

### Хүснэгт 9.4.1 Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Тээсэн ачаа, мян.т	30 535.7	50 644.3	42 361.4	44 636.2	35 835.8	43 369.4
Ачаа эргэлт, сая т.км	11 632.3	15 656.4	14 641.9	17 419.5	14 610.2	15 582.0
Зорчигч тээвэрлэлт, сая хүн	252.7	318.0	307.9	344.2	260.0	307.5
Зорчигч эргэлт, сая хүн км	3 772.3	4 972.4	4 604.2	5 235.4	4 061.2	4 718.3
Шилжүүлсэн сая т.км	13 624.6	18 159.1	16 915.2	19 845.5	16 486.2	17 851.5
Тээврийн орлого, тэрбум төг	559.8	1 041.1	1 035.9	1 038.3	1 080.7	1 049.0

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Хүснэгт 9.4.2 Ачаа болон зорчигч тээвэрлэлтийн бүтэц, тээврийн төрлөөр, хувиар, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
<b>Ачаа тээвэр:</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
төмөр замын	52.5	40.4	49.7	47.3	53.4	47.1
авто	47.5	59.6	50.3	52.7	46.6	52.9
агаарын	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>Зорчигч тээвэр:</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
төмөр замын	1.5	1.3	1.2	1.0	1.1	1.1
авто	98.4	98.5	98.5	98.8	98.7	98.6
агаарын	0.2	0.2	0.3	0.2	0.2	0.2
усан замын	0.003	0.012	0.008	0.012	0.018	0.012

Тээврийн салбарт 2015 онд давхардсан тоогоор нийт 260.0 сая зорчигч тээвэрлэснээс 98.7 хувь нь авто тээврээр, 1.1 хувь нь төмөр замаар, 0.2 хувь нь агаарын тээврээр, 0.018 хувь усан замын тээврээр зорчсон байна.

Нийт ачаанд авто тээврээр тээсэн ачаа 2012-2015 онд дунджаар 52.9 хувийг эзэлж байгаа нь 2008-2011 оны дунджаас 5.3 пунктээр нэмэгдэж, төмөр замаар тээсэн ачааных 5.3 пунктээр буурчээ.

**Агаарын тээвэр:** Агаарын тээврээр тээсэн ачаа 2015 онд 2839.3т, зорчигчид давхардсан тоогоор 616.4 мян.хүн, агаарын тээврийн орлого 247.7 тэрбум төг болж 2012 оныхоос тээсэн ачаа 29.2 хувь, зорчигчид 20.0 хувиар буурч, харин орлого 19.7 хувиар нэмэгджээ.

### Хүснэгт 9.4.3 Агаарын тээврийн үндсэн үзүүлэлт, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012- 2015 оны дундаж	2012-2015 оны дундаж % 2008-2011 оны дундаж
<b>Тээсэн ачаа, т</b>	<b>1 946.9</b>	<b>4 011.1</b>	<b>4 075.6</b>	<b>3 436.7</b>	<b>2 839.3</b>	<b>3 590.7</b>	<b>184.4</b>
шуудан	382.9	409.1	381.1	261.5	218.3	317.5	82.9
тээш	319.3	480.0	561.7	260.5	213.0	378.8	118.6
ачаа	1 244.6	3 122.0	3 132.8	2 914.7	2 408.0	2 894.4	232.6
<b>Ачаа эргэлт, мян т.км</b>	<b>5 864.0</b>	<b>9 736.8</b>	<b>9 590.2</b>	<b>9 397.6</b>	<b>7 682.2</b>	<b>9 101.7</b>	<b>155.2</b>
шуудан	853.9	816.2	814.9	597.0	498.4	681.6	79.8
тээш	612.8	631.6	660.8	433.7	386.2	528.1	86.2
ачаа	4 397.2	8 289.0	8 114.5	8 366.9	6 797.6	7 892.0	179.5
<b>Зорчигч тээвэрлэлт, мян. хүн</b>	<b>411.8</b>	<b>770.2</b>	<b>777.9</b>	<b>682.2</b>	<b>616.4</b>	<b>711.7</b>	<b>172.8</b>
олон улсын	288.7	441.8	452.2	442.1	425.6	440.4	152.5
дотоодын	123.0	328.5	325.8	240.1	190.8	271.3	220.5
<b>Зорчигч эргэлт, сая хүн.км</b>	<b>877.0</b>	<b>1 223.1</b>	<b>1 311.8</b>	<b>1 247.1</b>	<b>1 123.1</b>	<b>1 226.3</b>	<b>139.8</b>
<b>Шилжүүлсэн сая т.км</b>	<b>83.8</b>	<b>120.7</b>	<b>129.0</b>	<b>122.9</b>	<b>109.9</b>	<b>120.6</b>	<b>144.0</b>
<b>Тээврийн орлого, сая төг</b>	<b>125 943.7</b>	<b>206 908.3</b>	<b>247 291.5</b>	<b>246 201.3</b>	<b>247 725.4</b>	<b>237 031.7</b>	<b>188.2</b>

**Төмөр зам:** Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2015 онд 19.2 сая т, зорчигчид 2.8 сая хүн, орлого 387.9 тэрбум төг болж, 2012 оныхоос тээсэн ачаа 1.3 сая т буюу 6.3 хувь, зорчигчид давхардсан тоогоор 1.2 сая хүн буюу 30.1 хувь, орлого 28.6 тэрбум төг буюу 6.9 хувиар буурчээ. Төмөр замын тээврээр 2012-2015 онд жилд дунджаар 20.4 сая т ачаа тээвэрлэж, өмнөх 4 жилийн дунджаас 4.4 сая тонноор илүү байна.



## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Хүснэгт 9.4.4 Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж % 2008-2011 оны дундаж
<b>Тээсэн ачаа, мян.т</b>	<b>16 017.6</b>	<b>20 445.2</b>	<b>21 035.5</b>	<b>21 118.6</b>	<b>19 150.8</b>	<b>20 437.5</b>	<b>127.6</b>
дотоодын	8 137.8	9 889.8	10 725.1	10 573.6	9 231.3	10 104.9	124.2
гаргалт	4 031.2	6 575.7	6 069.4	6 191.1	5 637.7	6 118.5	151.8
оруулалт	1 638.9	2 445.5	2 484.1	2 288.7	2 188.2	2 351.6	143.5
дамжин өнгөрөх	2 209.7	1 534.2	1 756.8	2 065.2	2 093.6	1 862.4	84.3
<b>Ачаа эргэлт, сая т.км</b>	<b>9 454.7</b>	<b>12 142.7</b>	<b>12 076.5</b>	<b>12 473.7</b>	<b>11 462.6</b>	<b>12 038.9</b>	<b>127.3</b>
дотоодын	2 631.9	3 291.7	3 647.9	3 532.3	2 860.7	3 333.2	126.6
гаргалт	3 550.2	5 909.6	5 316.0	5 585.8	5 251.8	5 515.8	155.4
оруулалт	819.9	1 238.5	1 162.7	1 063.2	1 026.2	1 122.6	136.9
дамжин өнгөрөх	2 452.7	1 703.0	1 950.0	2 292.3	2 323.9	2 067.3	84.3
<b>Зорчигчид, мян.хүн</b>	<b>3 706.4</b>	<b>4 000.0</b>	<b>3 759.7</b>	<b>3 305.8</b>	<b>2 794.7</b>	<b>3 465.0</b>	<b>93.5</b>
олон улсын	155.5	170.3	170.4	153.9	141.9	159.1	102.3
дотоодын	3 550.9	3 829.7	3 589.3	3 151.9	2 652.8	3 305.9	93.1
<b>Зорчигч эргэлт, сая хүн км</b>	<b>1 257.2</b>	<b>1 485.4</b>	<b>1 394.4</b>	<b>1 194.5</b>	<b>996.7</b>	<b>1 267.8</b>	<b>100.8</b>
<b>Шилжүүлсэн сая т.км</b>	<b>10 711.9</b>	<b>13 628.1</b>	<b>13 471.0</b>	<b>13 668.2</b>	<b>12 459.3</b>	<b>13 306.7</b>	<b>124.2</b>
<b>Тээврийн орлого, сая төг</b>	<b>282 280.3</b>	<b>416 520.2</b>	<b>421 418.0</b>	<b>427 863.0</b>	<b>387 938.1</b>	<b>413 434.8</b>	<b>146.5</b>

**Авто тээвэр:** Авто тээврээр тээсэн ачаа 2015 онд 16.7 сая т, зорчигчид давхардсан тоогоор 256.5 сая хүн, орлого 444.4 тэрбум төг болж, 2012 оныхоос тээсэн ачаа 13.5 сая т буюу 44.8 хувь, зорчигчид 56.7 сая хүн буюу 18.1 хувиар буурч, харин орлого 26.9 тэрбум төг буюу 6.4 хувиар өсчээ. Тээсэн ачаа жилд дунджаар 2012-2015 онд 2008-2011 оныхоос 57.9 хувь, зорчигчид 22.0 хувиар өсчээ.

### Хүснэгт 9.4.5 Авто тээврийн үндсэн үзүүлэлт, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж % 2008-2011 оны дундаж
Тээсэн ачаа, мян.т	14 516.3	30 195.1	21 321.9	23 514.2	16 682.2	22 928.3	157.9
Ачаа эргэлт, сая т.км	2 171.7	3 503.9	2 555.8	4 936.4	3 139.9	3 534.0	162.7
Зорчигчдын тоо, сая.хүн	248.6	313.2	303.4	340.1	256.5	303.3	122.0
Зорчигч эргэлт, сая хүн км	1 638.2	2 263.1	1 897.5	2 793.0	1 940.5	2 223.5	135.7
Шилжүүлсэн сая т.км	2 864.2	4 409.1	3 314.8	6 053.7	3 916.1	4 423.4	154.4
Тээврийн орлого, сая төг	151 557.9	417 552.5	367 030.5	363 751.7	444 413.9	398 187.1	262.7

Автомашинны тоо: Техникийн үзлэг, оношлогоонд хамрагдсан автомашин 2015 онд 482.0 мянгад хүрч, 2012 оныхоос 136.6 мянга буюу 39.5 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс суудлынх 2012 оныхоос 114.6 мянга буюу 50.1 хувь, ачааных 26.3 мянга буюу 31.4 хувиар нэмэгдэж, харин автобус 0.9 мянга буюу 4.1 хувь, тусгай зориулалт 3.5 мянга буюу 30.3 хувиар буурчээ.

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Хүснэгт 9.4.6 Автомашины тоо, төрлөөр, 2012-2015

Төрлөөр	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
<b>Нийт</b>	<b>245 389</b>	<b>345 473</b>	<b>384 864</b>	<b>437 677</b>	<b>482 049</b>	<b>412 516</b>
Суудлын	165 635	228 650	259 309	303 724	343 288	283 743
Ачааны	56 340	83 718	89 473	96 581	110 024	94 949
Автобус	17 707	21 642	20 400	20 650	20 744	20 859
Тусгай зориулалтын	5 706	11 463	15 682	16 722	7 993	12 965

### 9.6 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол Улсад бүртгэлтэй ААНБ-ын тоо 2012-2015 онд 2008-2011 оныхоос 42.3 хувиар өссөн бол аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо 36.0 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 9.6.1 Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
<b>Бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо</b>	<b>40 596.0</b>	<b>51 938</b>	<b>54 929</b>	<b>59 843</b>	<b>64 301</b>	<b>57 752.8</b>	<b>142.3</b>
Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг	603	709	559	1 094	919	820.3	136.0
Аялал жуулчлалын салбарын эзлэх хувь	1.5	1.4	1.0	1.8	1.4	1.4	-

Аялал жуулчлалын үйл ажиллагааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2015 онд 58.7 тэрбумд хүрч, ДНБ-д эзлэх хувь харьцангуй өөрчлөлтгүй дунджаар 0.3 хувь байна.

#### Хүснэгт 9.6.2 Аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувь, 2012-2015

	2012	2013	2014	2015*
ДНБ, үндсэн үнээр, тэрбум төг	14 834.0	16 995.7	20 152.5	21 330.8
Үүнээс: Аялал жуулчлалын салбарын нэмэгдэл өртөг, тэрбум төг	45.0	35.6	53.8	58.7
ДНБ-д эзлэх хувь	0.3	0.2	0.3	0.3

Тайлбар: \* - Урьдчилсан гүйцэтгэл

Гадаадын 467.2 мянган зорчигчид 2015 онд Монгол Улсын хилээр орж ирсэн нь 2012 оныхоос 156.6 мян.хүн буюу 25.1 хувиар буурчээ. Харин 2012-2015 онд жилд дунджаар 528.0 мянган гадаадын зорчигч ирсэн нь 2008-2011 оныхоос 1.5 мян. хүн буюу 0.3 хувиар буурлаа.

#### Хүснэгт 9.6.2.1. Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчид, жуулчид, мян.хүн, 2012-2015

Үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
Гадаад зорчигчид	529.5	623.8	515.2	505.7	467.2	528.0	99.7
Гадаад жуулчид	443.6	475.9	417.8	392.8	386.2	418.2	94.3

Эх үүсвэр: ИХШХЕГ-ын мэдээлэл



## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

Монгол Улсын хилээр орж ирсэн гадаадын зорчигчид 2015 онд 82.1 хувь нь 30 хүртэл хоног, 3.3 хувь нь 31-ээс 90 хүртэл хоног, 14.7 хувь нь 90, түүнээс дээш хоногоор ирсэн байна. Гадаадын зорчигчдын 386.2 мянга буюу 82.7 хувь нь жуулчлалын зорилгоор орж ирсэн бол үлдсэн 17.3 хувь нь ажиллах, суралцах болон байнга оршин суухаар ирсэн байна.

Манай улсад 2015 онд 386.2 мянган гадаадын жуулчин ирсэн нь 2012 оныхоос 89.7 мянган хүн буюу 18.8 хувиар буурчээ. Харин 2012-2015 онд жилд дунджаар 418.2 мянган гадаадын жуулчин ирсэн нь 2008-2011 оныхоос 25.4 мянган жуулчин буюу 5.7 хувиар буурав.

### 9.7 ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ

Монгол Улсад дэлхийн зэрэглэлийн томоохон зочид буудлууд нээгдсэн нь салбарын үйлдвэрлэл, өрсөлдөөн өсөхөд нөлөөллөө. Зочид буудал, нийтийн хоолны үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-ын тоо 2012-2015 онд өмнөх 4 жилийнхээс 30.1 хувиар нэмэгдсэн бол бүртгэлтэй ААНБ-д эзлэх хувь нь 0.3 пунктээр буурсан байна.

#### Хүснэгт 9.7.1 Зочид буудал, нийтийн хоолны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын тоо, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж % 2008-2011 оны дундаж
<b>Бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо</b>	<b>40 596</b>	<b>51 938</b>	<b>54 929</b>	<b>59 843</b>	<b>64 301</b>	<b>57 753</b>	<b>142.3</b>
Зочид буудал, нийтийн хоолны салбарын	1 492	1 876	1 802	2 140	1 945	1 941	130.1
Зочид буудал, нийтийн хоолны салбарын эзлэх хувь	3.7	3.6	3.3	3.6	3.0	3.4	-

Зочид буудал, нийтийн хоолны салбарын нэмэгдэл өртөг 2012-2015 оны дунджаар 198.7 тэрбум төгрөгт хүрсэн нь 2008-2011 оны дунджаас 3.6 дахин их буюу 143.3 тэрбум төгрөгөөр илүү байна. Тус салбарт бий болсон нэмэгдэл өртөг жилээс жилд нэмэгдэж байгаа хэдий ч, нийт эдийн засагт эзлэх хувийн жинд төдийлөн өөрчлөлт орохгүй байна.

#### Хүснэгт 9.7.2 Зочид буудал, нийтийн хоолны салбарын ДНБ-д эзлэх хувь, 2012-2015

	2008- 2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012- 2015* оны дундаж	2012- 2015 оны дундаж % 2008- 2011 оны дундаж
<b>ДНБ, үндсэн үнээр, тэрбум.төг</b>	<b>8 097.6</b>	<b>14 834.0</b>	<b>16 995.7</b>	<b>20 152.5</b>	<b>21 330.8</b>	<b>18 328.2</b>	<b>2.3**</b>
Зочид буудал, нийтийн хоолны салбарын нэмэгдэл өртөг	55.4	186.2	205.5	196.6	206.3	198.7	3.6**
Зочид буудал, нийтийн хоолны салбарын эзлэх хувь	0.7	1.3	1.2	1.0	1.0	1.1	-

Тайлбар: \*- Урьдчилсан гүйцэтгэл

\*\* - дахин өссөн

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### 9.8 ХУДАЛДААНЫ САЛБАР

Худалдааны салбар нь өөрсдөө үйлдвэрлэл явуулахгүй боловч үйлдвэрлэгчээс бараа, материал худалдан авч, ямар нэг нэмэлт боловсруулалт хийлгүйгээр дахин худалддаг онцлогтой салбар юм. Худалдааны байгууллагууд ихэнхдээ бөөний болон жижиглэн худалдаа дагнах эсвэл холимог хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.

Худалдааны салбарт 2015 онд 24194 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа нь 2011 оныхоос 34.3 хувиар нэмэгдсэн байна.

#### Хүснэгт 9.8.1 Худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын тоо, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
<b>Бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо</b>	<b>40 596</b>	<b>51 938</b>	<b>54 929</b>	<b>59 843</b>	<b>64 301</b>	<b>57 753</b>	<b>42.3</b>
Худалдааны салбарын	16 404	20 430	21 640	22 793	24 194	22 264	35.7
Худалдааны салбарын эзлэх хувь	40.4	39.3	39.4	38.1	37.6	38.6	

Худалдааны салбарын нийт борлуулалт 2012-2015 оны дунджаар 16.1 их наяд төг болж, 2008-2011 оныхоос 3.4 дахин өслөө.

#### Хүснэгт 9.8.2 Худалдааны салбарын ДНБ-д эзлэх хувь, тэрбум төг, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
<b>ДНБ, үндсэн үнээр</b>	<b>8 097.6</b>	<b>14 834.0</b>	<b>16 995.7</b>	<b>20 152.5</b>	<b>21 330.8</b>	<b>18 328.2</b>	<b>2.3**</b>
Худалдааны салбарын нэмэгдэл өртөг	1 019.3	2 231.1	2 267.2	2 545.6	2 751.7	2 448.9	2.4**
Худалдааны салбарын эзлэх хувь	12.6	15.0	13.3	12.6	12.9	13.4	

\*- Урьдчилсан гүйцэтгэл

\*\*-Дахин

Худалдааны салбарын нэмэгдэл өртөг 2012-2015 онд дунджаар 2448.9 тэрбум төгрөгт хүрсэн нь 2008-2011 оны дунджаас 2.4 дахин их буюу 1429.6 тэрбум төгрөгөөр илүү байна. Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь сүүлийн дөрвөн жилийн дунджаар 13.4 хувь байна.

#### Хүснэгт 9.8.3 Худалдааны салбарын нийт борлуулалт, үйлдвэрлэл, оны үнээр, тэрбум төг, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
Нийт борлуулалт	4693.5	13 350.0	14 456.4	17 961.6	18 754.9	16 130.7	3.4**
Нийт үйлдвэрлэлт	1238.3	2 732.2	3 201.4	3 929.5	4 194.0	3 514.3	2.8**
Үүнээс: Бөөний худалдаа	722.8	1 397.1	1 685.0	1 883.4	1 888.1	1 713.4	2.4**

\*- Урьдчилсан гүйцэтгэл


\*\*-Дахин

9.9 ХАРИЛЦАА ХОЛБОО

Харилцаа холбооны салбарын орлого 2015 онд 724.6 тэрбум төг болж, 2012 оныхоос 155.5 тэрбум төг буюу 27.3 хувиар өсчээ.


Хүн амаас орсон орлого 2015 онд 538.1 тэрбум төг болж, 2012 оныхоос 102.0 тэрбум төг буюу 23.4 хувиар өсчээ. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд хөдөө орон нутагт үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэн, шинэ техник технологи, үйлчилгээ нэвтэрч, үүрэн утасны үйлчилгээ үзүүлэгч компаниудын үзүүлж буй үйлчилгээний төрөл нэмэгдэж, үнийн таатай нөхцөл бий болсноор хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, энэ салбарын нийт орлого нэмэгдэж байна.

Зураг 9.9.1 Харилцаа холбооны салбарын орлого, тэрбум төг, 2012-2015



Үүрэн утас хэрэглэгчид, давхардсан тоогоор 2015 оны эцэст 5564.1 мянга, үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид 3068.2 мянга, суурин утасны цэг 258.9 мянга, интернэтийн байнгын хэрэглэгчид 2430.0 мянга байна. Үүрэн утас хэрэглэгчид давхардсан тоогоор 2012 оныхоос 62.4 хувь, үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид 9.1 хувь, суурин утасны цэг 73.3 хувь, интернэтийн байнгын хэрэглэгчид 3.5 дахин өсчээ.

Зураг 9.9.2 Суурин утасны цэг болон үүрэн утас хэрэглэгчид, 2012-2015




Үүрэн холбооны 3G сүлжээн нийт хүн амын 96 хувийг хамарч, 348 сум, суурин газарт нэвтэрч, хэрэглэгчид 2015 оны эцэст 2.2 саяд хүрч, 2012 оныхоос 4.4 дахин өсчээ. Үүрэн холбооны 3G сүлжээг Улаанбаатар хот, орон нутгийн хэрэглэгчид өргөн ашиглаж, үүнтэй уялдан үүрэн холбооны дата хэрэглээ жил бүр өсөх хандлагатай байна.

Манай улсын 100 хүнд ногдох үүрэн утас хэрэглэгчид дэлхийн дунджаас дээгүүр байна. Тухайлбал, Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргасан “Мэдээлэл харилцаа холбооны 2015 оны статистик үзүүлэлт”-д дэлхийн дунджаар 100 хүнд ногдох үүрэн утас хэрэглэгчид 97 байгаа бол манай улсад 102 байна.

## IX. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

### Зураг 9.9.3 3G хэрэглэгчийн тоо, 2012-2015



Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын мэдээллээр 2015 оны эцэст интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 66 үйлчилгээ эрхлэгч үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн 34 нь хөдөө орон нутагт интернэтийн үйлчилгээ хүргэж байна. Интернэт хэрэглэгчид 2015 оны эцэст байдлаар 2.4 саяд хүрч, 2012 оныхоос 3.5 дахин өсчээ.

### Зураг 9.9.4 100 хүнд ногдох үүрэн утас хэрэглэгч, 2012-2015



Интернэт хэрэглэгчдийн 83.4 хувь нь Улаанбаатарт, 14.2 хувь аймагт, 2.4 хувь нь сумдад байна. Нийт интернэт хэрэглэгчдийн 91.4 хувь нь 3G технологиор, 6.5 хувь нь шилэн кабелиар, 1.0 хувь нь xDSL, 1.1 хувь нь Wi-Fi, WIMAX технологиор интернэт ашиглаж байна.

### Хүснэгт 9.9.1 Холбооны салбарын үзүүлэлт, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж	2012-2015 оны дундаж / 2008-2011 оны дундаж %
Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага*	62	67	55	59	66	62	99.6
Интернэтийн байнгын хэрэглэгчид, мян.хүн*	201.4	695.6	762.2	1 862.7	2 430.0	1 437.6	713.8
Компьютерийн тоо, мян.ш	283.9	478.2	505.6	525.4	581.0	522.6	184.1
1000 хүнд ногдох компьютер	104	175	181	182	196	184	176.6
Телевиз, радиогийн олон сувгийг хүлээн авч буй бүртгэлтэй хэрэглэгчид, мян.хүн*	186.2	482.6	523.8	669.9	725.8	600.5	322.5
Кабелийн телевиз хэрэглэгчид, мян.хүн	128.7	227.0	278.0	360.9	384.4	312.6	242.9
Шугамын радио цэг, мян.ш*	53.3	50.6	49.0	48.9	62.4	52.7	98.9

Эх үүсвэр: \*Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын мэдээллэл

Телевиз, радиогийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 63 ААНБ 2015 онд үйл ажиллагаа явуулсан байна.

Телевиз, радиогийн олон сувгийг хүлээн авч байгаа хэрэглэгчид 2015 оны эцэст 725.8 мянга болж, 2012 оныхоос 50.4 хувиар өсчээ.




## Х. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

### 10. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хөрөнгө оруулалт 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт 4754.6 тэрбум төг болж, 2014 оныхоос 1287.9 тэрбум төг буюу 21.3 хувиар буурлаа.

**Зураг 10.1. Хөрөнгө оруулалт, тэрбум төг, 2012-2015**



Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 2008-2011 онд 16164.9 тэрбум төг байсан бол 2012-2015 онд 26770.8 тэрбум төг болж, өмнөх 4 жилийнхээс 10605.9 тэрбум төг буюу 65.6 хувиар өслөө. Дотоод эх үүсвэрийн хөрөнгө оруулалтын хэмжээ 2012-2015 онд 2008-2011 оныхоос 2.4 дахин, харин гадаад эх үүсвэрийнх 24.0 хувиар нэмэгдсэн байна.


**Зураг 10.2. Нийт хөрөнгө оруулалт, эх үүсвэрээр, тэрбум төг, 2012-2015**



## Х. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Нийт хөрөнгө оруулалтыг технологийн бүтцээр авч үзвэл, барилга угсралтын ажил 2012-2015 онд 2008-2011 оныхтой харьцуулахад 3.5 дахин, машин, тоног төхөөрөмж 61.4 хувь, бусад хөрөнгө оруулалт 1.7 хувиар өссөн байна.

**Зураг 10.3. Нийт хөрөнгө оруулалт, технологийн бүтцээр, тэрбум төг, 2012-2015**



**Нийт хөрөнгө оруулалтын хувийн жинг авч үзвэл:**

**Хүснэгт 10.1. Хөрөнгө оруулалтын бүтэц, эх үүсвэрээр, хувиар, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015 оны дундаж
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Дотоодын хөрөнгө оруулалт	39.5	31.2	44.5	73.8	71.3	55.2
Гадаадын хөрөнгө оруулалт	60.5	68.8	55.5	26.2	28.7	44.8

Нийт хөрөнгө оруулалтад гадаадын хөрөнгө оруулалтын эзлэх хувь 2008-2011 онд 60.5 хувь байсан бол 2012-2015 онд 44.8 болж, 15.7 пунктээр буурч, харин дотоодын хөрөнгө оруулалтын эзлэх хувь нэмэгдсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалтын хувийн жин буурсан нь 2013 оноос гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ эрс буурч байгаатай холбоотой.

**Хүснэгт 10.2. Хөрөнгө оруулалтын бүтэц, технологийн бүтцээр, хувиар, 2012-2015**

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015 оны дундаж
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Барилга угсралт	18.3	11.0	28.1	42.7	49.6	32.9
Машин, тоног төхөөрөмж	48.5	43.7	57.6	45.8	46.2	48.3
Бусад	33.2	45.3	14.3	11.5	4.2	18.8

Нийт хөрөнгө оруулалтад барилга, угсралтын ажлын эзлэх хувь 2008-2011 онд 18.3 хувь байсан бол 2012-2015 онд 32.9 болж, 14.6 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь сүүлийн 3 жилд орон сууцны барилга, угсралтын ажил нэмэгдсэнээс шалтгаалсан байна.



## ХИ. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ХУДАЛДАА

### 11. 1. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

#### Урсгал данс

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2008-2011 онд дунджаар 1121.7 сая ам.долл, 2012-2015 онд дунджаар 2131.6 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ буурсан нь төлбөрийн тэнцлийн урсгал данс алдагдалтай гарахад нөлөөллөө. Барааны гадаад худалдааны алдагдал 2012-2015 онд өмнөх 4 жилийн дунджаас 66.3 хувиар буурсан бол, үйлчилгээний тэнцлийн алдагдал 2.8 дахин өссөн байна. Урсгал тэнцлийн үзүүлэлтүүдийг хүснэгт 11.1-д харуулав.

#### Хүснэгт 11.1.1 Урсгал тэнцлийн үзүүлэлтүүд, сая ам.доллараар, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015 оны дундаж
Урсгал Тэнцэл	-1 121.7	-3 362.3	-3 192.0	-1 405.0	-567.1	-2 131.6
Бараа ба үйлчилгээний худалдаа	-907.1	-2 653.6	-2 634.7	-559.3	337.5	-1 377.6
Бараа	-480.4	-1 553.3	-1 320.5	993.9	1 231.8	-162.0
Ерөнхий эд бараа	-770.2	-1 650.9	-1 586.3	660.4	834.0	-435.7
Экспорт FOB	2 719.2	4 259.2	3 957.9	5 368.5	4 248.9	4 458.6
Зэсийн баяжмал	767.9	838.6	949.0	2 574.7	2 280.1	1 660.6
Импорт FOB	3 489.4	5 910.0	5 544.2	4 708.1	3 414.9	4 894.3
Мөнгөжөөгүй алт	310.3	122.3	309.8	405.2	420.6	314.5
Бусад	-20.4	-24.8	-44.0	-71.8	-22.8	-40.8
Үйлчилгээ	-426.7	-1 100.3	-1 314.2	-1 553.2	-894.3	-1 215.5
Цэвэр орлого	-423.1	-948.1	-699.1	-988.6	-1 078.0	- 928.4
Урсгал шилжүүлэг	208.4	239.4	141.8	143.0	173.4	174.4
Засгийн газрын шилжүүлэг (цэвэр)	35.8	36.5	29.3	28.3	22.0	29.1
Ажилчдын гуйвуулга	94.7	41.0	22.0	30.8	80.1	43.4
Хүлээн авсан	226.6	286.2	209.9	201.4	211.5	227.3
Шилжүүлсэн (-)	131.9	245.3	187.9	170.6	131.5	183.8
Бусад шилжүүлэг (цэвэр)	77.9	161.9	90.4	83.9	71.3	101.9

Эх үүсвэр: Монголбанкны мэдээлэл

\*Урьдчилсан гүйцэтгэл

Цэвэр орлогын дансны алдагдал 2008-2011 онд дунджаар 423.1 сая ам.доллар байсан бол 2012-2015 онд 928.4 сая ам.доллар болж, 2.2 дахин нэмэгдсэн байна.

#### Хөрөнгө ба санхүүгийн данс

Хөрөнгө ба санхүүгийн данс 2008-2011 онд дунджаар 1511.2 сая ам.долларын ашигтай гарч байсан ба 2012-2015 онд 1961.0 сая ам.долларын ашигтай гарчээ. Сүүлийн жилүүдэд манай улсад орж ирэх гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ эрчимтэй нэмэгдсэн хэдий ч 2014 болон 2015 онд шинээр хийгдэх хөрөнгө оруулалт багассан байна.

## XI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ХУДАЛДАА

### Хүснэгт 11.1.2 Хөрөнгө ба санхүүгийн данс, сая ам.долл, 2012-2015

Төлбөрийн тэнцлийн үзүүлэлт	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015 оны дундаж
Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл	1 511.2	4 929.5	1 438.1	1 062.0	414.3	1 961.0
Хөрөнгийн данс	128.0	120.4	125.8	100.0	111.9	114.5
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	1 692.7	4 407.8	2 098.1	276.0	182.7	1 741.1
Санхүүгийн хөрөнгө оруулалт	193.8	2 325.4	- 156.1	276.8	281.7	682.0
Бусад хөрөнгө оруулалт	- 503.3	- 1 924.1	- 629.7	408.1	- 163.3	- 577.3

Эх үүсвэр: Монголбанкны мэдээлэл

\*Урьдчилсан гүйцэтгэл

Санхүүгийн хөрөнгө оруулалт буюу багцын хөрөнгө оруулалт 2013 онд алдагдалтай, бусад онуудад ашигтай гарсан байна. Бусад хөрөнгө оруулалтын тэнцлийн алдагдал 2012-2015 онд өмнөх 4 жилийнхээс 74.0 сая ам.долл буюу 14.7 хувиар нэмэгдсэн байна.

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2008-2011 онд жилд дунджаар 1121.7 сая ам.долларын алдагдалтай байсан бол 2012-2015 онд жил дараалан алдагдалтай гарч мөн бараа, үйлчилгээний худалдааны алдагдал 2012-2015 онд жилд дунджаар 1377.6 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

Төлбөрийн тэнцлийн хөрөнгө ба санхүүгийн тэнцэл сүүлийн 4 жилд ашигтай гарсан байна. Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 2008-2011 онд жилд дунджаар 1511.2 сая ам.долл, 2012-2015 онд дунджаар 1961.0 сая ам.долларын ашигтай байна. Энэхүү өсөлтөд санхүүгийн хөрөнгө оруулалтын өсөлт голлон нөлөөлжээ.

### 11.2 ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт эргэлт 2008-2011 онд дунджаар 29.9 хувиар өсч байсан бол 2012-2015 онд дунджаар 7.2 хувиар буурчээ. Үүнээс экспорт 2012-2015 онд жилд дунджаар 0.8 хувиар өсч, импорт 12.9 хувиар буурчээ.

#### Хүснэгт 11.2.1 Гадаад худалдааны нийт эргэлт, экспорт, импорт, тэнцэл, сая ам.долл, 2012-2015

Үзүүлэлт	2008-2011 оны жилийн дундаж өсөлт	2012	2013	2014	2015	2012-2015 оны жилийн дундаж өсөлт
Нийт эргэлт	6 831.7	11 123.0	10 626.9	11 011.0	8 466.8	10 306.9
Экспорт	3 036.5	4 384.7	4 269.1	5 774.3	4 669.3	4 774.3
Импорт	3 795.2	6 738.4	6 357.8	5 236.7	3 797.5	5 532.6
Тэнцэл (+; -)	-758.7	-2 353.7	-2 088.8	537.7	871.8	-

Эх үүсвэр : Гааль, татварын ерөнхий газрын мэдээлэл

Гадаад худалдааны нийт эргэлтэд экспортын эзлэх хувь 2012-2015 онд өмнөх 4 жилийнхээс 1.7 пунктээр өсч, харин импортынх 1.7 пунктээр буурсан байна.

Гадаад худалдааны тэнцэл 2015 онд 0.9 тэрбум ам.долларын ашигтай гарахад эрдэс бүтээгдэхүүн, машин тоног, төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импортын өсөлт голлон нөлөөлөв.

#### Экспорт

Манай Улсын экспортод эрдэс бүтээгдэхүүний экспорт зонхилсоор байгаа бөгөөд 2012-2015 онд экспортод дунджаар 52.1 хувийг эзэлж байсан бол 2012-2015 онд дунджаар 74.2 хувийг эзэлж байна.

## XI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ХУДАЛДАА

### Хүснэгт 11.2.2 Экспорт болон гадаад худалдааны тэнцлийн ДНБ-д эзлэх хувь, 2012-2015

	2012	2013	2014	2015
ДНБ-д экспортын эзлэх хувь	35.7	34.0	47.2	39.7
Гадаад худалдааны тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-19.2	-16.6	4.4	7.4

*Эх үүсвэр: Гааль, татварын ерөнхий газрын мэдээлэл*

Экспортын ДНБ-д эзлэх хувь 2012-2015 онд 35.7-39.7 хувь болж, үүнд импортын бууралт нөлөөлсөн байна.

### Хүснэгт 11.2.3 Экспорт, улсаар, сая ам.долл, 2012-2015

Улс	2012	2013	2014	2015	Бүтэц	
					2012	2015
<b>Бүгд</b>	<b>4 384.7</b>	<b>4 269.1</b>	<b>5 774.3</b>	<b>4 669.5</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Австрали	0.5	8.3	1.2	2.9	0.0	0.1
АНУ	3.6	3.9	15.4	18.7	0.1	0.4
Арабын Нэгдсэн Эмират	5.4	8.8	20.5	14.7	0.1	0.3
Бельги	1.4	0.2	0.4	0.3	0.0	0.0
БНСУ	12.3	13.0	13.5	66.6	0.3	1.4
БНХАУ	4 059.7	3 706.3	5 073.4	3 910.3	92.6	83.7
Дани	0.1	0.1	24.0	0.1	0.0	0.0
Итали	31.6	51.5	51.4	43.4	0.7	0.9
Их Британи	11.9	200.7	398.7	337.7	0.3	7.2
Казахстан	3.5	0.6	4.9	2.1	0.1	0.0
Канад	117.3	135.5	1.2	1.6	2.7	0.0
Филиппин	0.0	2.5	0.8	0.9	0.0	0.0
Мексик	0.8	1.7	0.0	0.0	0.0	0.0
Нидерланд	1.2	0.7	1.8	0.5	0.0	0.0
ОХУ	79.6	61.8	61.6	76.9	1.8	1.6
Польш	0.1	0.1	0.1	0.1	0.0	0.0
Сингапур	4.3	8.2	14.2	26.6	0.1	0.6
Турк	-	0.4	0.2	0.4	-	0.0
Узбекистан	0.6	0.5	0.4	0.0	0.0	0.0
Украин	1.2	5.2	0.1	0.0	0.0	0.0
Франц	3.6	8.5	9.3	7.3	0.1	0.2
ХБНГУ	16.0	18.4	15.0	10.8	0.4	0.2
Чехийн БНУ	0.2	0.1	0.1	0.2	0.0	0.0
Швед	0.3	3.9	0.4	0.8	0.0	0.0
Швейцарь	8.9	3.1	28.1	109.2	0.2	2.3
Энэтхэг	6.0	0.8	3.0	3.8	0.1	0.1
Япон	5.6	10.5	24.5	20.3	0.1	0.4
Бусад	9.0	13.6	10.5	13.3	0.2	0.3

*Эх үүсвэр: Гааль, татварын ерөнхий газрын мэдээлэл*

Манай улсын нийт экспортын дийлэнх хувь нь Хядад улсад ногдож байна. Энэ нь манай орны экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрс, зэс, төмрийн хүдэр, цайрын хүдэр, баяжмал зэргийг БНХАУ-д экспортолж байгаатай холбоотой.

Нийт экспортод 2015 онд 48.8 хувийг зэсийн баяжмал, 11.9 хувийг нүүрс, 9.0 хувийг боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, 8.3 хувийг боловсруулаагүй газрын тос, 4.9 хувийг төмрийн хүдэр, 2.2 хувийг цайрын хүдэр, баяжмалын экспорт эзэлж байна. Эдгээр бараа нийт экспортын 85.1 хувийг эзэлж байна.

## XI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ХУДАЛДАА

### Хүснэгт 11.2.4 Экспортын бүтэц, барааны бүлгээр, хувиар, 2012-2015

	2012	2013	2014	2015
Эрдэс бүтээгдэхүүн	89.2	81.9	83.0	78.8
Түүхий болон боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн бүтээгдэхүүн	0.7	0.8	0.6	0.7
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	5.3	6.6	5.9	6.5
Үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйл	2.8	7.3	7.0	9.0
Бусад	2.0	3.4	3.5	5.0
<b>Нийт дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Эх үүсвэр: Гааль, татварын ерөнхий газрын мэдээлэл

Нийт экспортод эрдэс бүтээгдэхүүний эзлэх хувь 2008-2011 онд дунджаар 74.2 байсан бол 2012-2015 онд дунджаар 83.2 болж, 9.0 пунктээр өсч, харин үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлийн эзлэх хувь 2008-2011 онд дунджаар 12.1 байсан бол 2012-2015 онд дунджаар 6.5 болж, өмнөх 4 жилийнхээс 5.6 пункт, түүхий болон боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх 2008-2011 онд дунджаар 1.3 бол 2012-2015 онд дунджаар 0.7 болж, өмнөх 4 жилийнхээс 0.6 пункт нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүний эзлэх хувь 2008-2011 онд дунджаар 7.9 байсан бол 2012-2015 онд дунджаар 6.1 болж, өмнөх 4 жилийнхээс 1.8 пунктээр буурчээ.

### Хүснэгт 11.2.5 Экспортын гол нэр төрлийн барааны биет хэмжээ, 2012-2015

Нэр төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Зэсийн баяжмал (мян.т)	578.6	574.3	649.8	1 379.0	1 477.8	1 020.2
Нүүрс (мян.т)	12 326.2	20 915.5	18 373.1	19 499.0	14 472.7	18 315.1
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт (т)	10.2	2.8	7.6	10.0	11.3	7.9
Цайрын хүдэр, баяжмал (мян.т)	132.3	140.9	130.9	99.4	84.1	113.8

Эх үүсвэр : Гааль, татварын ерөнхий газрын мэдээлэл

Манай Улсын экспортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэмжээ сүүлийн 4 жилд өссөн байна. Нүүрсний биет хэмжээ 2012-2015 онд өмнөх 4 жилийнхээс 1.5 дахин, төмрийн хүдэр, баяжмалынх 2.0 дахин, боловсруулаагүй газрын тосных 3.1 дахин өссөн байна.

### Хүснэгт 11.2.6 Экспортын гол нэрийн зарим бүтээгдэхүүний үнэ, ам.долл, 2012-2015

Нэр төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Нүүрс (т)	61.7	90.9	61.1	43.5	38.4	58.5
Төмрийн хүдэр (т)	73.5	83.0	97.3	70.6	44.9	73.9
Зэсийн баяжмал (т)	1 331.4	1 460.1	1 460.3	1 867.1	1 543.0	1 582.6
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт (кг)	33 310.8	43 727.9	40 990.5	40 359.9	37 076.6	40 538.7

Эх үүсвэр : Гааль, татварын ерөнхий газрын мэдээлэл

Экспортод өндөр хувийн жин эзэлж буй дээрх бүтээгдэхүүний нэгжийн үнэ 2008-2012 оны дунджаас хэлбэлзэлтэй байв. Үүнд 1 т нүүрсний үнэ 5.2 хувиар буурч, 1 кг боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны үнэ 21.7 хувь, 1 т зэсийн баяжмалын үнэ 18.9 хувь, 1 т төмрийн хүдрийн үнэ 0.6 хувиар өссөн байна. Монгол Улсын экспорт эрдэс бүтээгдэхүүнд голлож байгаагаас шалтгаалж, тэдгээр бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс эдийн засаг ихээхэн хамаарч байна.


## ХИ. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ХУДАЛДАА

Экспортын нийт дүнд 2012-2015 онд нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй газрын тос голлох байр эзлэх болж, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны экспорт жилээс жилд нэмэгдсэн байна. Харин боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны хилийн нэгжийн үнэ жил бүр өссөн байна.

### Импорт

Импорт 2015 онд нийт 3797.5 сая ам.долларт хүрч, 2008-2011 оны дунджийн түвшинд байна.

Зураг 12.2.1 Импорт, сая ам.долл, 2008-2015



Импортын хэмжээг улс орнуудаар авч, үзвэл 2015 онд нийт импортын 36.6 хувь нь БНХАУ-д, 26.9 хувь нь ОХУ-д, 7.2 хувь нь Япон улсад, 7.2 хувь нь БНСУ-д, 6.8 хувь нь ХБНГУ-д, 3.3 хувь, АНУ-д 3.1 хувь ногдож байгаа бөгөөд эдгээр улстай хийсэн импортын худалдаа нь импортын үнийн дүнгийн 83.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 12.2.7 Импорт, улсаар, сая ам.долл, 2012-2015

Улс	2012	2013	2014	2015	Бүтэц, хувиар	
					2012	2015
Бүгд	6 738.4	6 357.8	5 236.7	3 797.2	100.0	100.0
Австрали	80.3	50.4	14.8	11.8	1.2	0.3
Австри	13.3	6.9	9.4	23.9	0.2	0.6
АНУ	535.9	512.7	229.5	116.5	8.0	3.1
Беларусь	129.4	155.0	21.1	17.9	1.9	0.5
Бельги	19.1	18.4	8.8	6.6	0.3	0.2
БНСУ	467.8	507.4	352.6	258.7	6.9	6.8
БНХАУ	1 873.5	1 822.6	1 767.9	1 389.5	27.8	36.6
Болгар	6.3	7.7	3.3	1.9	0.1	0.1
Вьетнам	16.3	22.3	24.5	29.1	0.2	0.8
Дани	5.5	19.0	9.0	4.9	0.1	0.1
Израиль	3.9	2.2	0.8	0.7	0.1	0.0
Индонез	19.8	17.5	15.5	11.8	0.3	0.3
Испани	23.6	25.5	23.7	8.2	0.4	0.2
Итали	53.3	54.3	45.3	33.3	0.8	0.9
Их Британи	53.5	46.5	26.4	23.7	0.8	0.6
Казахстан	20.5	34.2	29.4	29.2	0.3	0.8
Канад	97.2	80.4	21.5	19.6	1.4	0.5
Киргизстан	1.6	1.6	1.3	0.3	0.0	0.0
Малайз	67.8	88.0	63.0	38.8	1.0	1.0
Нидерланд	28.4	22.3	16.0	14.5	0.4	0.4
ОХУ	1 847.4	1 561.9	1 549.3	1 021.0	27.4	26.9
Польш	57.1	63.8	51.6	39.8	0.8	1.0
Сингапур	69.2	66.6	52.8	22.1	1.0	0.6
Тайланд	41.0	45.0	44.9	33.5	0.6	0.9

## XI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ХУДАЛДАА

### Хүснэгт 12.2.7-ийн үргэлжлэл

Улс	2012	2013	2014	2015	Бүтэц, хувиар	
					2012	2015
Турк	34.1	41.9	37.9	28.4	0.5	0.7
Украин	69.9	56.2	70.1	36.9	1.0	1.0
Унгар	9.6	10.1	11.8	9.5	0.1	0.2
Финлянд	23.3	25.0	6.6	6.6	0.3	0.2
Франц	63.6	62.5	53.6	27.5	0.9	0.7
ХБНГУ	246.4	252.2	159.2	124.5	3.7	3.3
Чехийн БНУ	20.7	16.1	10.3	7.5	0.3	0.2
Швед	41.0	39.8	11.6	12.8	0.6	0.3
Швейцарь	14.2	11.6	9.1	8.4	0.2	0.2
Шинэ Зеланд	19.8	19.8	20.4	8.9	0.3	0.2
Энэтхэг	54.3	34.3	12.7	16.8	0.8	0.4
Япон	501.6	444.2	367.8	274.6	7.4	7.2
Бусад	108.1	112.1	83.4	77.5	1.6	2.0

Эх үүсвэр: Гааль, татварын ерөнхий газрын мэдээлэл

Импортын дүнд эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт зонхилох хандлага хэвээр байна. 2012-2015 онд импортод эрдэс бүтээгдэхүүн дунджаар 25.9 хувь, машин тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги дунджаар 21.5 хувь, авто агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги дунджаар 14.0 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн дунджаар 9.4 хувь, хүнсний бэлэн бүтээгдэхүүн дунджаар 7.1 хувь эзэлж байна.

Нийт импортод эрдэс бүтээгдэхүүний эзлэх хувь 2012-2015 онд 2008-2011 оныхоос 1.1 пунктээр өсч, авто, агаар, усан зам тээврийн хэрэгслийнх 3.2 пункт, машин тоног, төхөөрөмж, тэдгээрийн эд ангийнх 0.2 пунктээр буурсан байна.

### Хүснэгт 12.2.8 Импортын бүтэц, барааны бүлгээр, хувиар, 2012-2015

	2012	2013	2014	2015
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	5.9	6.5	7.3	8.7
Эрдэс бүтээгдэхүүн	23.5	27.4	28.0	24.7
Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	8.7	8.7	10.3	9.8
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, эд анги дуу хураагч, телевизор, эдгээрийн сэлбэг	24.5	22.0	18.8	20.7
Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	18.9	15.7	11.8	9.7
Бусад	18.5	19.8	23.9	26.5
<b>Нийт дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Эх үүсвэр: Гааль, татварын ерөнхий газрын мэдээлэл

Уул, уурхайн машин, тоног, төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импортын тоо хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж тэдгээрийн эд анги, түлш шатахууны импорт өссөн байна. Үүнд суудлын автомашины тоо хэмжээ 2012-2015 онд 2008-2011 оныхоос 26.3 хувь, ачааны автомашиных 1.5 хувь, дизель түлш 42.1 хувиар өссөн байна.



## XI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ХУДАЛДАА

### Хүснэгт 12.2.9 Импортын гол нэрийн зарим барааны биет хэмжээ, 2012-2015

Нэр төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Автобензин (мян.т)	1 299.1	389.1	380.1	416.0	433.5	1 618.7
Дизель түлш (мян.т)	1 991.2	715.5	773.5	685.9	655.0	2 829.8
Суудлын автомашин (ш)	134 142	46 409	44 680	41 246	37 088	169 423
Ачааны автомашин (ш)	59 706	22 438	17 995	12 505	7 674	60 612
Бульдозер, авто хусуур, индүүдэгч, экскаватор (ш)	4 560	2 090	1 358	713	432	4 593

Импортын тоо хэмжээ өсөлтөөс гадна импортын нэгжийн үнийн өсөлт импортын өсөлтөд илүүтэйгээр нөлөөлсөн байна.

### Хүснэгт 12.2.10 Импортын гол нэрийн зарим барааны нэгжийн үнэ, ам.долл, 2012-2015

Нэр төрөл	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015	2012-2015 оны дундаж
Суудлын автомашин (ш)	6 300.0	9 266.7	8 349.0	7 011.8	5 662.2	7 572.4
Ачааны автомашин (ш)	15 000.0	18 192.5	17 057.8	8 623.3	6 504.7	12 594.6
Автобензин (л)	889.5	1 218.4	1 156.7	1 022.6	632.0	1 007.4
Дизель түлш (л)	915.0	1 144.4	1 139.2	956.6	575.1	953.8





## XII. ТӨРИЙН САНХҮҮ

## 12. ТӨРИЙН САНХҮҮ

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээлд эрдэс бүтээгдэхүүний эрэлт, үнэ буурснаас манай улсын эдийн засгийн өсөлт саарч, төсвийн орлого бүрдэлтэд нөлөөлж байна.

Улсын нэгдсэн төсөвт 2008-2011 онд жилд дунджаар 2921.9 тэрбум төгрөгийн орлого оруулж байсан бол 2012-2015 онд 5809.3 тэрбум төгрөг болж, 2.0 дахин нэмэгдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг нэр төрлийн ангиллаар авч үзье.

## Хүснэгт 12.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, оны үнээр, тэрбум төг, 2012-2015

	2008- 2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012- 2015 оны дундаж	2012-2015* оны дундаж % 2008-2011 оны дундаж
<b>Нийт орлого, тусламжийн хэмжээ</b>	<b>2921.9</b>	<b>4 957.8</b>	<b>5 986.9</b>	<b>6 316.5</b>	<b>5 976.1</b>	<b>5 809.3</b>	<b>198.8</b>
Тогтворжуулалтын сан	241.0	94.7	46.9	39.9	2.3	45.9	19.1
Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ	2861.6	4 863.1	5 940.1	6 276.6	5 973.8	5 763.4	201.4
Татварын орлого	2459.1	4 179.3	5 072.8	5 157.0	5 142.7	4 888.0	198.8
Орлогын албан татвар	770.5	871.4	1 109.2	1 101.0	1 178.6	1 065.0	138.2
Нийгмийн даатгалын орлого	318.7	650.2	874.2	917.6	1 038.8	870.2	273.1
Хөрөнгийн албан татвар	12.8	45.1	69.8	78.4	86.5	69.9	546.3
Нэмэгдсэн өртгийн албан татвар	595.4	1 296.5	1 435.1	1 371.7	1 037.1	1 285.1	215.8
Онцгой албан татвар	226.9	312.4	449.4	454.4	592.3	452.1	199.3
Тусгай зориулалтын орлого	18.7	10.8	10.9	11.6	11.8	11.3	60.3
Гадаад үйл ажиллагааны орлого	196.9	327.4	381.4	355.3	320.6	346.2	175.8
Бусад татвар, төлбөр, хураамж	319.2	665.6	742.8	867.0	877.0	788.1	246.9
Татварын бус орлого	402.5	683.8	867.3	1 119.6	831.1	875.4	217.5
Нийтлэг татварын бус орлого	376.7	642.7	860.6	1 094.5	737.2	833.7	221.3
Хөрөнгийн орлого	7.0	16.4	6.7	25.1	54.7	25.7	367.5
Тусламжийн орлого	18.8	24.7	-	-	39.2	16.0	85.0

\* Урьдчилсан гүйцэтгэл

Татварын бус орлого 2012-2015 онд 2008-2011 оныхоос 2.2 дахин, татварын орлого 2.0 дахин өссөн байна.

Татварын орлогын төсвийн нийт орлогод эзлэх хувь 2012-2015 онд 2008-2011 оныхоос 0.1 пунктээр буурч, татварын бус орлогынх 1.3 пунктээр өссөн байна.

### XIII. СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТРИЙН САН

#### Хүснэгт 12.2 Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн бүтэц, хувиар, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015 оны дундаж
<b>Нийт орлого, тусламжийн хэмжээ</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Тогтворжуулалтын сан	8.2	1.9	0.8	0.6	0.0	0.8
Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ	97.9	98.1	99.2	99.4	100.0	99.2
Татварын орлого	84.2	84.3	84.7	81.6	86.1	84.1
Орлогын албан татвар	26.4	17.6	18.5	17.4	19.7	18.3
Нийгмийн даатгалын орлого	10.9	13.1	14.6	14.5	17.4	15.0
Хөрөнгийн албан татвар	0.4	0.9	1.2	1.2	1.4	1.2
Нэмэгдсэн өртгийн албан татвар	20.4	26.1	24	21.7	17.4	22.1
Онцгой албан татвар	7.8	6.3	7.5	7.2	9.9	7.8
Тусгай зориулалтын орлого	0.6	0.2	0.2	0.2	0.2	0.2
Гадаад үйл ажиллагааны орлого	6.7	6.6	6.4	5.6	5.4	6.0
Бусад татвар, төлбөр, хураамж	10.9	13.4	12.4	13.7	14.7	13.6
Татварын бус орлого	13.8	13.8	14.5	17.7	13.9	15.1
Нийтлэг татварын бус орлого	12.9	13.0	14.4	17.3	12.3	14.4
Хөрөнгийн орлого	0.2	0.3	0.1	0.4	0.9	0.4
Тусламжийн орлого	0.6	0.5	0.0	0.0	0.7	0.3


\* Урьдчилсан гүйцэтгэл

Улсын нэгдсэн төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 2012 онд 29.1 хувь, 2013 онд 31.2 хувь, 2014 онд 28.4 хувь, 2015 онд 25.8 хувь болж, 2012 оныхоос 3.9 пунктээр буурчээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрээр авч үзвэл, 2012-2015 онд 81.6-86.1 хувь нь татварын орлогоос, 13.8-17.7 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна. Татварын орлогын эзлэх хувь 2015 онд 84.1 болж, 2014 оныхоос 2.0 пунктээр буурсан бол татварын бус орлогынх 15.1 болж, 1.2 пунктээр өсчээ.

Татварын орлогын ДНБ-д эзлэх хувь 2012 онд 25.0 байсан бол 2015 онд 22.2 болж, 2012 оныхоос 2.8 пунктээр буурсан байна.

**Зураг 12.1 Татварын орлогын ДНБ-д эзлэх хувиар, 2012-2015**



\* Урьдчилсан гүйцэтгэл

Улсын нэгдсэн төсвийн орлого нэмэгдсэнээс төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээ өссөн байна. Төсвийн нийт зарлага, цэвэр зээлийн дүн ДНБ-д эзлэх хувь 2012 онд 35.9 хувь байсан бол 2015 онд 30.8 хувь болж, 2012 оныхоос 5.1 пунктээр буурчээ. ДНБ, (оны үнээр) 2015 онд 2012 оныхоос 38.8 хувиар өсч, мөн хугацаанд төсвийн нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 19.1 хувиар нэмэгдсэн байна.

### XIII. СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТРИЙН САН

#### Хүснэгт 12.3 Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээл, тэрбум төг, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015 оны дундаж	2012-2015* оны дундаж % 2008-2011 оны дундаж
<b>Нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ</b>	<b>3 169.0</b>	<b>5 993.8</b>	<b>6 164.7</b>	<b>7 144.6</b>	<b>7 136.9</b>	<b>6 610.0</b>	<b>208.6</b>
Нийт зарлага	2 945.8	5 929.5	6 043.3	7 064.4	7 087.9	6 531.3	221.7
Урсгал зардал	2 260.0	4 404.1	4 552.6	5 293.4	5 749.9	5 000.0	221.2
Бараа, ажил үйлчилгээний зардал	1 179.9	2 052.4	2 391.2	2 652.5	2 821.1	2 479.3	210.1
Хүү	32.3	125.9	270.4	500.4	731.1	406.9	1 259.8
Татаас, урсгал шилжүүлэг	1 047.8	2 225.7	1 891.0	2 140.6	2 197.7	2 113.7	201.7
Хөрөнгийн зардал	685.8	1 525.4	1 490.7	1 771.1	1 338.0	1 531.3	223.3
Дотоод эх үүсвэрээр	653.9	1 427.9	1 236.6	1 518.0	1 131.4	1 328.5	203.2
Гадаад эх үүсвэрээр	31.9	97.5	254.1	253.1	206.6	202.8	635.7
Цэвэр зээл	223.2	64.3	121.3	80.1	49.1	78.7	35.3

\* Урьдчилсан гүйцэтгэл

Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүнд урсгал зардал 2015 онд 80.6 хувь, үүний дотор бараа, үйлчилгээний зардал 39.5 хувь, хүүгийн зардал 10.2 хувь, татаас, шилжүүлэг 30.8 хувийг эзэлж байна. Хөрөнгийн зардалд 2012-2015 онд жилд дунджаар 1531.3 тэрбум төг зарцуулсан нь 2008-2011 оныхоос 845.5 тэрбум төг буюу 2.2 дахин нэмэгджээ.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын бүтцийг авч үзвэл, 2012-2015 онд жилд дунджаар 2008-2011 оныхоос урсгал зардал 4.3 пункт, хөрөнгийн зардал 1.6 пунктээр өсч, цэвэр зээл 5.8 пунктээр буурчээ. Урсгал зардлын төсвийн нийт зарлагад эзлэх хувь 2015 онд 2014 оныхоос 6.5 пункт, бараа, ажил үйлчилгээний зардал 2.4 пункт, хүүгийн зардал 3.2 пункт, татаас, урсгал шилжүүлэг 0.8 пунктээр өсч, хөрөнгийн зардал 6.1 пункт, дотоод эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгийн зардал 5.3 пункт, гадаад эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалт 0.6 пункт, цэвэр зээлийн эзлэх хувийн жин 0.4 пунктээр буурсан байна.

#### Хүснэгт 13.4 Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээл, дүнд эзлэх хувиар, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015 оны дундаж
<b>Нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Нийт зарлага	93.0	98.9	98.0	98.9	99.3	98.8
Урсгал зардал	71.3	73.5	73.8	74.1	80.6	75.6
Бараа, ажил үйлчилгээний зардал	37.2	34.2	38.8	37.1	39.5	37.5
Хүү	1.0	2.1	4.4	7.0	10.2	6.2
Татаас, урсгал шилжүүлэг	33.1	37.1	30.7	30.0	30.8	32.0
Хөрөнгийн зардал	21.6	25.4	24.2	24.8	18.7	23.2
Дотоод эх үүсвэрээр	20.6	23.8	20.1	21.2	15.9	20.1
Гадаад эх үүсвэрээр	1.0	1.6	4.1	3.5	2.9	3.1
Цэвэр зээл	7.0	1.1	2.0	1.1	0.7	1.2

\* Урьдчилсан гүйцэтгэл

Улсын нэгдсэн төсөв 2012-2015 онд 224.6-1163.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

#### Хүснэгт 13.5 Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төг, 2012-2015

	2008-2011 оны дундаж	2012	2013	2014	2015*	2012-2015 оны дундаж
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-307.4	-1 130.7	-224.6	-868.0	-1 163.2	-846.6

\* Урьдчилсан гүйцэтгэл



### XIII. Статистикийн бизнес регистрийн сан

Үндэсний статистикийн байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны тооллогын үр дүнд үндэслэн статистикийн зориулалтаар Статистикийн бизнес регистрийн санг байгуулсан бөгөөд тус улсын аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, төлөв, тэдгээрийн өөрчлөлтийг улирал дутмын статистик мэдээлэлд нэгтгэж гаргаж байсан. Улмаар ААНБ-ын 2006, 2011, 2016 оны тооллогын дүн, Хуулийн этгээдийн бүртгэлийн газар, Гааль, татварын ерөнхий газар болон бусад байгууллагын мэдээллүүдийг харилцан уялдуулж холбогдох баяжилт, нэгдсэн судалгаагаар байнга өргөжүүлж байна.

**Хүснэгт 13.1. Статистикийн бизнес регистрийн сан (СБРС)-д бүртгэлтэй ААНБ-ын тоо, үйл ажиллагааны төлөв, байдал, 2012-2015**


Хугацаа	СБРС-д бүртгэлтэй ААНБ-ын тоо	Үйл ажиллагаа явуулж байгаа	Үйл ажиллагаа явуулаагүй байгаа	эхлээгүй	түр зогсоосон	бүрэн зогссон	бусад
2012	90 540	51 940	38 600	11 075	20 349	720	6 456
2013	99 603	54 929	44 674	14 948	22 706	706	6 314
2014	113 602	59 843	53 759	14 266	34 571	1 750	3 172
2015	126 560	64 301	62 259	21 124	36 650	1 626	2 859

**Жич:**

Түр зогсоосон төлөвт 1 жил 6 сараас доош хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй боловч цаашид үйл ажиллагаагаа явуулах зорилго бүхий аж ахуйн нэгж, байгууллагыг;


Бүрэн зогссон төлөвт 1 жил 6 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй, тухайн орон нутгийн татварын байгууллагад татан буугдахаар бүртгээгдсэн аж ахуйн нэгж, байгууллагуудыг оруулж байна.

**Зураг 13.1. Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ын тоо, үйл ажиллагааны төлөв байдлаар, 2012-2015**



### XIII. СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТРИЙН САН

**Зураг 13.2. Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ын тоо үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, 2012-2015**



Тайлбар: Бусад шалтгаанд хаяг тодорхойгүй, олдохгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7-р зүйлийн 1 дэх хэсгийн “з” буюу “Аж ахуйн нэгжийн тооллогыг 5 жил тутам явуулах тухай” заалт, Засгийн газрын энэ оны 163 тоот тогтоолын дагуу Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газраас тус улсын нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллагуудын ээлжит тооллогыг 2016 оны 4-р сард явууллаа.

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогод 2016 оны 4-р сарын 1-ний өдрөөс өмнө байгуулагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулж (Хүснэгт 2), статистикийн бизнес регистрийн үзүүлэлтүүд, Дотоодын нийт бүтээгдэхүүн, нөөц ашиглалтын хүснэгт, үндэсний тооцооны системийн хөрөнгийн дансны болон хөрөнгө оруулалтын статистик, улмаар төрийн бус байгууллагын статистик үзүүлэлтүүдээр ААНБ-уудын мэдээллийн шалгалт, нэгтгэл хийгдэж байна.

**Хүснэгт 13.2. Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын хамрагдалт, 2012-2015**

Д/д	Нийслэл, аймаг	Тооллогын хүрээ	Хамрагдалтын дүн	Татан буугдсан	Бусад*
1	Улаанбаатар	99 705	77 874	1 043	2 453
2	Дорнод	1 680	1 632	37	9
3	Сүхбаатар	964	942	16	6
4	Хэнтий	1 439	1 394	3	42
5	Төв	1 812	1 793	1	7
6	Говьсүмбэр	438	434	2	2
7	Сэлэнгэ	2 811	2 659	111	40
8	Дорноговь	1 336	1 213	91	32
9	Дархан-Уул	3 531	3 116	127	288
10	Өмнөговь	1 958	1 836	23	98
11	Дундговь	927	887	38	2
12	Орхон	3 930	3 677	35	218
13	Өвөрхангай	1 522	1 510	12	0
14	Булган	1 384	1 283	49	52
15	Баянхонгор	1 456	1 390	38	28
16	Архангай	1 339	1 304	7	28
17	Хөвсгөл	1 946	1 872	45	29
18	Завхан	1 766	1 745	5	16
19	Говь-Алтай	961	924	11	25
20	Баян-Өлгий	1 684	1 570	107	7
21	Ховд	2 214	2 081	106	27
22	Увс	1 772	1 652	85	35
	<b>ДҮН</b>	<b>136 575</b>	<b>112 788</b>	<b>1 992</b>	<b>3 444</b>

\* Хаяг, утас тодорхойгүй учраас олдохгүй байгаа

Давхар бүртгэлтэй

Нууцын зэрэглэлтэй байгууллага

Бусад



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2012	2013	2014	2015
Монгол Улсын хүн ам, оны эцэст, мян.хүн	2 867.7	2 930.3	2 995.9	3 057.8
1000 хүнд ногдох ердийн цэвэр өсөлт	19.7	21.6	22.4	21.3
Өрхийн тоо, оны эцэст, мян.өрх	768.3	794.1	823.4	859.1
Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хичээлийн жилийн эхэнд, мян.хүн	719.6	716.3	728.9	742.5
Эдийн засгийн идэвхтэй хүн ам, мян.хүн	1 151.1	1 198.3	1 206.6	1 243.9
Ажиллагчид	1 056.4	1 103.6	1 110.7	1 151.2
Ажилгүй иргэд	94.7	94.7	95.9	92.7
Бүртгэлтэй ажилгүй иргэд, мян.хүн	35.8	42.8	37.0	32.8
Ажилгүйдлийн түвшин, хувиар	8.2	7.9	7.9	7.5
ДНБ, оны үнээр, тэрбум төг	16 688.4	19 174.2	22 227.0	23 166.8*
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг	12 853.4	14 350.7	15 482.3	15 837.7*
ҮНО, оны үнээр, тэрбум төг	15 399.6	18 091.3	20 420.0	21 048.4*
ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг	11 860.7	13 540.2	14 223.6	14 389.5*
1 хүнд ногдох ДНБ, оны үнээр, мян.төг	5 876.8	6 614.1	7 501.3	7 648.9*
1 хүнд ногдох ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг	4 526.3	4 950.2	5 225.0	5 229.1*
1 хүнд ногдох ҮНО, оны үнээр, мян.төг	5 422.9	6 240.5	6 891.4	6 949.5*
1 хүнд ногдох ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг	4 176.8	4 670.6	4 800.2	4 750.9*
Инфляцийн жилийн түвшин, оны эцэст	14.0	12.5	11.0	1.9
Мөнгө M2, тэрбум төг	7 613.7	9 454.9	10 635.8	10 050.2
Төгрөгийн ам.доллартай харьцах, жилийн дундаж ханш	1 359.4	1 525.7	1 818.3	1 970.7
Улсын нэгдсэн төсөв, тэрбум төг				
Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж	4 957.8	5 986.9	6 316.5	5 976.1*
Нийт зарлага, цэвэр зээл	5 993.8	6 164.7	7 144.6	7 136.9*
Төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төг	-1 036.0	- 177.8	- 828.1	-1 160.8*
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь	29.1	31.2	28.4	25.8*
Улсын нэгдсэн төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь	35.9	32.1	32.1	30.8*
Төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-6.8	-1.1	- 3.7	- 5.0*
Хөрөнгө оруулалт, тэрбум төг	9 395.8	6 577.9	6 042.5	4 754.6
Гадаад худалдаа, сая ам.долл				
Экспорт	4 384.7	4 269.1	5 774.3	4 669.3
Импорт	6 738.4	6 357.8	5 236.7	3 797.5
Гадаад худалдааны тэнцэл, сая ам.долл	-2 353.7	-4 442.5	537.7	871.8*
Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, оны үнээр, тэрбум төг	9 821.3	10 443.7	14 402.9	13 734.6*
Уул уурхай, олборлолт	5 787.0	6 099.7	9 271.3	8 685.7*
Боловсруулах үйлдвэрлэл	3 012.1	3 212.8	4 042.7	3 741.1*
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	824.1	904.5	842.7	1 024.6*
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	198.1	226.7	246.2	283.1*
Нэг өрхийн сарын дундаж орлого, мян.төг	820.0	959.2	1 080.1	1 047.2
Нэг өрхийн сарын дундаж зарлага, мян.төг	820.3	961.7	1 076.6	1 064.8
Мал, мян.толгой	40 920.9	45 144.3	51 982.6	55 979.8
Хураасан ургац, мян.т				
Үр тариа	479.3	387.0	518.8	216.3
Төмс	245.9	191.6	161.5	163.8
Хүнсний ногоо	98.9	101.8	104.8	72.3
Барилга угсралт, их засварын ажил, тэрбум төг	1 034.1	1 845.9	2 582.8	2 359.4
Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа, сая т	50.6	42.4	44.6	35.8
Бүх төрлийн тээврээр зорчигчид, давхардсан тоогоор, сая хүн	318.0	307.9	344.2	260.0
Дотоод худалдааны салбарын нийт борлуулалт, тэрбум төг	13 350.0	14 456.4	16 980.5	17 698.7*
Бөөний худалдаа	7 668.5	7 078.6	7 809.7	7 683.2*
Жижиглэн худалдаа	5 681.5	7 377.8	9 170.8	10 015.5*

Тайлбар: \* Урьдчилсан гүйцэтгэл



## Дүгнэлт

### 1. ХҮН АМ, НИЙГМИЙН БАЙДАЛ

- Монгол Улсын хүн ам 2015 оны эцсийн байдлаар 3057.8 мянга болж, өмнөх оныхоос 61.9 мянган хүнээр нэмэгдэж, жилийн дундаж өсөлт 2.06 хувь байна. Орхон аймгийн хүн амын өсөлтийн хувь 6.68 буюу хамгийн өндөр байгаа бол Увс аймгийнх 6.56, Баян-Өлгий аймгийнх 5.29 хувь байна.
- Монгол Улсын хүн амын 68.6 хувь буюу 2096.2 мян.хүн 2015 оны байдлаар хот, тосгонд амьдарч байгаа нь 2012 оныхоос 169.6 мянган хүн буюу 8.8 хувиар өсчээ.
- Сүүлийн жилүүдэд нийт хүн амын дунд 15-64 насны хүн амын эзлэх хувь нэмэгдэж, 2015 оны эцсийн байдлаар 66.6 хувийг 15-64 насны хүн ам, 29.6 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 3.8 хувийг 65, түүнээс дээш насныхан эзэлж байна.
- Монгол Улсын хүн амын 49.2 хувийг эрэгтэйчүүд, 50.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж, хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 96.7 байна.
- Улсын хэмжээнд 2015 оны байдлаар 859.1 мянган өрх, түүний 67.4 хувь нь хотод, 32.6 хувь нь хөдөөд байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 3.5 хүн ногдож байна.
- Төрөлтийн түвшин 2006 оныхоос өсч, 1000 хүнд ногдох төрөлт 2012 онд 26.0, 2014 онд 28.0 хүрч байснаа 2015 онд 27.1 болж, өмнөх оныхоос 0.9 пунктээр буурчээ. Нас баралтын ерөнхий коэффициент 2006 оноос тогтмол буурч 2012 онд 6.3, 2014 онд 5.6 болж буурч, 2015 онд 0.2 пунктээр өсч 5.8 болсон байна.
- Нийт 17.6 мянган хос 2015 онд гэрлэлтээ бүртгүүлж, 3.9 мянган гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 2.2 мянган хүүхэд үрчлүүлсэн байна. Гэрлэлт өмнөх оныхоос 1.5 хувь, гэр бүл цуцлалт 3.3 хувиар, үрчлүүлсэн хүүхэд 25.9 хувиар өсөв.
- Улсын хэмжээгээр өнчин хүүхэд 2015 онд 37.9 мянга болж, 2012 оныхоос 6.2 хувь, 2013 оныхоос 4.1 хувь, 2014 оныхоос 2.9 хувиар буурчээ. Нийт өнчин хүүхдийн 3.9 мянга буюу 10.2 хувь нь бүтэн өнчин, 34.1 мянга буюу 89.8 хувь нь хагас өнчин хүүхэд байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2015 онд 101.7 мянга болж, нийт хүн амын 3.3 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2012 оныхоос 10.3 хувь, 2013 оныхоос 5.6 хувь, 2014 оныхоос 2.2 хувиар өсчээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрлөөр нь авч үзвэл 40.8 хувь нь төрөлхийн, 59.2 хувь нь олдмол, үүнээс 74.8 хувь нь ердийн өвчнөөс, 9.6 хувь нь ахуйн ослоос, 9.2 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөс, 3.8 хувь нь зам тээврийн ослоос, 2.6 хувь нь үйлдвэрийн ослоос шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2015 онд 56.9 хувь, улсын хэмжээнд 1152.2 мянган хүн ажил эрхэлж байгаагийн 28.5 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 15.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, тус бүр 7.7 хувь нь барилга, 7.7 хувь нь боловсрол, 7.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 6.3 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа болон 27.2 хувь нь эдийн засгийн бусад салбарт ажиллаж байна.
- Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд ажилгүйдлийн түвшин буурч байгаа боловч эдийн засгийн идэвх төдийлөн нэмэгдэхгүй байна. Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарт ажиллагчид 2008-2011 онд 2004-2007 оны дунджаас 4.2 хувиар нэмэгдэж байсан бол 2012-2015 оны дундаж ажиллагчид өмнөх 4 жилийн

дунджаас 7.3 хувиар өсчээ. Сүүлийн 4 жилд эдийн засгийн идэвхтэй хүн ам 7.1 хувиар нэмэгдсэн нь өмнөх 4 жилийн дундаж өсөлтөөс 2.6 пунктээр бага байна.

- Ажиллах хүчний судалгааны 2015 оны дүнгээр улсын хэмжээнд 92.7 мянган ажилгүй иргэд байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажилгүй иргэд 2015 оны 12 дугаар сарын эцэст 32.8 мянга болсны 17.7 мянга нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1.1 хувийг магистр, доктор, 28.9 хувийг дипломын болон бакалаврын, 6.3 хувийг тусгай мэргэжлийн дунд, 6.5 хувийг техникийн болон мэргэжлийн, 47.3 хувийг бүрэн дунд, 9.9 хувийг суурь, бага боловсролтой болон боловсролгүй иргэд эзэлж байгаа бөгөөд 61.3 хувь нь 15-34 насны залуучууд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэд 2008-2011 онд жилд дунджаар 40.9 мянга байсан бол 2012-2015 оны дунджаар 37.1 мянга болж буурсан байна.
- Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 78 дугаар тогтоолоор 2012 онд 38.2 хувь, 23.0 хувиар 2 удаа, 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолоор 15.0 хувиар нэмэгдүүлсэн, мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2013 онд 36.8 хувиар нэмэгдүүлсэн нь дундаж цалин хөлсний өсөлтөд нөлөөлсөн байна.
- Нэг өрхийн сарын дундаж нийт орлого 2015 онд 1047.3 мян.төг болж, 2012 оныхоос 27.7 хувиар өссөн боловч өмнөх оныхоос 3.0 хувиар буурчээ. Өрхийн сарын дундаж нийт орлого 2015 онд өмнөх оныхоос 3.0 хувиар буурахад мөнгөн орлого 3.0 хувиар, үүнд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 17.5 хувиар буурсан нь нөлөөлсөн байна. Сүүлийн 4 жилийн дунджийг 2008-2011 оны дундажтай харьцуулахад өрхийн сарын дундаж нийт орлого 2.2 дахин нэмэгдсэн байна.
- Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага 2015 онд 1064.8 мян.төг болж, 2012 оныхоос 29.8 хувиар өсч, өмнөх оныхоос 1.1 хувиар буурчээ. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2012-2015 онд өмнөх 4 жилийн дунджаас 2.2 дахин өсөхөд хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 2.5 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.
- Монгол Улсад ядуурлын түвшин буюу ядуурлын хамралтын хүрээ 2014 оны байдлаар 21.6 хувь болсон бөгөөд 634.0 мянга орчим хүн ядууралд өртсөн байна. Өөрөөр хэлбэл, 100 хүн тутмын 22 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна. Ядуурлын хамралтын хүрээ 2012 онд 27.4 хувь байснаа хотод ядуурал 23.3 хувиас 18.8 хувь болж 4.5 пунктээр, хөдөөд 35.4 хувиас 26.4 хувь болж 9.0 пунктээр буурсан байна.
- Нийт 127 цэцэрлэгийн барилгыг 2012-2015 онд шинээр ашиглалтад оруулж, хүүхдийн цэцэрлэгийн хүчин чадлыг 12735 ороор нэмэгдүүлэв. Мөн хугацаанд 296 гэр цэцэрлэгийг шинээр байгуулсан байна.
- Бага боловсролын хамран сургалтын бохиржин 2015 онд 2012 оныхтой харьцуулахад 1.4 пунктээр өсч 99.3 хувь, суурь боловсролын хамран сургалтын бохир жин 2.6 пунктээр өсч 96.9 хувь боллоо.
- Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох сурагчийн тоо 2008-2011 онд дунджаар 19.8 байсан бол 2012-2015 онд дунджаар 18.5 болж цөөрсөн байна.
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тоо 2012-2015 оны дунджийг 2008-2011 оныхтой харьцуулахад 14-өөр буюу 21.9 хувиар нэмэгдсэн байна.
- Их, дээд сургууль, коллежид 2012-2015 онд дунджаар 172.6 мянган хүн суралцаж байгаа нь 2008-2011 оны дунджаас 3.3 хувиар нэмэгджээ.

- Улсын хэмжээнд 2015 оны байдлаар төрийн өмчийн 32, төрийн бус өмчийн 6 эрдэм шинжилгээний байгууллага ажиллаж байна.
- Улсын хэмжээгээр 2015 онд эрүүл мэндийн 3245 байгууллагад 47429 ажиллагчид ажиллаж, эмнэлэг 21720 орны хүчин чадалтай боллоо.
- Монгол Улсын Засгийн газраас “Эх, хүүхдийн эрүүл мэндийн стратеги” (2011-2015)-ийг батлан, амжилттай хэрэгжүүлсний үр дүнд эхийн эндэгдлийн түвшин 2015 онд 25.6, нялхсын эдэгдлийн түвшин 15.0, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 18.0, эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан хувь 99.8 болж, МХЗ-ын 2015 онд дэвшүүлсэн зорилтоо биелүүлсэн байна.
- Эх, хүүхдийн эндэгдлийн түвшинг 2015 оны байдлаар аймаг, нийслэлээр авч үзвэл нялхсын эндэгдлийн түвшин Баруун бүсийн Завхан, Баян-Өлгий, Ховд, Увс, Хангайн бүсийн Хөвсгөл, Баянхонгор, Зүүн бүсийн Сүхбаатар, Хэнтий, Төвийн бүсийн Өмнөговь аймагт улсын дунджаас өндөр байна.
- Манай улсын хүн амын нас баралтыг зонхилох шалтгаанаар авч үзвэл, 1990 онд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 1992 оноос эхлэн одоог хүртэл зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж, хавдар 2-рт, гэмтэл, хордлого ба гадна шалтгаант өвчин 3-рт, амьсгалын тогтолцооны өвчин 4-рт, хоол боловсруулах тогтолцооны өвчин 5-рт орж байна.
- “Халдварт өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөр (2011-2015 он)-ийн шалгуур үзүүлэлт болох 10000 хүн амд ногдох сальмонеллёзоор өвчлөгчид 0.5, А вирүст гепатитаар өвчлөгчид 0.3, гахайн хавдраар өвчлөгчид 0.8, улаануудаар өвчлөгчид 0.2 болж зорилтот түвшиндээ хүрсэн байна. Харин цусан суулга, улаан бурханаар өвчлөгчдийн хувьд зорилтот түвшиндээ хүрээгүй байна.
- Монгол Улс жирэмсэн эмэгтэйчүүд болон 15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ийн халдварын тархалтыг 0.1 хувиас бага түвшинд барих зорилтоо хэрэгжүүлж чадсан ч сүүлийн жилүүдэд манай хүн амын дунд ХДХВ-ын халдварын тохиолдол нэмэгдсээр байна.
- Манай улсын хүн амын дунд халдварт бус өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан болж байгаа өвчлөлүүд 2007 оноос хойш өсөх хандлагатай байна. 2007-2012 он хүртэл өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны 3-рт шээс, бэлгийн тогтолцооны өвчин орж байсан бол 2013-2015 онд зүрх-судасны тогтолцооны өвчин 3-рт эрэмбэлэгдэж байна.
- Нийгмийн даатгалын сангийн орлого 2012-2015 оны дунджаар 1036.5 тэрбум төгрөг болж, 2008-2011 оны дунджаас 1.8 дахин нэмэгдэв. Нийгмийн даатгалд даатгуулагчдын 2012-2015 оны дундаж тоог 2008-2011 оны дундажтай харьцуулахад 1.5 дахин нэмэгдсэн бөгөөд сайн дураар даатгуулагчдын дундаж тоо 2.5 дахин нэмэгджээ. Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 2012-2015 оны дундажийг 2008-2011 оныхтой харьцуулахад 2.1 дахин, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 2.6 дахин, дундаж тэтгэврийн хэмжээ 2.2 дахин нэмэгдлээ.
- Нийгмийн даатгалын сангаас 2015 онд 1198.9 тэрбум төгрөгийг тэтгэвэрт зарцуулсан нь 2012 оныхоос 464.8 тэрбум.төг буюу 63.3 хувиар өссөн байна. Нийгмийн даатгалын сангаас 2012-2015 онд олгосон тэтгэврийн дундаж хэмжээ 2008-2011 оныхоос 565.5 тэрбум.төг буюу 2.5 дахин өслөө.

- Нийгмийн халамжийн сангийн зардал 2012-2015 онд дунджаар 228.3 тэрбум төгрөгт хүрч, 2008-2011 оныхоос 31.6 хувиар нэмэгдсэн байна. Халамжийн сангаас тэтгэвэр авагч нэг хүнд сард ногдох тэтгэвэр 2015 онд 120402 төгрөг, тэтгэмж, тусламж авагч нэг хүнд сард ногдох хэмжээ 43889 төгрөг болж, 2012 оныхтой харьцуулахад халамжийн тэтгэвэр 30320 төг буюу 33.7 хувь, тэтгэмж, тусламж 3569 төг буюу 8.9 хувиар өсчээ.
- Бүртгэгдсэн гэмт хэрэг 2012-2015 онд дунджаар 25.6 мянган болж, 2008-2011 оны дунджаас 5.6 мянга буюу 28.0 хувиар өссөн байна. Сүүлийн 4 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг өсөхөд 2014-2015 онд гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлжээ.
- Гэмт хэрэгт холбогдсон сэжигтнүүдийн 2008-2011 онд 7878 буюу 41.7 хувь нь ял шийтгүүлж байсан бол 2012-2015 онд гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогчдын 8066 буюу 35.6 хувь нь ял шийтгүүлж, нийт сэжигтэн яллагдагчдын дүнд ял шийтгүүлэгчдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 6.1 пунктээр буурсан байна.
- Учирсан хохирлын 2008-2011 онд дунджаар 33.5 хувийг нөхөн төлүүлж байсан бол 2012-2015 онд 45.4 хувийг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэлт өмнөх 4 жилээс 11.9 пунктээр өссөн байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг дунджаар 2012-2015 онд 796 болж, 2008-2011 оны дунджаас 497 буюу 2.7 дахин өссөн байна. Хүчирхийлэлд өртсөн иргэдийн 565 буюу 43.2 хувь нь ажилгүй иргэд байна.
- Анхан шатны шүүхээр 2012-2015 онд 6365 эрүүгийн хэрэг, 34444 иргэний хэрэг, 1173 захиргааны хэрэг шийдвэрлэгдсэн нь 2008-2011 оныхтой харьцуулахад эрүүгийн хэрэг 12.9 хувь, захиргааны хэрэг 2.9 хувиар өсч, иргэний хэрэг 3.5 хувиар буурсан байна.



## 2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

- Манай улсын эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд буурч байгаа хэдий ч ДНБ-ий 2012-2015 оны жилийн дундаж өсөлт өмнөх 4 жилийнхээс 0.8 пунктээр нэмэгдсэн байна. ДНБ-ий жилийн дундаж өсөлт 2008-2011 онд 7.7 хувь байсан бол 2012-2015 онд 8.5 хувь болсон. Эдийн засаг ийнхүү өсөхийн хэрээр нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нэмэгдэж, Дэлхийн банкны атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох ДНБ 2008 -2011 оны дунджаар 2301 ам.доллар байсан бол 2012-2015 онд 4308 ам.долларт хүрч, 1.9 дахин нэмэгдлээ.
- Эдийн засгийн бүтцэд өөрчлөлт гарч, хувийн хэвшлийн эдийн засагт эзлэх байр суурь улам бүр нэмэгдлээ. Өнгөрсөн 4 жилийн дотор хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 11.2 байснаа 13.6 болж, 2.4 пунктээр нэмэгдсэн, харин үйлдвэрлэлийн салбарынх 34.5 байснаа 33.7 хувь, үйлчилгээний салбар, түүний дотор худалдаа болон тээврийн салбарынх 25.1 хувиас 21.8 хувь болж, 3.3 пунктээр буурсан байна. Өнгөрсөн хугацаанд хувийн хэвшлийн эдийн засагт оруулж буй хувь хэмжээ нэмэгдэж, 80.8 хувьд хүрчээ. Боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хувь дэлхийн дунджаар 15.9 хувь, бага болон дунд орлоготой орнуудынх 20.5 хувь, Ази, номхон далайн орнуудынх 21.9 хувь байхад манай улсын хувьд боловсруулах аж үйлдвэрийн ДНБ-д эзлэх хувь дөнгөж 8.0 байна.
- Хөрөнгийн хуримтлалын ДНБ-д эзлэх хувь 2008-2011 онд 44.0 хувь байсан бол 2012 -2015 онд 42.7 хувь болж 1.3 пунктээр буурчээ.
- Гадаад худалдааны нийт эргэлт өнгөрсөн 4 жилд 41.2 тэрбум ам. долларт хүрч, 2015 онд 8.5 тэрбум ам. долларын бараа эргэлт хийсэн нь 2011 оныхтой харьцуулахад 25.8 хувиар буурсан байна. Гадаад худалдааны нийт эргэлтийн дийлэнх хувь хэмжээ хөрш орнуудад ногдож байгаа бөгөөд өнгөрсөн 4 жилд БНХАУтай хийсэн худалдааны эзлэх хувь 9.0 пунктээр нэмэгдэж, ОХУынх 0.4 пунктээр буурсан байна.
- Гадаад худалдаанд импортын эзлэх хувь давамгайлж, харин экспортын барааны нэр төрөл цөөрөх хандлага ажиглагдаж байна. Манай улсын экспортод нүүрсний экспорт тэргүүлэх болж, зэсийн баяжмал, төмрийн хүдрийнх нэмэгдэж, экспортын орлогын дийлэнх хувийг бүрдүүлэгч гол бүтээгдэхүүн болж байна. Манай улс 2008-2011 оны дүнгээр 49.3 сая тонн нүүрс экспортоор гаргаж байсан бол 2012-2015 онд 73.3 сая тонн болж, 48.6 хувиар нэмэгджээ. Импортын барааны дийлэнх хувийг уул уурхайн зориулалттай машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг, эд анги, хүнд даацын ачааны болон суудлын авто машин, шатахууны импорт эзэлж байна. Харин цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тос зэрэг дотоодын хэрэгцээгээ гаднаас бүрэн хангадаг хүнсний зарим бүтээгдэхүүнийг цөөн орноос импортолж байна.
- Инфляци 2008-2011 онд жилд дунджаар 12.4 хувиар нэмэгдэж байсан бол 2012 2015 онд дунджаар 9.9 хувиар нэмэгдсэн нь өмнөх 4 жилийн дунджаас 2.5 пунктээр буурсан байна. Инфляцийн өсөлт 2012 онд 14.0 хувь байсан бол, 2015 онд 1.9 хувь болж, 2009 оноос хойш анх удаа 1 оронтой тоонд хүрсэн байна. Өмнөх жилүүдтэй адил өрхийн зарлагад өндөр хувийн жин эзэлдэг цөөн нэрийн хүнсний барааны үнийн өсөлт инфляцид нөлөөлсөн хэвээр байна.
- Эдийн засаг тэлэхийн хэрээр мөнгөний нийлүүлэлт мөн нэмэгдэж, 2015 оны эцэст 10.4 их наяд төгрөгт хүрч, бүтцийн хувьд 2012 оныхтой харьцуулахад банкнаас гадуурх мөнгө жил дараалан буурч, харин төгрөгийн хадгаламж болон гадаад



валютын хадгаламж хувийн жин өссөн байна. Мөнгөний нийлүүлэлтийн дийлэнх хувийг иргэд, байгууллагын хадгаламжийн өсөлтөөр хангасан хэвээр байна.

- Гадаад валютын цэвэр албан нөөц 2012 оныхоос 3.1 дахин буурч, 2015 оны эцэст 1323.1 сая ам.доллар болсон байна.
- Төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2008-2011 онд харьцангуй тогтвортой байсан бол сүүлийн 4 жилд эрчимтэй суларч төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 2015 онд 2012 оныхоос 45.0 хувь, 2014 оныхоос 8.4 хувиар суларчээ.
- Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн сулралтад гадаадын хөрөнгө оруулалт багассан нь голлон нөлөөлжээ.
- Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламж 2008-2011 онд нийтдээ 11687.5 тэрбум төг байсан бол 2012-2015 онд 23237.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх 4 жилийнхээс 98.8 хувиар нэмэгджээ. Энэ хугацаанд улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 12676.1 тэрбум төгрөг байснаа 26440.0 тэрбум төгрөгт хүрч, 2.1 дахин нэмэгдсэн байна.
- Улсын төсвөөс 2008-2011 онд нийтдээ 2743.2 тэрбум төгрөгөөр хөрөнгийн зардлыг санхүүжүүлж байсан бол 2012-2015 онд 6125.2 тэрбум төг болж, өмнөх 4 жилийнхтэй харьцуулахад 2.2 дахин нэмэгджээ. Хөрөнгийн зардлын нийт зарлагад эзлэх хувь 2012-2015 онд 23.2 хувь болж, 1.6 пунктээр өсчээ.
- Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ДНБ-д эзлэх хувь 2011 онд -4.0 хувь байсан бол 2015 онд -5.0 хувь болж, -1 пунктээр нэмэгдлээ.